

АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ТОГТОЛЦООНЫ ЦАХИМЖУУЛАЛТЫН БЭЛЭН БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Захиалагч: AMEP Australia Mongolia Extractives Program

Гүйцэтгэгч: ТУС Солюшн ХХК

Улаанбаатар хот
2021 он

АГУУЛГА

1. ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ	3
2. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР	6
3. УДИРТГАЛ	8
4. НЭГДСЭН ДҮГНЭЛТ	11
4.1 Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны цахимжуулалтын бэлэн байдлын үнэлгээний дүгнэлт	11
4.2 Олон улсын ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоо, цахимжуулалтын түвшний дүгнэлт	13
4.3 Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог дижиталжуулахад E-MONGOLIA, TENDER.MN, CMCS программыг ашиглах боломжийн судалгааны дүгнэлт	17
5. НЭГТГЭСЭН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ	20
6. ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ТОГТОЛЦООНЫ ЦАХИМЖУУЛАЛТЫН БЭЛЭН БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ	22
6.1 АМГТГ-н Кадастрын хэлтсийн системийн төлөв байдлын оношилгоо	24
6.2 Албан тушаалын тодорхойлолтын хэв шинжүүдийг бүрдүүлсэн түвшин	56
6.3 Хайгуулын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтын журмын чанарын түвшин	59
6.4 Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны цахимжуулалтын бэлэн байдлын үнэлгээний дүгнэлт	63
7. ОЛОН УЛСЫН ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ТОГТОЛЦОО, ЦАХИМЖУУЛАЛТЫН БАЙДАЛ	65
7.1 Австрали улсын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоо, цахимжуулсан арга зам	65
7.1.1 Баруун Австрали мужийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоо	65
7.1.2 Баруун Австрали мужийн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог цахимжуулсан арга зам, програмын тухай мэдээлэл	67
7.1.3 Баруун Австрали мужийн хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны цахимжуулалтын үнэлгээ	72
7.2 Канад улсын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоо, цахимжуулсан арга зам	74
7.2.1 Саскачеван мужийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоо	74
7.2.2 Саскачеван мужийн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог цахимжуулсан арга зам, программын тухай мэдээлэл	76
7.2.3 Канадын Саскачеван мужийн ашигт малтмалын зөвшөөрлийн бүртгэлийн журмын цахимжуулалтын үнэлгээ	82
7.3 Орос Холбооны Улсын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоо, цахимжуулсан арга зам	84
7.3.1 ОХУ-н ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоо	84
7.3.2 ОХУ-н ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог цахимжуулсан арга зам, программын тухай мэдээлэл	86
7.3.3 ОХУ-н ашигт малтмалын зөвшөөрлийн бүртгэлийн журмын цахимжуулалтын үнэлгээ	90
7.4 Олон улсын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоо, цахимжуулалтын байдлын судалгааны дүгнэлт	93

8. ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ТОГТОЛЦООГ ДИЖИТАЛЖУУЛАХАД EMONGOLIA, TENDER.MN, CMCS ПРОГРАММЫГ АШИГЛАХ БОЛОМЖИЙН СУДАЛГАА	97
8.1 Emongolia.mn программын судалгаа	98
8.1.1 E-mongolia программын ерөнхий мэдээлэл	98
8.1.2 Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог E-mongolia системтэй уялдуулан дижиталжуулах боломж	101
8.1.3 Ижил төстөй программууд болон E-mongolia программуудын уялдааны зураглал, ажиллах зарчим	103
8.2 CMCS программын судалгаа	106
8.3 Tender.mn программын судалгаа	113
8.4 Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог дижиталжуулах арга зам	118
9. АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	120
10. ХАВСРАЛТ	121

1. ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Хүснэгтийн жагсаалт

- Хүснэгт 1: Нэр томъёоны тайлбар
Хүснэгт 2: Байгууллагын системийн төлөв байдлын түвшингийн ангилал
Хүснэгт 3: Цахимжуулалтын бэлэн байдлын индексийн ангилал
Хүснэгт 4: Байгууллагын системийн төлөв байдалд оношилгоо хийх зорилгоор цуглуулсан мэдээллийн бүртгэл
Хүснэгт 4: Цахимжуулалтын бэлэн байдлын индекс
Хүснэгт 5: Системийн төлөв байдлын оношилгооны дүн
Хүснэгт 6: Байгууллагын системийн төлөв байдалд оношилгоо хийх зорилгоор цуглуулсан мэдээллийн бүртгэл
Хүснэгт 7: Системийн төлөв байдлын оношилгооны дүн
Хүснэгт 8: Дэд тогтолцоонуудын уялдааны түвшин
Хүснэгт 9: Дэд тогтолцоонуудын уялдааны ангилал
Хүснэгт 10: ЗТ-ын дэд тогтолцооны оношилгооны дүн
Хүснэгт 11: Зорилгын тайллын дэд тогтолцоонуудын доголдлыг арилгах шийдлүүдийн зөвлөмж
Хүснэгт 12: МУ-ын дэд тогтолцооны оношилгооны дүн
Хүснэгт 13: МУ-ын дэд тогтолцооны доголдлыг арилгах шийдлүүдийн зөвлөмж
Хүснэгт 14: ҮГ-ийн дэд тогтолцооны оношилгооны дүн
Хүснэгт 15: Үүргийн гүйцэтгэлийн дэд тогтолцооны доголдлыг арилгах шийдлүүдийн зөвлөмж
Хүснэгт 16: ЭХ-ны дэд тогтолцооны оношилгооны дүн
Хүснэгт 17: Эргэх холбооны дэд тогтолцооны доголдлыг арилгах шийдлүүдийн зөвлөмж
Хүснэгт 18: ХҮ-ийн дэд тогтолцооны оношилгооны дүн
Хүснэгт 19: Хэмжүүр үзүүлэлтийн дэд тогтолцооны доголдлыг арилгах шийдлүүдийн зөвлөмж
Хүснэгт 20: Ажилтнуудад тулгарч буй нийтлэг асуудлууд
Хүснэгт 21: Суурь ойлголтын зөрүүний индексийн үнэлгээний шалгуурын ангилал
Хүснэгт 22: Байгууллагын үйл ажиллагаанд нийтлэг хэрэглэгддэг суурь ойлголтын зөрүүний индекс
Хүснэгт 23: Дүрэм, журамд туссан суурь ойлголтын зөрүүний индекс
Хүснэгт 24: Үзэл баримтлалд туссан суурь ойлголтын зөрүүний индекс
Хүснэгт 25: Ажилтнууд зөрүүтэй ойлголттой байгаа асуудлын жишээ
Хүснэгт 26: Хүний суурь хэрэгцээний матриц
Хүснэгт 27: АТТ-ын хэв шинжүүдийг бүрдүүлсэн түвшинг тодорхойлох матриц
Хүснэгт 28: Журамд заагдсан үүргүүдийн чанарын түвшний үнэлгээ
Хүснэгт 29: Цахимжуулалтын бэлэн байдлын индексийн ангилал
Хүснэгт 30: Цахимжуулалтын бэлэн байдлын индекс
Хүснэгт 31: Баруун Австралийн хайгуулын тусгай зөвшөөрөл олгох нөхцөл
Хүснэгт 32: Канад улсын Саскачеван мужийн ашигт малтмалын зөвшөөр олгох нөхцөл
Хүснэгт 33: Emongolia программын дэлгэрэнгүй мэдээлэл
Хүснэгт 34: CMCS программын дэлгэрэнгүй мэдээлэл
Хүснэгт 35: www.tender.gov.mn сайтын дэлгэрэнгүй мэдээлэл

Зургийн жагсаалт

- Зураг 1: Цахимжуулалтын бэлэн байдлын түвшинг үнэлэх хэмжүүр үзүүлэлтүүд
- Зураг 2: Цахимжуулалтын бэлэн байдлын түвшинг үнэлэх аргачлал
- Зураг 3: Олон улсын болон Монгол улсын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны цахимжуулалтын бэлэн байдал болон цахимжуулсан байдлын дүн
- Зураг 4: Асуудлууд ба шалтгаануудын логик холбоос
- Зураг 5: Суурь ойлголтын зөрүүний индекс
- Зураг 6: Хайгуулын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтын журмын үүргүүдийн урсгал
- Зураг 7: Цахимжуулсан байдлын үнэлгээ
- Зураг 8: Баруун Австралийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны оролцогч талууд
- Зураг 9: Баруун Австрали мужийн уул уурхайн салбарт ашиглагдаж буй дижитал шийдлүүд
- Зураг 10: Mining Titles Online системд нэвтэрсний дараах нүүр хуудас
- Зураг 11: Mining Notices системээр дамжуулан нийт бүртгэгдсэн тусгай зөвшөөрлийн хүсэлтийг хайх, харах хуудас
- Зураг 12: Tenenograph Web системээр дамжуулан байршлын талаар мэдээлэл харах хуудас
- Зураг 13: Баруун Австрали мужийн хайгуулын тусгай зөвшөөрөл олгох процессийн зураглал
- Зураг 14: Баруун Австрали мужийн хайгуулын тусгай зөвшөөрөл олгох процессийн зураглал /Монголын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох процессийн ерөнхий үе шатууд дээр тусган харуулсан/
- Зураг 15: Баруун Австрали мужийн хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны цахимжуулалтын бэлэн байдлын түвшин
- Зураг 16: Баруун Австрали мужийн ашигт малтмалын зөвшөөрлийн бүртгэлийн журмын цахимжуулалтын бэлэн байдлын үнэлгээний үзүүлэлтийн дүн
- Зураг 17: Баруун Австрали мужийн хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны цахимжуулсан байдлын түвшин
- Зураг 18: Саскачеван мужийн ТЗ олгох үйл ажиллагаанд оролцогч талууд
- Зураг 19: Саскачеван мужийн хайгуулын тусгай зөвшөөрлийн хүсэгт гаргах, хүлээн авах процессын зураг
- Зураг 20: Саскачеван мужийн ашигт малтмалын үйл ажиллагаанд ашиглагддаг программуудын уялдааны зураглал
- Зураг 21: Petrinex вебсайтын нүүр хуудас
- Зураг 22: Саскачеван мужийн засгийн газрын вебсайтын нүүр хуудас
- Зураг 23: MARS программын нүүр хуудас
- Зураг 24: IRIS программын нүүр хуудас
- Зураг 25: GeoAtlas программын нүүр хуудас
- Зураг 26: Саскачеван мужийн ашигт малтмалын зөвшөөрлийн бүртгэлийн журмын цахимжуулалтын бэлэн байдлын түвшин
- Зураг 27: Саскачеван мужийн ашигт малтмалын зөвшөөрлийн бүртгэлийн журмын цахимжуулалтын бэлэн байдлын үнэлгээний үзүүлэлтийн дүн
- Зураг 28: Саскачеван мужийн ашигт малтмалын зөвшөөрлийн бүртгэлийн журмын цахимжуулсан байдлын түвшин
- Зураг 29: ОХУ-н ТЗ олгох үйл ажиллагаанд оролцогч талууд
- Зураг 30: ОХУ-н ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох процесс
- Зураг 31: ОХУ-н вебсайтын нүүр хуудас
- Зураг 32: ОХУ-н сонгон шалгаруулалтын вебсайтын нүүр хуудас
- Зураг 33: ОХУ-н ашигт малтмалын зөвшөөрлийг олгох журмын цахимжуулалтын бэлэн байдлын түвшин

Зураг 34: ОХУ-н ашигт малтмалын зөвшөөрлийг олгох журмын цахимжуулалтын бэлэн байдлын үнэлгээний үзүүлэлтийн дүн

Зураг 35: ОХУ-н ашигт малтмалын зөвшөөрлийг олгох журмын цахимжуулсан байдлын түвшин

Зураг 36: Башкортостаны 2020 оны 11 сард зарласан лицензийн дуудлага худалдааны журмийн зураглал

Зураг 37: Олон улсын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны цахимжуулалтын бэлэн байдлын болон цахимжуулсан байдлын дүн

Зураг 38: Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох системд оролцогч талуудын уялдааны зураглал

Зураг 39: Төрийн үйлчилгээний гол гурван систем

Зураг 40: Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог E-mongolia системтэй уялдууланд дижиталжуулах

Зураг 41: Системд байгууллагаа холбох дараалал

Зураг 42: Иргэн эсвэл хуулийн этгээд харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын үйлчилгээний тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргах замын зураг

Зураг 43: Харилцаа холбооны зохицуулах хорооны системийн нэвтрэх хуудас

Зураг 44: Emongolia системийн нэвтрэх хуудас

Зураг 45: Emongolia системийн мэдээлэл дамжуулалтыг баталгаажуулах хуудас

Зураг 46: Харилцаа холбооны зохицуулах хорооны тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргах хуудас

Зураг 47: Харилцаа холбооны зохицуулах хорооны тусгай зөвшөөрлийн систем

Зураг 48: Нийгмийн тогтолцоог дижиталжуулах үйл ажиллагааны логик дарааллын зураглал

Зураг 49: Нийгмийн тогтолцоог дижиталжуулах үйл ажиллагааны логик дарааллын зураглалын жишээ

Зураг 50: Уул уурхайн кадастрын системийн нүүр зураг

Зураг 51: Хайгуулын тусгай зөвшөөрлийн сонгол шалгаруулалтын журмын суурь ойлголтууд болон цахимжуулсан объектууд

Зураг 52: Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог CMCS программаар дижиталжуулах боломжийн зураглал

Зураг 53: tender.gov.mn сайтын худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээллийг зураглал

Зураг 54: tender.gov.mn сайтын цахимжуулсан үе шат

Зураг 55: хайгуулын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтын журмын үе шат дээр tender.gov.mn сайтын хангаж байгаа

Зураг 56: Хайгуулын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтын журмын үүргүүдийн урсгал зураг

2. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Хүснэгт 1: Нэр томьёоны тайлбар

№	Нэр томьёо	Тайлбар
1	Асуудал	Системийн доголдлын илрэн гарч буй шинж тэмдгийг;
2	Доголдол	Зорилгоо хэрэгжүүлэх тогтолцооны хэвийн үйл ажиллагааг ямар нэг байдлаар алдагдуулахад хүргэж буй оюуны шийдлүүдийн дутмаг байдлыг;
3	Дүгнэлт	Тодорхой зорилгоор мэдээллүүдийг ангилж, боловсруулснаар тогтоосон тэдгээрийн хоорондын хамаарлын зүй тогтлын томьёоллыг;
4	Журам	Зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд мөрдөгдөх тодорхой хэв шинжийг бүрдүүлэхэд шаардлагатай, олон дахин давтагддаг үүргүүдийг тогтоож, тэдгээрийг хооронд нь уялдуулсан эрх зүйн баримт бичгийг;
5	Зорилго	Хэтийн зорилгынхоо хүрээнд хүрэхээр төлөвлөсөн үр дүнг;
6	Мэдээллийн урсгал	Өгөгдөл, мэдээллийг хүргүүлэх, хүлээн авах цогц үйл ажиллагааг;
7	Мэдээлэл	Байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, мониторинг, зохицуулалт хийх зорилгоор цуглуулж боловсруулсан өгөгдлүүдийгд
8	Систем	Тодорхой хугацаанд зонхилох хэв шинжийг тогтвортой бүрдүүлдэг, харилцан уялдаатай элементүүдийн нэгдлийг;
9	Системийн инженерчлэл	Хэвийн үйл ажиллагаатай тогтолцоог бүрдүүлэх арга хэрэгслийгд
10	Суурь нөөц	Тодорхой зорилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай цаг, хөрөнгө, мэдлэгийн нөөцийг;
11	ТУСС индекс	Системийн зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаанд учрах эрсдэлийг даван туулах чадварыг жигдрүүлсэн байдлаар, тоон утгаар, баримтанд суурилан хэмжих хэмжүүр үзүүлэлтүүдийн багцыг;
12	Тогтолцоо	Оролцогч талууд харилцан уялдаатай үүргүүдийг гүйцэтгэх замаар нэгдмэл зорилгоо хэрэгжүүлэх бүтцийг;
13	Үнэт зүйлс	Үнэ цэнийг бүтээх арга замын бусдаас ялгарах хэв шинжүүд;
14	Үзэл баримтлал	Байгууллагын үйл ажиллагааны туйлын зорилго, хэтийн зорилго, үнэт зүйлс, зарчмуудыг багтаасан цогц ойлголтыг;
15	Үүрэг	Ажлыг гүйцэтгэхэд зайлшгүй хийгдэх, эрх зүйн актаар байнгын мөрдөх хэм хэмжээ болгон тогтоосон үйлдлүүдийг;
16	Шийдэл	Асуудлыг шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай ойлголтуудыг тодорхойлох, өгөгдөлд хөрвүүлэх, ангилах, үйлдлүүдийг тогтоох, дэс дараалалд оруулах, тэдгээрийг хооронд нь уялдуулах цогц санааг баримтжуулсан хэлбэрийг;
17	Оношилгоо	Асуудал үүсгэж байгаа шалтгааныг тодорхойлох зорилготой танин мэдэхүйн үйл ажиллагааг;
18	Системийн төлөв байдлын оношилгоо	Үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагааны бодит баримтанд үндэслэн ТУС индексийг ашиглан тоон утгыг гаргаж, тухайн байгууллагын үйл ажиллагаанд асуудал үүсгэж буй шалтгаан буюу системийн доголдлуудыг илрүүлэн дүгнэлт гаргах үйл ажиллагааг;
19	Бизнесийн түнш /BA/	Саскачеван мужийн Эрчим хүч, байгалийн баялагийн яамтай бизнесийн үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжийг;
20	IRIS	Нөөцийн мэдээллийн нэгдсэн системийг;
21	Бизнесийн түншийн тодорхойлолтын код	Хуулийн этгээд бүрт идэвхтэй BA ID-тай байх ёстой бөгөөд энэ нь таван тэмдэгтээс бүрдэх тоон таних код юм. Хуулийн этгээд нь Petrinex-ээр

Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны цахимжуулалтын бэлэн байдлын үнэлгээ

	/BA ID/	дамжуулан Саскачевангийн засгийн газраас BA ID код авдаг.
22	Petrinex	Petrinex бол газрын тос, байгалийн хийн салбарын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, хэмжигдэхүүн, үнэлгээтэй холбоотой татвар төлөгч болон дэд бүтцийн мэдээллийг Саскачеваны засгийн газарт хүргүүлэхэд ашигладаг систем юм. Засгийн газар Petrinex-ийг BA ID кодыг удирдахдаа ашигладаг.
21	IRIS аюулгүй байдлын зохицуулагч /SA/	SA нь BA-ийн өмнөөс IRIS-ийн бүх хэрэглэгчийн дансыг удирдах, үүнд зөвшөөрөл олгох, аюулгүй байдал, эрсдлийн менежментийн зохих журмыг IRIS-т байрлуулж, BA-ийн мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдлыг хадгалах үүрэгтэй

3. УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Ашигт Малтмал, Газрын Тосны Газрын /цаашид АМГТГ/ Кадастрын хэлтсийн хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны цахимжуулалтын бэлэн байдлын түвшинг тодорхойлж, одоогийн системд үндэслэн дижиталжуулах боломжтой арга замыг санал болгох, мөн олон улсын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоо, цахимжуулсан арга замыг судлан дүгнэлт гаргаж, санал зөвлөмж өгөх зорилготой.


СУДАЛГААНЫ АРГА АРГАЧЛАЛ

“ТУССолюшн” ХХК нь аливаа системийг дижиталжуулахад бэлэн байгаа эсэхийг үнэлэхдээ өөрсдийн системийн инженерүүдийн боловсруулсан аргачлалаар тодорхойлдог. Тус аргачлал нь аливаа системийн оюуны шийдлүүд нь тодорхой, бүрэн, үнэн зөв, харилцан уялдаатай бөгөөд дараах 6 хэв шинжийг агуулсан чанартай өгөгдлүүдийг бий болгох чадвартай байвал тухайн системийг цахимжуулалтад бэлэн байна гэж үздэг.

1. **Рийл-тайм байх** гэж аливаа юмс үзэгдлийн тухайн агшны төлөв байдлыг илэрхийлдэг хэв шинжийг хэлнэ.
2. **Нотлогддог байх** аливаа юмс үзэгдлийг баримт фактаар шалгах боломжтой төлөвийг илэрхийлэх хэв шинжийг хэлнэ.
3. **Хүртээмжтэй байх** гэж аливаа юмс үзэгдлийг ашиглах боломж бүрдсэн төлөв байдлын хэв шинжийг хэлнэ.
4. **Жигдрүүлсэн байх** зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэв шинжүүдийг оролцогч талуудын хүлээн зөвшөөрөгдсөн шалгуураар ангилагдсан хэмжих нэгж рүү хөрвүүлсэн төлөв байдлыг хэлнэ.
5. **Цогц байх** гэж зорилгоо хэрэгжүүлэхэд шаардлагатай элементүүд, тэдгээрийн хоорондын харилцан шүтэлцээний байдлыг бүрэн бүрдүүлсэн хэв шинжийг бүрдүүлэх боломжтой байхыг хэлнэ.
6. **Уялдаатай байх** гэж зорилгоо хэрэгжүүлэхэд шаардлагатай цаг хугацаа, орон зайн хувьд зөрчилгүй байгаа төлөв байдлын хэв шинжийг хэлнэ.

Системийн цахимжуулалтын бэлэн байдлыг гурван хэмжүүр үзүүлэлтээр тодорхойлдог. Үүнд:

Зураг 1: Цахимжуулалтын бэлэн байдлын түвшинг үнэлэх хэмжүүр үзүүлэлтүүд



1. Системийн төлөв байдлын оношилгоо

Системийн төлөв байдлын оношилгоо гэдэг нь байгууллагын үйл ажиллагааны бодит баримтад үндэслэн ТУС индексийг ашиглан тоон утгыг гаргаж, тухайн байгууллагын үйл ажиллагаанд асуудал үүсгэж буй шалтгаан буюу системийн доголдлуудыг илрүүлэн дүгнэлт гаргах үйл ажиллагааг хэлнэ.

Өөрөөр хэлбэл, системийн төлөв байдлын оношилгоог гүйцэтгэхдээ захиалагч байгууллагын албан ёсны баталгаажсан мэдээллүүдэд үндэслэн, 5 дэд тогтолцооны 40 хэв шинжийн бүрдлийг 240 шалгуураар шалгах замаар тоон утгаар үнэлгээ өгдөг. Үүнд:

1. Зорилгын тайллын дэд тогтолцоо /7 хэв шинж, 42 шалгуур/
2. Мэдээллийн урсгалын дэд тогтолцоо /10 хэв шинж, 60 шалгуур/
3. Үүргийн гүйцэтгэлийн дэд тогтолцоо /6 хэв шинж, 36 шалгуур/
4. Эргэх холбооны дэд тогтолцоо /6 хэв шинж, 36 шалгуур/
5. Хэмжүүр үзүүлэлтийн дэд тогтолцоо /11 хэв шинж, 66 шалгуур/

Эдгээр 5 дэд тогтолцооны 240 шалгуураар үнэлэхдээ шалгуур хангаж байгаа тохиолдолд 2 оноо, харин хангахгүй бол 1 оноо өгч, хэвийн байгууллагын хэв шинж болох 480 онооноос авсан оноог хувьчлан харьцуулж доорх хүснэгтэд тусгасан системийн төлөв байдлын түвшинг тодорхойлон дүгнэлт гаргадаг.

Хүснэгт 2: Байгууллагын системийн төлөв байдлын түвшингийн ангилал

№	ASA ангилал	Стратегийн суурь тогтолцооны эрүүл мэндийн түвшин	Ангилалын тайлбар
1	ASA - I	$91\% < x \leq 100\%$	Эрсдэлийн нөлөөллийг удирдах чадвартай систем
2	ASA - II	$81\% < x \leq 90\%$	Эрсдэлийн нөлөөллийг тогтвортой даван туулах чадвартай систем
3	ASA - III	$71\% < x \leq 80\%$	Эрсдэлийн нөлөөллийг тогтоон барих чадвартай систем
4	ASA - IV	$61\% < x \leq 70\%$	Эрсдэлийн нөлөөллийг бууруулах чадвартай систем
5	ASA - V	$51\% < x \leq 60\%$	Эрсдэлийн нөлөөлөлд өртөмтгий систем
6	ASA - VI	$x \leq 50\%$	Эрсдэлийн хамгаалалтгүй систем

2. Ажлын байрны тодорхойлолтын хэв шинжүүдийг бүрдүүлсэн түвшин

Системийн цахимжуулалтын бэлэн байдлын түвшинг тодорхойлох гурван хэмжүүр үзүүлэлтийн нэг болох ажлын байрны тодорхойлолтын хэв шинжүүдийг бүрдүүлсэн түвшин нь аливаа байгууллагын ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт/АБТ/-ууд АБТ-д тавигдах системийн 24 шалгуурт нийцэж байгаа эсэхийг үнэлж, индексээр тодорхойлно.

3. Журмын чанарын түвшин

Байгууллагын үйл ажиллагаандаа ашиглаж буй албан ёсны батлагдсан журамд туссан үүргүүдийг тодорхойлсон 4 шалгуур үзүүлэлт бүхий индексээр түвшинг нь тогтооно.

Эдгээр гурван үзүүлэлтийн тус бүрийн түвшинг тодорхойлж, доорх зурагт туссан аргачлалын дагуу цахимжуулалтын бэлэн байдлын индексийг тооцдог. Өөрөөр хэлбэл, хэмжүүр үзүүлэлт тус

бүрийн авсан оноог хувийн жингээр нь үржүүлж, тэдгээрийн нийлбэрээр тухайн системийн үйл ажиллагааг дижиталжуулахад бэлэн байгаа эсэхийг тодорхойлно.

Зураг 2: Цахимжуулалтын бэлэн байдлын түвшинг үнэлэх аргачлал

$$\text{Дижиталжуулалтын бэлэн байдлын индекс} = 50\% * \frac{\text{Системийн төлөв байдлын оношилгооны түвшин}}{\text{Системийн төлөв байдлын оношилгооны түвшин}} + 25\% * \frac{\text{Журамд заасан үүргүүдийн чанарын түвшин}}{\text{Журамд заасан үүргүүдийн чанарын түвшин}} + 25\% * \frac{\text{АБТ-ын хэв шинжүүдийг бүрдүүлсэн түвшин}}{\text{АБТ-ын хэв шинжүүдийг бүрдүүлсэн түвшин}}$$

Аливаа системийн цахимжуулалтад бэлэн байгаа эсэхийг Зураг 2т туссан аргачлалын дагуу системийн төлөв байдлын оношилгооны түвшин, байгууллагад дагаж мөрдөгдөж буй журмын чанарын түвшин болон ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтын хэв шинжүүдийг бүрдүүлсэн түвшинг тогтоон, тэдгээрийн нийлбэр дүнгээр цахимжуулалтын бэлэн байдлын индексийг тодорхойлон дүгнэдэг.

Системийн цахимжуулалтын бэлэн байдлын түвшингийн дүнг тодорхойлсноор тухайн систем ямар түвшинд байгааг дараах хүснэгтэд туссан ангиллын дагуу тогтоож, дүгнэлт зөвлөмжийг боловсруулна.

Хүснэгт 3: Цахимжуулалтын бэлэн байдлын индексийн ангилал

№	Ангилал	Хувь	Дүгнэлт
1	Дижитал бэлэн байдлын I түвшин	90% - 100%	Дижиталжуулахад бэлэн байна
2	Дижитал бэлэн байдлын II түвшин	51% - 90%	Хэсэгчлэн дижиталжуулахад бэлэн байна
3	Дижитал бэлэн байдлын III түвшин	0% - 50%	Дижиталжуулахад шаардлагатай хэв шинжүүд бүрдээгүй байна

Системийн инженерчлэлийн арга зүй нь зөвхөн захиалагч байгууллагын өгсөн албан ёсны баталгаажсан мэдээлэл, материал дээр үндэслэн судалгаа, шинжилгээгээ гүйцэтгэдэг тул судалгааны ажлын үр дүн нь захиалагч байгууллагын мэдээллээр хангах үүргийн гүйцэтгэлээс шууд хамаардаг болно.

4. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

4.1 Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны цахимжуулалтын бэлэн байдлын үнэлгээний дүгнэлт

Системийн цахимжуулалтын бэлэн байдлын түвшинг тодорхойлох аргачлалын дагуу хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны цахимжуулалтын бэлэн байдлын индексийг тодорхойлж, цахимжуулалтын бэлэн байдлын индексийн ангиллын дагуу хамаарах түвшинг тогтоосон.

Хүснэгт 4: Цахимжуулалтын бэлэн байдлын индекс

№	Дижиталжуулахад бэлэн байдлын хэмжүүр үзүүлэлт	Хувийн жин	Дүн
1	Системийн төлөв байдлын оношилгооны дүн	50.00%	69.94%
2	Журамд заагдсан үүргүүдийн чанарын түвшин	25.00%	72.73%
3	Ажлын байрны тодорхойлолтын хэв шинжүүдийг бүрдүүлсэн түвшин	25.00%	50.00%
Дижиталжуулахад бэлэн байдлын индексийн дүн		100%	65.65%
Дижиталжуулахад бэлэн байдлын түвшингийн ангилал			II түвшин

Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны бэлэн байдлын түвшин **65.65** хувьтай гарсан бөгөөд энэ нь **хэсэгчлэн дижиталжуулахад бэлэн** байгааг харуулж байна. Иймд шаардлагатай хэв шинжийг бүрдүүлэх замаар дижиталжуулах ажлыг зохион байгуулах нь зүйтэй юм.

Хүснэгт 5: Системийн төлөв байдлын оношилгооны дүн

№	Дэд тогтолцоонууд	Хэвийн үйл ажиллагаатай байгууллагын дүн /оноогоор/	Оношилгооны дүн /оноогоор/	Хэвийн үйл ажиллагаатай байгууллагын дүн /хувиар/	Оношилгооны дүн /хувиар/	Хамаарах ангилал
1	Зорилгын тайллын дэд тогтолцоо	84	62.61	100.00%	74.54%	ASA - III
2	Мэдээллийн урсгалын дэд тогтолцоо	120	90	100.00%	75.00%	ASA - III
3	Үүргийн гүйцэтгэлийн дэд тогтолцоо	72	44.1	100.00%	61.25%	ASA - IV
4	Эргэх холбооны дэд тогтолцоо	72	45	100.00%	62.50%	ASA - IV
5	Хэмжүүр үзүүлэлтийн дэд тогтолцоо	132	94	100.00%	71.21%	ASA - III
Системийн төлөв байдлын оношилгооны дүн		480	335.71	100.00%	69.94%	ASA - IV

АМГТГ-н “Кадастрын хэлтэс”-ийн системийн төлөв байдлын оношилгооны нэгдсэн дүнгээр **69.94** хувийн үнэлгээ авсан. Энэ нь системийн төлөв байдлын түвшингийн ангиллын дагуу **ASA - IV** буюу **Эрсдэлийн нөлөөллийг бууруулах чадвартай систем**-н ангилалд хамаарч байна. “Кадастрын хэлтэс”-ийн системийн уялдааны индекс нь **68.92** хувийн үнэлгээтэйгээр **SU-II** ангилал буюу **системийн тогтолцооны уялдааг сайжруулах шаардлагатай** байна.

АМГТГ-н “Кадастрын хэлтэс”-ийн зорилгын тайллын дэд тогтолцоо нь **62.61** оноо авсан бөгөөд хэвийн үйл ажиллагаатай байгууллагын зорилгын тайллын дэд тогтолцооны дүнтэй

харьцуулахад **21.39** оноогоор бага байна. Өөрөөр хэлбэл Нэгдмэл зорилго нь албан ёсоор баталгаажсан байх ёстой дэд тогтолцоог **74.54 хувь** бүрдүүлсэн буюу “Эрсдэлийн нөлөөллийг тогтоон барих чадвартай систем”-д хамаарч байна. “Кадастрын хэлтэс”-ийн мэдээллийн урсгалын дэд тогтолцооны хувьд **120** оноо авахаас **90 оноо** авсан нь хэвийн үйл ажиллагаатай байгууллагын мэдээллийн урсгалын дэд тогтолцооны дүнгээс **30** оноогоор бага байна. Энэ нь тухайн байгууллагын мэдээллийн урсгалын дэд тогтолцоо буюу үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай чанартай мэдээллүүдийг цуглуулж, боловсруулж, түгээдэг байх дэд тогтолцоо **75** хувьтай байгаа буюу “Эрсдэлийн нөлөөллийг тогтоон барих чадвартай систем”-д хамаарч байна. Тус хэлтсийн үүргийн гүйцэтгэлийн дэд тогтолцоо нь **72** оноо авахаас **44.1** оноо авсан. Өөрөөр хэлбэл, үүргийн гүйцэтгэлийн дэд тогтолцоо нь **61.25** хувьтай бүрдсэн буюу “Эрсдэлийн нөлөөллийг бууруулах чадвартай систем”-д хамаарч байна. Харин эргэх холбооны дэд тогтолцоо буюу зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь байнга төгөлдөрждөг байх дэд тогтолцооны хувьд **72** оноо авах ёстойгоос **45** авсан нь тухайн дэд тогтолцоо **62.5** хувьтай гарсан буюу “Эрсдэлийн нөлөөллийг бууруулах чадвартай систем”-д хамаарч байна. Стратегийн суурь тогтолцооны сүүлийн дэд тогтолцоо болох хэмжүүр үзүүлэлтийн дэд тогтолцооны хувьд тухайн байгууллага **132** оноо авахаас **94** оноо авч, тус дэд тогтолцоог **71.21** хувьтай бүрдүүлсэн байна. Өөрөөр хэлбэл, “Эрсдэлийн нөлөөллийг тогтоон барих чадвартай систем”-нд хамаарч байна.

Мөн оношилгооны нэг бүрэлдэхүүн хэсэг болон ажилтнуудад тулгарч буй 10 асуудлуудыг санал асуулгаар тодорхойлсон. Тус асуулгаар нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай дараах 3 асуудлыг тогтоосон юм. Үүнд:

1. Ажилтнууд тэгш бус ачаалалтай ажилладаг
2. Ажилтнуудаа сургаж хөгжүүлдэггүй
3. Газар нэгжийн ажлууд хоорондоо уялддаггүй

Эдгээр асуудлуудын суурь шалтгаан нь дээрх 5 дэд тогтолцоонд үүссэн системийн доголдлуудаас шалтгаалан бий болж байна. Тухайн системийн доголдлуудыг арилгах шийдлүүдийг нэн даруй боловсруулж, хэрэгжүүлэх хэрэгтэй ба эс бөгөөс үүссэн сөрөг асуудлуудыг шийдэхэд байгууллага нөөцөө зарцуулсаар байх болно.

Харин хайгуулын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтын журмын чанарын түвшин нь **72.73** хувь буюу журмын үүргүүдийг харьцангуй сайн бүрдүүлсэн боловч журамд тусгагдсан үүргүүдийн үүрэг хүлээх албан тушаалтан болон шаардлагатай хавсралт маягтуудыг боловсруулж хавсаргаагүй байгаа нь сөргөөр нөлөөлсөн.

Захиалагч байгууллагаас ирүүлсэн 18 албан тушаалын тодорхойлолт /АТТ/-с жишиг болгон дараах гурван АТТ-г сонгон авч үнэлгээ хийсэн.

1. Геологи уул уурхайн кадастрын хэлтсийн дарга
2. Сонгон шалгаруулалт хариуцсан ахлах мэргэжилтэн
3. Сонгон шалгаруулалтын мэдээлэл хариуцсан мэргэжилтэн

Албан тушаалын тодорхойлолтын хэв шинжүүдийг бүрдүүлсэн түвшин **50** хувийн үнэлгээтэй гарсан. АТТ-уудын бүрдүүлэх шаардлагатай хэв шинжүүдийг тусган илрүүлсэн доголдлуудыг арилгаж, ажил үүргүүдийг хооронд нь уялдуулан боловсруулах нь зүйтэй.

Ашигт Малтмал, Газрын Тосны Газрын Кадастрын хэлтсийн хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны бэлэн байдлыг тодорхойлохын зэрэгцээ цахимжуулсан байдлыг тодорхойлсон. Цахимжуулсан байдлыг тодорхойлохын тулд “Хайгуулын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтын журам”-н үүрэг бүрт хамаарах маягтуудыг цахимжуулсан эсэхийг захиалагч байгууллагаас мэдүүлсэн албан ёсны баримт бичиг, дүрэм, журам болон ашиглаж буй мэдээллийн технологийн талаарх мэдээлэл дээр үндэслэн судалсан. Үүнд АМГТТ-н хайгуулын тусгай зөвшөөрөл олгох процессын **21.4** хувийг <https://mrpam.gov.mn/> болон <https://cmcs.mrpam.gov.mn/cmcs> програмуудаар цахимжуулсан байна.

4.2 Олон улсын ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоо, цахимжуулалтын түвшний дүгнэлт

Олон улсын ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох системийг судлахын тулд Австрали, ОХУ болон Канад улсыг сонгон авч судалсан. Австрали улс болон Канад улс нь холбооны улс учраас системийг нарийн судлах үүднээс тодорхой шалгуур боловсруулж, Баруун Австрали муж болон Канад улсын Саскачеван мужийг сонгон судласан.

Хүснэгт : Олон улсын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны харьцуулалт

№	Үзүүлэлт	Баруун Австрали	Канад улсын Саскачеван муж	ОХУ
1	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог зохицуулдаг эрх зүйн баримт бичгүүд	Mining Act 1978 Mining Regulation 1981	Mineral tenure registry regulation, 2012 Mineral disposition regulation, 1986	Газрын хэвлийн тухай хууль Тусгай үйл ажиллагааг лицензжуулах тухай хууль Тухайн газар орон нутгийн лиценз олголтгийн тухай журам.
2	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог зохицуулдаг байгууллага	Уул уурхай, аж үйлдвэрийн зохицуулалт, аюулгүй байдлын газар /The Department of Mines, Industry Regulation and Safety/	Саскачеван мужийн Эрчим Хүч, Байгалийн Баялгийн Яам	Холбооны газрын хэвлий ашиглах агентлаг /Роснедра/
3	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох арга	Өргөдлөөр “first come first serve” буюу түрүүлж хүсэлт гаргасан этгээдэд	Олон нийтийн тендер	Сонгон шалгаруулалт Дуудлага худалдаа
4	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны оролцогч талууд	Тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргаж буй этгээд Уул уурхай, аж үйлдвэрийн зохицуулалт, аюулгүй байдлын газар Уул уурхайн сайд Уул уурхай, аж үйлдвэрийн зохицуулалт, аюулгүй байдлын газрын гүйцэтгэх захирал Хайгуулын тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргаж буй газрын эзэмшигч	Саскачеван мужийн Эрчим Хүч, Байгалийн Баялгийн Яам Тусгай зөвшөөрөл хүсэгч этгээд First Nation	ОХУ-н Засгийн Газар Газрын хэвлий ашиглах агентлаг Байгалийн менежментийн холбоо Байгаль, орчин, технологи, цөмийн хяналт шалгалтын холбоо
5	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаа	5 жил	1 жил /хамгийн ихдээ 8 жил/	5 жил
6	Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоонд ашиглагдаж буй программууд	Mining Titles Online Mining Notices Tenagraph Web	GeoAtlas MARS IRIS	www.rosnedra.gov.ru/ www.torgi.gov.ru

Баруун Австрали мужид ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох аргачлал нь энэ судалгаанд туссан Орос, Канад улсуудын аргачлалаас ялгаатай учир нь “first come first serve” буюу түрүүлж хүсэлт гаргасан этгээдэд Уул уурхай, аж үйлдвэрийн зохицуулалт, аюулгүй байдлын газар /The Department of Mines, Industry Regulation and Safety/-с хайгуул хийх тусгай зөвшөөрлийг олгодог. Баруун Австрали мужийн уул уурхай, аж үйлдвэрийн зохицуулалт, аюулгүй байдлын газрын гаргасан зөвлөмжийн дагуу хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа нь үндсэн 8 үе шатнаас бүрддэг.

Энэхүү 8 үе шат нь Mining Regulation-д туссан 12 үүргийн заалт, 56 тодотгох заалт, 6 маягтаас бүрдэж байна. Уул уурхайн үйл ажиллагааг зохицуулдаг баримт бичгүүдээс хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд **Mining Titles Online, Mining Notices, Tenagraph Web** зэрэг програм хангамжууд ашиглагдаж байна.

1. Mining Titles Online - Mining Act, Mining Regulation-д туссан үүргүүдийг гүйцэтгэхэд ашиглагдаж буй маягтуудыг цахимаар бүртгэх, шийдвэрлэх боломжийг бүрдүүлсэн платформ юм. Энэхүү платформоор дамжуулан Mining Regulation-д туссан нийт 43 маягтын 36-г нь цахимаар илгээх, бүртгүүлэх, шийдвэрлүүлэх боломж бүрдсэн ба мөн бусад нэмэлт журамд туссан үүргүүдийг энэ платформоор дамжуулан гүйцэтгэх боломжтой байна.

2. Mining Notices - Энэхүү платформ нь ашиг малтмал, уул уурхайн үйл ажиллагааг явуулах хүсэлт хүлээн авсан, олгосон талаар оролцогч талуудад ил тод мэдэгдэх зорилготой цахим платформ юм.

3. Tenagraph Web нь Баруун Австралийн уул уурхайн ашиглалт, газрын тосны газрын байршил, газрын бусад мэдээлэлтэй холбоотой байр суурийг харуулсан орон зайн лавлагаа, зураглалын систем юм. Энэ нь уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй газрын одоогийн бодит дүр зургийг гаргаж, ашигт малтмалын хайгуул хийх боломжтой газрыг тогтооход ашигладаг.

Эдгээр гурван програмууд нь бүгд “Mining Act”, “Mining Regulation” эрх зүйн баримт бичгүүдийг суурь оюуны шийдлээ болгож ашиглан, цахимжуулсаны үр дүнд бий болсон байна. Ингэснээр дижитал шийдлүүд болон хууль дүрэм журмуудыг уялдуулан сайжруулж, хүсэлт гаргагч этгээд дижитал платформоор дамжуулан үүргээ гүйцэтгэх боломжийг бүрдүүлж өгсөн байна.

Канад улсын Саскачеван мужийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргах, хүлээн авах процессыг судлан, зурагласан. Тухайн процессыг зураглахдаа дөрвөн үе шатад ангилж, үе шат тус бүрт гүйцэтгэх үйлдлүүдийг тодорхойлсон. Саскачеван мужийн хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоонд Petrinex, Saskatchewan.ca, MARS болон IRIS системүүд ашиглагддаг. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл авах үе шатанд хүсэлт гаргагч иргэн эсвэл аж ахуй нэгж “BA ID буюу бизнесийн түншийн тодорхойлолтын код”-г Petrinex системээс авдаг. Тухайн кодыг авсны дараа хүсэлт гаргагч нь MARS систем болон IRIS системд бүртгүүлж, мэдээллээ байршуулснаар олон нийтийн тендерийн үйл ажиллагаанд оролцох боломжтой болно.

Хайгуулын тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргагч этгээд нь Эрчим Хүч, Байгалийн Баялгийн Яамд “Subsurface mineral tenure regulation”-н дагуу өргөдөл гаргахаас өмнө боломжит ашигт малтмалын газрыг тодорхойлохдоо ISC /Ашигт малтмалын өмчлөл/ болон Geotlas /олгогдсон тусгай зөвшөөрөл, эрх/ашиглана. Эдгээр вебсайтуудаас олж авсан мэдээлэл нь ашигт малтмалын эрхийн хүртээмжийг тодорхойлоход ашиглагддаг. IRIS-д тендерийн өргөдөл гаргахыг хүсч буй хүн бүр IRIS дахь олон нийтийн санал авах хуваарь руу орж цахим дебит кодтой болох ёстой. Бүх саналыг IRIS-ээр олон нийтэд санал болгож буй өдрийн стандарт цагийн хуваарийн дагуу өдрийн 12:00 цаг хүртэл хүлээн авах ёстой. Тодорхойлсон процессын дагуу хайгуулын тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргаж, авахын тулд хүсэлт гаргагч этгээд бүр дараах шалгуурыг хангасан байх шаардлагатай.

1. IRIS бүртгэл болон IRIS-ийн аюулгүй байдлын зохицуулагч өгсөн зохих зөвшөөрөлтэй байх.
2. Тендерийн саналуудыг тусад нь ирүүлэх эсвэл нэг тендер ирүүлэх байдлаар илгээж болно. Тендерийн бүх саналуудад дараах мэдээллүүд багтсан байх ёстой.
 - a. Төлбөр төлөгч
 - b. Холбоо барих мэдээлэл
 - c. Итгэмжлэгдсэн төлөөлөгч
 - d. Тусгай зөвшөөрөл эзэмших этгээдийн мэдээлэл
3. Саскачеваны Эрчим хүч, байгалийн баялгийн яамтай урьдчилж зөвшөөрөгдсөн дебит (PAD) төлбөртэй байх


ОХУ-н тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог судлахдаа ОХУ-н хууль эрх зүйн орчин, тухайн тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хариуцаж буй байгууллага, түүнд мөрдөгддөг дотоод эрх зүйн баримт бичиг зэргийг судалсан.

Газрын хэвлий ашиглалтын чиглэлээр төрийн үйлчилгээ үзүүлэх, төрийн өмчийн гүйцэтгэх байгууллага буюу “Роснедра” нь өөрийн орон нутгийн харьяа байгууллагуудаараа дамжуулан ОХУ-н “Газрын хэвлийн тухай” хуулийн хүрээнд дотоодын тусгай зөвшөөрөл олгох журмын дагуу тусгай зөвшөөрлийг олгодог гол байгууллага юм. Тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалт, дуудлага худалдаа гэсэн хоёр аргаар олгож байна. Тусгай зөвшөөрөл олгох, сонгон шалгаруулалт, дуудлага худалдааг тухай бүр олон нийтэд нээлттэй зарлаж байгаа тусгай зөвшөөрлийн журмаар зохицуулдаг бөгөөд уг журам нь Роснедра-н дуудлага худалдаа, сонгон шалгаруулалт явуулах дотоодын захиргааны журмаар зохицуулагддаг байна.

ОХУ-н тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны цахимжуулсан арга замыг Роснедра-н дуудлага худалдаа, сонгон шалгаруулалт явуулах дотоодын захиргааны журмыг үндэслэн судалсан. Үр дүнгээр ОХУ-н ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох процессын **цахимжуулалтын** бэлэн байдлын үнэлгээ **61.3** хувьтай гарсан. Харин **цахимжуулсан** байдлын түвшин **16.13** хувьтай гарсан. Үүнд дуудлага худалдаа, сонгон шалгаруулалтын талаарх мэдээллийг олон нийтэд зарлах, дуудлага худалдаа, сонгон шалгаруулалтын комиссын протокол болон дуудлага худалдаа сонгон шалгаруулалтын үр дүнг олон нийтэд албан ёсны вебсайт болох www.rosnedra.gov.ru болон www.torgi.gov.ru сайтуудаар дамжуулан мэдээлэлж байгаа нь цахимжуулсан байдлын түвшинд эерэг нөлөө үзүүлж байсан бөгөөд, үүрэгт хамаарах маягтууд бүрэн байхгүй нь цахимжуулсан байдлын түвшинд сөргөөр нөлөөлж байна. Цахимжуулалтын бэлэн байдлын түвшин нь 61.3 хувь буюу **хоёрдугаар түвшинд** хамаарч байгаа бөгөөд шаардлагатай хэв шинжийг бүрдүүлэх замаар дижиталжуулах ажлыг зохион байгуулах боломжтой байсан. Иймд ОХУ-нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог үүрэгт хамаарах маягтыг бүрэн тодорхойлж боловсруулснаар бүрэн дижиталжуулах боломжтой байна.

Австрали, Канад, ОХУ-н ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны **цахимжуулалтын** бэлэн байдал болон **цахимжуулсан** байдлыг үнэлэн Зураг 37-д үзүүлэв.

Зураг 3: Олон улсын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны цахимжуулалтын бэлэн байдлын болон цахимжуулсан байдлын дүн



Баруун Австрали мужийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох процессын **цахимжуулалтын** бэлэн байдлын үнэлгээ **91.7** хувьтай гарсан. Энэ нь цахимжуулалтын бэлэн байдлын **нэгдүгээр түвшинд** хамаарч байгаа бөгөөд дижиталжуулах ажлын зохион байгуулах нөхцөл бүрэн бүрдсэн байна. Харин Баруун Австралид ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоонд мөгдөгддөг хууль, дүрэм, журмуудад туссан тухайн үйл ажиллагаатай шууд хамааралтай үүргүүдийг **цахимжуулсан** байдлын түвшин **100** хувьтай гарсан.

Канад улсын Саскачеван мужийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны цахимжуулалтын бэлэн байдлын түвшин нь **98.5** хувьтай, цахимжуулсан байдлын түвшин **100.00** хувьтай гарсан. Энэ нь цахимжуулалтын бэлэн байдлын **нэгдүгээр түвшинд** хамаарч байгаа бөгөөд дижиталжуулах ажлын зохион байгуулах нөхцөл бүрэн бүрдсэн байсан байна.

ОХУ-н ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох процессын **цахимжуулалтын** бэлэн байдлын үнэлгээ **61.3** хувьтай гарсан. Энэ нь цахимжуулалтын бэлэн байдлын **хоёрдугаар** түвшинд хамаарч байгаа бөгөөд шаардлагатай хэв шинжийг **бүрдүүлэх** замаар дижиталжуулах ажлыг зохион байгуулах боломжтой. ОХУ-н хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог голчлон зохицуулдаг “Газрын хэвлий ашиглах эрхийн дуудлага худалдаа, сонгон шалгаруулалт зохион байгуулах Роснедрагийн захиргааны журам” -д туссан 31 үүргийг жишиг болгон сонгон авч шинжилгээ хийхэд үүрэг бүрт гүйцэтгэх үйлдэл, үйлдэлд өртөх объект болон үүрэг гүйцэтгэгчийг этгээдийг **100%** тодорхойлж томъёолсон байсан. Тодорхойлсон үүргүүдийг гүйцэтгэх маягттай байх шалгуурын хувьд **22.58** хувь бүрдүүлсэн байна. Үүний шалтгаан нь тухайн журам үүргүүдийг гүйцэтгэхэд шаардлагатай маягтуудыг бүрэн хавсаргаагүй байсан. Иймд тухайн **77.15** хувийн доголдол нь нийт цахимжуулалтын бэлэн байдлын түвшинд сөрөг нөлөө үзүүлсэн. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог **цахимжуулсан** байдлын түвшин **16.13** хувьтай гарсан.

Эдгээр гурван улсаас Баруун Австрали болон Саскачеван мужуудын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны шийдлүүд бүрэн бүрдсэн байгаа учраас тухайн шийдлүүдэд үндэслэн цахимжуулсан байна. Харин ОХУ-н хувьд шаардлагатай дүрэм, журам, заавар гэх мэтчилэн оюуны шийдлүүд нь хангалттай бүрдээгүй байгаа тул цахимжуулсан түвшин бага байна.

4.3 Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог дижиталжуулахад E-MONGOLIA, TENDER.MN, CMCS программыг ашиглах боломжийн судалгааны дүгнэлт

Emongolia программын судалгааны дүгнэлт:

Монгол Улсын төрийн бүх үйлчилгээг цахимжуулах, цахим засаглалыг хөгжүүлэх зорилгоор E-MONGOLIA төслийг хэрэгжүүлж эхлээд байгаа ба төслийн хүрээнд **Бүгд Найрамдах Эстони Улсын (БНЭУ)** цахим засаглалыг жишиг болгон сонгож, тус улсын цахим засаглалын академитай хамтран, өнөөгийн цахим хөгжлийн нөхцөл байдлыг тодорхойлж, Монгол Улсад хамгийн тохиромжтой загварыг хөгжүүлэн ажиллаж байна. Энэхүү систем нь цахим орчинд бүхий л төрлийн цахим үйлчилгээг авахад тухайн иргэнийг таньж баталгаажуулах боломжийг бүрдүүлэх бөгөөд хувийн хэвшил болон төрийн үйлчилгээний өөр хоорондоо харилцан хамааралгүй системүүдтэй нягт уялдаатай ажиллах боломжтой платформ бүхий систем юм. Emongolia системийн зорилго нь иргэд, аж ахуй нэгжид зориулсан бүхий л төрийн үйлчилгээг нэг цахим платформд нэгтгэж хүнд сурталгүй түргэн шуурхай хүргэх зорилготой тул энэхүү зорилгын хамрах хүрээний хувьд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог дижиталжуулах үйл ажиллагааны зорилготой уялдаж байгаа нь харагдаж байна.

“Үндэсний Дата Төв” УТҮГ-ийн Emongolia систем нь иргэний өөрийнх нь зөвшөөрлийн дагуу ХҮР төрийн мэдээлэл солилцооны системд бүртгэлтэй вебсервис дуудаж үр дүнг үйлчилгээг олгогч системд дамжуулдаг систем юм. Үйлчилгээг олгогч байгууллага, emongolia системээс сервис дуудах бүрт иргэн заавал тоон гарын үсэг эсвэл нэг удаагийн sms нууц кодоор өөрийгөө баталгаажуулж нэвтэрсэн байна. Уг баталгаажуулалт амжилттай болж иргэн өөрөө мэдээллээ өгөхийг зөвшөөрсөн тохиолдолд л иргэний мэдээллийг гуравдагч системд өгөх юм.

Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог дижиталжуулахад E-mongolia системтэй уялдуулах боломжийг судлан тодорхойлсон. Хайгуулын тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргах, хүлээн авах процессын 2 дахь үе шат болох хайгуулын тусгай зөвшөөрлийн хүсэгч этгээд шаардлагатай баримт бичгүүдийг өргөдлийг хамт хүсэлт гаргах болон сонгон шалгаруулалтад оролцох өргөдлийг бүртгэх гэсэн үүргүүдийг E-mongolia систем дамжуулан дижиталжуулах боломжтой байна. E-mongolia системтэй уялдуулан дижиталжуулснаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох системийн мэдээллийн аюулгүй байдлыг нэг цэгээс хянах боломжтой болох юм.

Emongolia системд төрийн болон бусад байгууллагуудын системтэй холбох бүрэн боломжтой бөгөөд тодорхой шаардлага, тодорхойлолтуудыг бэлтгэн “Үндэсний Дата Төв” УТҮГ-д бүртгүүлэх ёстой. Emongolia системд байгууллагын системийг холбогдоход дараах шаардлагуудыг хангасан байх хэрэгтэй. Үүнд:

1. developer.sso.gov.mn цахим хуудсанд нийтлэгдсэн OAuth 2.0 /emongolia/ нийтлэлийг сайтар уншиж танилцсан байна.
2. OAuth 2.0 протоколын талаар ойлголттой болсон байх.
3. ХҮР Төрийн мэдээлэл солилцооны системд холбогдсон байх.
4. PGP нийтийн түлхүүрийг PGP түлхүүрийн сан цахим хуудсанд оруулсан байх.
5. Холбогдож буй систем олон улсад итгэмжлэгдсэн SSL тоон гэрчилгээтэй байх.
6. Хөгжүүлэлт хийж буй байгууллага нь ядаж нэг Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй “Гэрчилгээжүүлэх Байгууллага”-аас олгогдсон тоон гэрчилгээг агуулсан И-Токен төхөөрөмжтэй байх.

Tender.mn программын судалгааны дүгнэлт:

Tender.mn сайтын судалгааны зорилго нь www.tender.mn сайтын ажиллагааны тогтолцоог ашиглан “АМГТГ”-н тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг дижиталжуулах боломжтой эсэхийг судлахад оршиж байгаа юм. Судалгааг уг сайтын ерөнхий мэдээлэл болон гол ашиглаж буй эрх зүйн баримт бичигт үндэслэн хийсэн. Tender.mn сайтыг ажиллагаа нь Төрийн худалдан авах ажиллагааны

газрын “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-аар зохицуулагдаж байсан бөгөөд судалгаанд энэхүү журамд туссан заалтуудыг зураглалд оруулан боловсруулж “АМГТГ”-н “Хайгуулын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтын журам”-н үе шатуудтай харьцуулж “Хайгуулын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтын журам”-д туссан үе шатуудыг tender.mn сайтаар дижиталжуулах боломжийг гаргасан.

Үр дүнгээр tender.mn сайт нь сонгон шалгаруулалтын мэдээллийг олон нийтэд зарлах, сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй этгээд өргөдлийг илгээх, нөгөө талаас өргөдлийг хүлээн авах, сонгон шалгаруулалтын үр дүнг олон нийтэд мэдээлэх гэсэн 4 үе шатыг цахимжуулсан байсан учраас “АМГТГ”-н “Хайгуулын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтын журам”-н дараах үе шатуудыг уг сайтаар дижиталжуулах боломжтой байна:

- Журмын 1.5-т заасан “Төрийн захиргааны байгууллага нь Засгийн газраас тогтоосон талбайн солбицлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ” гэх үе шатыг;
- Журмын 1.9 -т заасан “Журмын 3.1.5-д заасан талбайд сонгон шалгаруулалт явуулахаас 30-аас доошгүй хоногийн өмнө Төрийн захиргааны байгууллага нь сонгон шалгаруулалтын урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ” гэх үе шатыг;
- Журмын 2.1-т заасан “Хуулийн этгээд хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтээ АМТХ-н 10.1.2-т заасан журмын дагуу өргөдлөөр төрийн захиргааны байгууллагад гаргах бөгөөд шаардлагатай баримт бичгийг хавсаргана. (АМТХ 18.1)” гэх үе шатыг;
- Журмын 2.2 “Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийн өргөдлийг хүлээн авч бүртгэх (АМТХ 11.1.16)” гэх үе шатыг;
- Журмын 4.1-т заасан “АМГТГ нь түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох шийдвэрийг хуулийн этгээдэд мэдэгдэнэ” гэх үе шатыг;
- Журмын 4.5-т заасан “АМГТГ хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон даруйд энэ тухай байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн талбай байрших аймаг, сум, дүүргийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын албанд мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ” гэх үе шатыг;

CMCS программын судалгааны дүгнэлт:

CMCS платформын өгөгдлийн бааз дээр нийт 7 үндсэн объектуудыг бүртгэж байгаа ба энэхүү объектуудыг суурь шалгуур болгон Монголын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд туссан үүргүүдтэй харьцуулах замаар тухайн үүргүүдийг CMCS платформыг ашиглан дижиталжуулах боломжтой эсэхийг дүгнэсэн. Энэ судалгааны үр дүнд Монголын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд ашиглагдаж буй 54 объектыг илрүүлсэн ба давхацсан объектуудыг хассаны үр дүнд 28 өвөрмөц объектуудыг тодорхойлсон. Энэ тодорхойлсон объектуудыг CMCS платформ дээр бүртгэл хийж буй объектуудтай харьцуулсны үр дүнд нийт 6 заалтыг CMCS платформыг ашиглан дижиталжуулах боломжтой байна. Үүнд:

1. Энэ хуулийн 11.1.25-д заасны дагуу төрийн захиргааны байгууллага нь **талбайн солбицлыг** тодорхойлохдоо тухайн аймаг, нийслэлийн Засаг даргад бичгээр мэдэгдэх бөгөөд түүнд **талбайн зургийг** хавсаргана. (АМТХ 17.1)
2. Төрийн захиргааны байгууллага нь Засгийн газраас тогтоосон **талбайн солбицлыг** хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ. (ТЗОСШЖ 2.4)
3. Төрийн захиргааны төв байгууллага нь багц мэдээлэлтэй танилцаж, сонгон шалгаруулалт явуулах **талбайг** эцэслэн сонгож, Төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ. (ТЗОСШЖ 3.1.5)

4. АМГТГ нь түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох шийдвэрийг хуулийн этгээдэд мэдэгдэнэ.
5. АМГТГ нь түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг хуулийн этгээдэд олгох (АМТХ 11.1.19)
6. АМГТГ хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон даруйд энэ тухай байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн талбай байрших аймаг, сум, дүүргийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын албанд мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ. (АМТХ 20.7)

заалтууд тус тус багтаж байна.

Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог дижиталжуулах арга замын дүгнэлт:

Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог дижиталжуулах боломжтой арга замуудыг АМГТГ болон УУХҮЯ-н холбогдох ажилтнуудтай ярилцсаны үндсэн дээр дараах арга замуудын хувилбаруудыг тодорхойлсон.

Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны 8 үүргүүдийг хэрэгжиж буй оюуны шийдлүүд буюу дүрэм, журам, заавар үндэслэн **программын өнөөгийн хөгжүүлэлтэд тохируулан** дижиталжуулах боломжтой байна. Үүнд:

1. Ашигт малтмалын тухай хуулийн 11.1.25-д заасны дагуу *“төрийн захиргааны байгууллага нь талбайн солбицлыг тодорхойлохдоо тухайн аймаг, нийслэлийн Засаг даргад бичгээр мэдэгдэх бөгөөд түүнд талбайн зургийг хавсаргах”* үүргийн **тодорхой хэсгийг** MRPAM-н программаар дижиталжуулах боломжтой байна.
2. *“Төрийн захиргааны байгууллага нь Засгийн газраас тогтоосон талбайн солбицлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ”* үүргийг MRPAM-н программ болон Tender.mn программаар дижиталжуулах боломжтой байна.
3. Хайгуулын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтын журмын 3.1.5-д заасан *“талбайд сонгон шалгаруулалт явуулахаас 30-аас доошгүй хоногийн өмнө Төрийн захиргааны байгууллага нь сонгон шалгаруулалтын урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ”* үүргийг MRPAM-н программаар дижиталжуулах боломжтой байна.
4. *“Хуулийн этгээд хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтээ АМТХ-н 10.1.2-т заасан журмын дагуу өргөдлөөр төрийн захиргааны байгууллагад гаргах бөгөөд шаардлагатай баримт бичгийг хавсаргана”* үүргийн **тодорхой** хэсгийг Emongolia программ болон Tender.mn программаар дижиталжуулах боломжтой байна.
5. *“Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийн өргөдлийг хүлээн авч бүртгэх”* үүргийн **тодорхой** хэсгийг Emongolia программ болон Tender.mn программаар дижиталжуулах боломжтой байна.
6. *“АМГТГ нь түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох шийдвэрийг хуулийн этгээдэд мэдэгдэнэ”* үүргийг MRPAM программ болон Tender.mn программаар дижиталжуулах боломжтой байна.
7. *“АМГТГ нь түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг хуулийн этгээдэд олгох”* үүргийг MRPAM программаар дижиталжуулах боломжтой байна.
8. *“АМГТГ хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон даруйд энэ тухай байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн талбай байрших аймаг, сум, дүүргийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын албанд мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ”* үүргийг MRPAM программ болон Tender.mn программаар дижиталжуулах боломжтой байна.

5. НЭГТГЭСЭН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ

Системийн төлөв байдлын оношилгооны дүнгээс харахад АМГТГ-н “Кадастрын хэлтэс” нь системийн доголдлуудаа арилгах дараах шийдлүүдийг боловсруулж, сайжруулах шаардлагатай байна. Үүнд:

1. Нэгдмэл зорилгодоо үйл ажиллагаанд оролцогч талуудын нийтлэг ашиг сонирхлыг тусгаж, **ойлголт бүрийг задалж томьёолон**, бүх ажилтнуудад **танилцуулж** баталгаажуулах.
2. Нэгдмэл зорилгын томьёолол нь **тоон хэлбэрлүү шилжүүлж** болохуйц ойлголтуудаар илэрхийлэх.
3. Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд мөрдөгдөх **тодорхой зарчмуудыг** тодорхойлох.
4. Зорилго, үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх өгөгдөл, мэдээллийг **шуурхай, бүрэн цуглуулж, бүртгэх** шийдлийг боловсруулах.
5. Зорилго, үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх өгөгдөл, мэдээллийг шуурхай **ангилж, боловсруулах** шийдлийг боловсруулах.
6. Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллийг **шуурхай, хүртээмжтэйгээр** түгээх шийдлийг боловсруулах.
7. Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь албадан гүйцэтгэгддэг **үйлдлүүд /үүргүүд/-ээс бүрдүүлэн, ангилж** уялдуулах.
8. Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргүүдийн гүйцэтгэлийг тоон утгаар хэмжиж хэмжүүрүүдийг боловсруулан, ажилтан бүрээр **хүлээн зөвшөөрүүлэх**.
9. Оролцогч талуудын ашиг сонирхлыг хангахад шууд нөлөө үзүүлдэг **үр дүн болон үүргийг биелэлтийн үзүүлэлтүүдийг** боловсруулан, хэрэгжүүлэх.
10. Ажилтнуудыг урт хугацаанд **тогтвортой, үр дүнтэй** хамтран ажиллахыг сэдэлжүүлсэн шийдлүүдийг **сайжруулах**.
11. Зорилгын хэрэгжилтэд учирч буй асуудлуудыг үүсгэж байгаа шалтгааныг оролцогч талууд **тухай бүр олж тогтоох шийдлүүдийг** боловсруулах.
12. Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны гүйцэтгэл /шалтгаан/ болон үр дүн /үр дагавар/ нь тус тусдаа хэмжүүрээр хэмжих.

Стратегийн суурь тогтолцооны загварыг ашиглан системийн доголдлоо арилгаснаар байгууллага тасралтгүй хөгжих боломжтой болно. Системийн доголдлуудыг арилгах шийдлүүдийг бий болгох явцад систем болон дэд тогтолцоонуудын хоорондын нягт уялдааг анхаарах шаардлагатай.

Хурдацтай өөрчлөгдөж байгаа орчин болон бидний мэдлэгийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан системийн доголдлыг арилгах шийдлүүдийн процесс нь тасралтгүй үргэлжилнэ гэдгийг анхаарна уу.

АМГТГ-н “Кадастрын хэлтэс”-н албан тушаалын тодорхойлолтуудад дараах зөвлөмжийн дагуу АТТ-уудад бүрдүүлэх шаардлагатай хэв шинжүүдийг тусган боловсруулж, сайжруулах хэрэгтэй юм. Үүнд:

1. Ажил үүргийг нь орлох албан тушаалтныг тодорхойлж, тусгах
2. Ажлын гүйцэтгэх үе шатуудыг гүйцэтгэх хугацааг тодорхойлж, тусгах
3. Ажлын хүрээнд ХХА-д илгээх мэдээллүүдийг тодорхойлж, тусгах
4. Ажлыг хэрэгжүүлж дуусгаснаар үүсгэх мэдээллийн хэлбэр тодорхойлж, тусгах
5. Ажлыг хэрэгжүүлж дуусгаснаар үүсгэсэн мэдээллийг түгээх сувгийг тодорхойлж, тусгах
6. Ажлыг хэрэгжүүлж дуусгаснаар үүсгэсэн мэдээллийг хүргүүлэх ХХА-уудыг тодорхойлж, тусгах
7. Мэдээлэл үүсгэх ажлын кодыг тусгах
8. Мэдээлэл үүсгэх ажлын нэрийг тодорхойлж, тусгах
9. Үүсгэх мэдээллийг тодорхойлж, тусгах
10. Мэдээллийг үүсгэх хугацаа, давтамжийг тодорхойлж, тусгах
11. Мэдээллийн үүсгэх үе шатыг тодорхойлж, тусгах

12. Ажлуудыг /АТТ-нд туссан/ гүйцэтгэхэд шаардлагатай шийдлүүдийг /аргачлал, алгоритм, дүрэм, журам/ боловсруулж, АТТ-д тусгасан байх

Хайгуулын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтын журмын чанарын түвшин 72.73 хувь бүрдсэн байна. Иймд тухайн системийн оролцогч тал болох ажилтнууд болон удирдлагууд журмын дараах зөвлөмжийн дагуу доголдлуудыг арилган системийн хэвийн ажиллагааг хангах бүрэн боломжтой байна.

1. Хайгуулын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтын журмын үүрэг бүрийг гүйцэтгэх маягыг боловсруулан журамд хавсаргаж батлуулах
2. Хайгуулын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтын журмын доголдолтой үүргүүдийн үүрэг гүйцэтгэгчийг нарийвчлан тодорхойлж, доголдлыг арилгах

Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог дижиталжуулахад баримтлах жишиг зарчмууд:

АМГТГ-н “Кадастрын хэлтэс” хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог цахимжуулалтаа сайжруулах, нэмэлт хөгжүүлэлт хийхэд дараах зарчмуудыг зөвлөмж болгож байна. Үүнд:

- 1. Зорилгыг хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагааг дижиталжуулахын өмнө оюуны шийдлүүд бэлэн байх**

Програм нь дангаараа ямар нэгэн нийгмийн системийн асуудал, доголдлыг шийдвэрлэх боломжгүй. Тухайн програмыг хэрэгжүүлэх оюуны шийдэл /Хууль тогтоомж, дүрэм журам/ байснаар програм зорилгоо хэрэгжүүлэхэд чиглэсэн хэвийн үйл ажиллагаа явуулах боломж бүрддэг.

- 2. Оюуны шийдлийг дижиталжуулах замаар програм бүтдэг байх**

Програм нь оюуны шийдэл дээр суурилан бүтдэг ба оюуны шийдэлгүйгээр програм бүтээх үйл ажиллагаа нь дийлэнх тохиолдолд асуудалд хүргэдэг. Оюуны шийдлийг нөөц их зарцуулахгүйгээр туршиж, сул талуудыг илрүүлж, шуурхай засварлах боломжтой байдаг бол програм дээр нэмэлт хөгжүүлэлт хийх, засварлах, тохируулах гэсэн үйлдлүүд маш их нөөц зарцуулах сул талтай. Улмаар туршигдсан оюуны шийдлийг дижиталжуулах нь ирээдүйд гарах програмын засвар, тохиргооны асуудлуудыг урьдчилан арилгадаг.

- 3. Оюуны шийдэлд туссан ойлголт бүрийг өгөгдөл хүртэл задлан таньж мэдэн, оролцогч талууд ойлголтоо нэгтгэсэн байх**

Програм нь хамгийн суурь логик үйлдлүүдийн цогцоос бүрддэг тул ямар нэгэн хөгжүүлэлтийн үе шатанд ерөнхийлсөн ойлголт ашигласан байвал тухайн ойлголт ирээдүйд програмд доголдол гарах шалтгаан болдог.

- 4. Програм бүрийн зорилго болон хэрэгжилтийг хэмждэг байх**

Програм хөгжүүлэлтийн төслүүдийн 70% амжилтгүй болдог. Тухайн асуудлын суурь шалтгааныг оношилж, илрүүлэхийн тулд заавал хэмжүүр үзүүлэлт хэрэг болдог. Хэмжүүр үзүүлэлтгүйгээр та асуудлаа оношилох боломжгүй.

- 5. “Дижиталжуулах” болон “Автоматжуулах” гэсэн ойлголтууд маш том ялгаатай**

Програм хөгжүүлэх үйл ажиллагаа нь жижиг зорилтуудаас бүрдэх нь давуу талыг авчирдаг. Яг л бусад системтэй адил, програм тань бага багаар төлөвших, сайжрах боломжийг олгох ёстой. Анхнаас нь бүх үүргүүдийг автоматжуулсан төгс програм хүсэх нь нөөцийн хувьд үр ашиггүй бөгөөд, та дундуур нь анх төлөвлөсөн програмын хэв шинжүүд зөв/буруу байсан эсэхийг дүгнэн, өөрчлөх боломж олгодоггүй. Дижиталжуулна гэдэг нь тогтмол чанартай өгөгдөл бүртгэх боломжийг бүрдүүлдэг, мөн автоматжуулах боломжийг бүрдүүлдэг.

6. ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ТОГТОЛЦООНЫ ЦАХИМЖУУЛАЛТЫН БЭЛЭН БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны цахимжуулалтын бэлэн байдлын түвшинг судалгааны аргачлалын дагуу дараах гурван хэмжүүр үзүүлэлтүүдээр хэмжин дүгнэлт бэлтгэв. Үүнд:

1. АМГТГ-н “Кадастрын хэлтэс”-н системийн төлөв байдлын оношилгооны дүн
2. Албан тушаалын тодорхойлолтын хэв шинжүүдийг бүрдүүлсэн түвшин
3. Хайгуулын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтын журмын чанарын түвшин

Дээрх хэмжүүр үзүүлэлтүүдийн тус бүрийн гүйцэтгэлийг тогтоосны үндсэн дээр хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны цахимжуулалтын бэлэн байдлын түвшинг тодорхойлсон бөгөөд үнэлгээ хийхдээ захиалагч байгууллагаас илгээсэн дараах мэдээллүүдэд үндэслэн үнэлгээг гүйцэтгэсэн болно.

Хүснэгт 6: Байгууллагын системийн төлөв байдалд оношилгоо хийх зорилгоор цуглуулсан мэдээллийн бүртгэл

№	Шаардлагатай мэдээллүүдийн агуулга	Баталсан огноо	Баталсан дугаар	Хэлбэр
1	<u>Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам</u>	2019	39	Онлайнаар
2	<u>Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх</u>	2019	38	Онлайнаар
3	<u>Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам</u>	2019	36	Онлайнаар
4	<u>Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль</u>	2020	-	Онлайнаар
5	<u>Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам</u>	2020	-	Онлайнаар
6	<u>Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээ</u>	2019	-	Онлайнаар
7	<u>Төрийн албан хаагчид шагнал олгох журам</u>	2019	-	Онлайнаар
8	<u>Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль</u>	2011	-	Онлайнаар
9	<u>Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль</u>	2002		Онлайнаар
10	<u>Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм</u>	2019	33	Онлайнаар
11	<u>Төрийн албаны тухай хууль</u>	2017	-	Онлайнаар
12	<u>Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль</u>	2020	-	Онлайнаар
13	<u>Статистикийн тухай хууль</u>	1997	-	Онлайнаар
14	<u>Зөрчлийн тухай хууль</u>	2017	-	Онлайнаар
15	<u>Төрийн хяналт шалгалтын тухай хууль</u>	2003	-	Онлайнаар
16	4 Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг	2015/06/12	108	Онлайнаар

Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны цахимжуулалтын бэлэн байдлын үнэлгээ

тооцох журам				
17	Байгууллагын дэргэдэдэх баримт бичиг нягтлан шалгах комиссын дүрэм	2015/09/01	A/78	Онлайнаар
18	Байгууллагын архивын ажлын үндсэн заавар батлах тухай	2007/06/07	59	Онлайнаар
19	Ашигт малтмал газрын тосны газрын хөдөлмөрийн дотоод журам	2019/06/07	A/108	Онлайнаар
20	Бүтэц, орон тоо шинэчлэн батлах тухай	2020/11/25	A/120	Онлайнаар
21	Ашигт малтмал газрын тосны газрын мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах журам	2021/02/25	A/35	Онлайнаар
22	Геологи, уул уурхай, эрдэс баялгийн мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журам	2018/02/05	A/19	Онлайнаар
23	Ашигт малтмал газрын тосны газрын бүтцийн ерөнхий бүдүүвч, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр	2020/11/04	A/272	Онлайнаар
24	Албан тушаалын тодорхойлолт /18ш/	-	-	Онлайнаар
25	Эйбл программын мэдээлэл	-	-	Онлайнаар

6.1 АМГТГ-н Кадастрын хэлтсийн системийн төлөв байдлын оношилгоо



АМГТГ-ын “Кадастрын хэлтэс” нь системийн төлөв байдлын оношилгооны нэгдсэн дүнгээр **69.94** хувийн үнэлгээ авсан. Энэ нь системийн төлөв байдлын түвшингийн ангиллын дагуу **ASA - IV** буюу **Эрсдэлийн нөлөөллийг бууруулах чадвартай систем**-н ангилалд хамаарч байна.

Хүснэгт 7: Системийн төлөв байдлын оношилгооны дүн

№	Дэд тогтолцоонууд	Хэвийн үйл ажиллагаатай байгууллагын дүн /оноогоор/	Оношилгооны дүн /оноогоор/	Хэвийн үйл ажиллагаатай байгууллагын дүн /хувиар/	Оношилгооны дүн /хувиар/	Хамаарах ангилал
1	Зорилгын тайллын дэд тогтолцоо	84	62.61	100.00%	74.54%	ASA - III
2	Мэдээллийн урсгалын дэд тогтолцоо	120	90	100.00%	75.00%	ASA - III
3	Үүргийн гүйцэтгэлийн дэд тогтолцоо	72	44.1	100.00%	61.25%	ASA - IV
4	Эргэх холбооны дэд тогтолцоо	72	45	100.00%	62.50%	ASA - IV
5	Хэмжүүр үзүүлэлтийн дэд тогтолцоо	132	94	100.00%	71.21%	ASA - III
Системийн төлөв байдлын оношилгооны дүн		480	335.71	100.00%	69.94%	ASA - IV

АМГТГ-н “Кадастрын хэлтэс”-ийн **зорилгын тайллын дэд тогтолцоо** нь **62.61** оноо авсан бөгөөд хэвийн үйл ажиллагаатай байгууллагын зорилгын тайллын дэд тогтолцооны дүнтэй харьцуулахад **21.39** оноогоор бага байна. Өөрөөр хэлбэл Нэгдмэл зорилго нь албан ёсоор баталгаажсан байх ёстой дэд тогтолцоог **74.54** хувь бүрдүүлсэн буюу **“Эрсдэлийн нөлөөллийг тогтоон барих чадвартай систем”**-д хамаарч байна. “Кадастрын хэлтэс”-ийн тогтолцоонд дараах доголдуудаас үүдэлтэй байна. Үүнд:

1. Зорилгод тусгагдсан ойлголт бүрийг задалж томъёолоогүй байгаа нь оролцогч бүрт нэг утгаар ойлгогдохгүй байх асуудлын үндсэн шалтгаан болсон.
2. Зорилгын томъёолол нь тоон хэлбэрлүү шилжүүлж болохуйц ойлголтуудаар илэрхийлэгдээгүй.
3. Зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд мөрдөгдөх тодорхой зарчмуудыг тодорхойлоогүй байна.

АМГТГ-н “Кадастрын хэлтэс”-ийн **мэдээллийн урсгалын дэд тогтолцооны** хувьд **120** оноо авахаас **90** оноо авсан нь хэвийн үйл ажиллагаатай байгууллагын мэдээллийн урсгалын дэд тогтолцооны дүнгээс **30** оноогоор бага байна. Энэ нь тухайн байгууллагын мэдээллийн урсгалын дэд тогтолцоо буюу үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай чанартай мэдээллүүдийг цуглуулж, боловсруулж, түгээдэг байх дэд тогтолцоо **75** хувьтай байгаа буюу “**Эрсдэлийн нөлөөллийг тогтоон барих чадвартай систем**”-д хамаарч байна. Үүний гол шалтгаан нь дараах доголдлуудаас үүсч байна. Үүнд:

1. Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх өгөгдөл, мэдээллийг **шуурхай цуглуулж, бүртгэдэг байх** нийтлэг үүргийг ажилтан бүрт хүлээлгээгүй.
2. Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх явцад бүртгэгдсэн **мэдээллийг боловсруулдаг байх** нийтлэг үүргийг ажилтнуудад ажилтнуудад хүлээлгээгүй.
3. Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх явцад бүртгэгдсэн мэдээллийг **шуурхай/тухай бүр боловсруулдаг** байх нийтлэг үүргийг ажилтан бүрт хүлээлгээгүй.
4. Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргийг гүйцэтгэхэд **шаардлагатай мэдээллийг түгээдэг байх** нийтлэг үүргийг ажилтан бүрт хүлээлгээгүй.
5. Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргийг гүйцэтгэхэд **шаардлагатай мэдээллийг тухай бүр/шуурхай түгээдэг байх** нийтлэг үүргийг ажилтан бүрт хүлээлгээгүй.
6. Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллийг **хүртээмжтэйгээр түгээдэг байх ёстой** хэв шинжийг дүрэм, журамд тусгаагүй байна.

Тус хэлтсийн **үүргийн гүйцэтгэлийн дэд тогтолцоо** нь **72** оноо авахаас **44.1** оноо авсан. Өөрөөр хэлбэл, үүргийн гүйцэтгэлийн дэд тогтолцоо нь **61.25** хувьтай бүрдсэн буюу “**Эрсдэлийн нөлөөллийг бууруулах чадвартай систем**”-д **хамаарч** байна. Үүний гол шалтгаан нь дараах доголдлуудаас үүсч байна.

1. Байгууллагын дүрэм, журмуудыг албадан гүйцэтгэгддэг үйлдлүүд /үүргүүд/-ээс бүрэн бүрдүүлээгүй.
2. Хөдөлмөрийн дотоод журамд туссан үүргүүдийг нийтлэг хэв шинжүүдээр нь ангилж тодорхойлоогүй.
3. Дүрэм, журамд туссан үүргүүд нь бие биентэйгээ цогц уялдаагүй.
4. Байгууллагын удирдлага болон ажилтнуудын үүргүүдийн гүйцэтгэлийг хэмжих тоон утгаар хэмжиж болохуйц хэмжүүрийг боловсруулаагүй.
5. Байгууллагын дүрэм, журамд туссан үүргүүдийг тухайн үүргийг хүлээсэн ажилтан, удирдлага гэх мэт оролцогч тал бүртэй хэлэлцүүлж санал аваагүй байгаа учраас оролцогч бүр хүлээн зөвшөөрсөн байх ёстой хэв шинжийг огт хангаагүй.

Харин **эргэх холбооны дэд тогтолцоо** буюу зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь байнга төгөлдөрждөг байх дэд тогтолцооны хувьд **72** оноо авах ёстойгоос **45** авсан нь тухайн дэд тогтолцоо **62.5** хувьтай гарсан буюу “**Эрсдэлийн нөлөөллийг бууруулах чадвартай систем**”-д **хамаарч** байна. Тус дэд тогтолцоог бүрэн бүрдүүлж чадаагүй байгаа шалтгаан нь дараах доголдлуудад байна.

1. Нэгдмэл зорилгын хэрэгжилтийн үр дүнгийн хэмжүүр үзүүлэлтүүдийг **оролцогч тал** бүрээр тодорхойлоогүй байгаа тул оролцогч талуудын ашиг сонирхлыг хангахад шууд нөлөө үзүүлдэг байх ёстой хэв шинжийг бүрэн бүрдүүлээгүй.
2. Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргүүдийн биелэлт нь оролцогч талуудын ашиг сонирхлыг хангахад шууд нөлөө үзүүлдэг байх ёстой хэв шинжийг дүрэм журамд огт тусгаагүй байна.
3. Үйл ажиллагаанд учирч буй **доголдол, зөрчлийг үүсгэж байгаа шалтгааныг** оролцогч талууд тухай бүр олж тогтоодог байх ёстой хэв шинжийг бүрдүүлээгүй байна.

Стратегийн суурь тогтолцооны сүүлийн дэд тогтолцоо болох **хэмжүүр үзүүлэлтийн дэд тогтолцооны** хувьд тухайн байгууллага **132** оноо авахаас **94** оноо авч, тус дэд тогтолцоог **71.21** хувьтай бүрдүүлсэн байна. Өөрөөр хэлбэл, “**Эрсдэлийн нөлөөллийг тогтоон барих чадвартай систем**”-нд хамаарч байна. Хэвийн үйл ажиллагаатай байгууллагын дүнтэй харьцуулсан зөрүүг үүсгэхэд дараах доголдлууд нөлөөлсөн.

1. Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны **гүйцэтгэлийг** бүх оролцогч бүрийн үүргийн **гүйцэтгэлийн нийлбэрээр хэмждэг** байх ёстой хэв шинжийг хангаагүй.
2. Нэгдмэл зорилгын хэрэгжилтийн **үр дүн** нь оролцогч талуудын ашиг сонирхлыг тусгасан **олон хэмжээст хэмжүүрүүдээр** хэмжигддэггүй.
3. Нэгдмэл зорилгын хэрэгжилтийн **үр дүнг** оролцогч талууд **нийтлэг хэмжүүрээр хэмждэг байх** ёстой хэв шинжийг бүрдүүлээгүй.
4. Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны **гүйцэтгэл /шалтгаан/ болон үр дүн /үр дагавар/** нь тус тусдаа **хэмжүүртэй байх** ёстой хэв шинжийг дүрэм, журамд тусгаагүй.
5. Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны **үр дүн** ба гүйцэтгэлийн **хоорондын хамаарлыг** хэмждэг хэмжүүргүй.

Мөн оношилгооны нэг бүрэлдэхүүн хэсэг болон ажилтнуудад тулгарч буй 10 асуудлуудыг санал асуулгаар тодорхойлсон. Тус асуулгаар нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай дараах 3 асуудлыг тогтоосон юм. Үүнд:

4. Ажилтнууд тэгш бус ачаалалтай ажилладаг
5. Ажилтнуудаа сургаж хөгжүүлдэггүй
6. Газар нэгжийн ажлууд хоорондоо уялддаггүй

Эдгээр асуудлуудын суурь шалтгаан нь дээрх 5 дэд тогтолцоонд үүссэн системийн доголдлуудаас шалтгаалан бий болж байна. Тухайн системийн доголдлуудыг арилгах шийдлүүдийг нэн даруй боловсруулж, хэрэгжүүлэх хэрэгтэй ба эс бөгөөс үүссэн сөрөг асуудлуудыг шийдэхэд байгууллага нөөцөө зарцуулсаар байх болно.

Ерөнхий санал, зөвлөмж

Системийн төлөв байдлын оношилгооны дүнгээс харахад АМГТГ-н “Кадастрын хэлтэс” нь системийн доголдлуудаа арилгах дараах шийдлүүдийг боловсруулж, сайжруулах шаардлагатай байна. Үүнд:

1. Нэгдмэл зорилгодоо үйл ажиллагаанд оролцогч талуудын нийтлэг ашиг сонирхлыг тусгаж, ойлголт бүрийг задалж томъёолон, бүх ажилтнуудад танилцуулж баталгаажуулах.
2. Нэгдмэл зорилгын томъёолол нь тоон хэлбэр рүү шилжүүлж болохуйц ойлголтуудаар илэрхийлэх.
3. Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд мөрдөгдөх тодорхой зарчмуудыг тодорхойлох.
4. Зорилго, үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх өгөгдөл, мэдээллийг шуурхай, бүрэн цуглуулж, бүртгэх шийдлийг боловсруулах.
5. Зорилго, үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх өгөгдөл, мэдээллийг шуурхай ангилж, боловсруулах шийдлийг боловсруулах.
6. Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллийг шуурхай, хүртээмжтэйгээр түгээх шийдлийг боловсруулах.
7. Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь албадан гүйцэтгэгддэг үйлдлүүд /үүргүүд/-ээс бүрдүүлэн, ангилж уялдуулах.
8. Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргүүдийн гүйцэтгэлийг тоон утгаар хэмжиж хэмжүүрүүдийг боловсруулан, ажилтан бүрээр хүлээн зөвшөөрүүлэх.
9. Оролцогч талуудын ашиг сонирхлыг хангахад шууд нөлөө үзүүлдэг үр дүн болон үүргийг биелэлтийн үзүүлэлтүүдийг боловсруулан, хэрэгжүүлэх.

10. Ажилтнуудыг урт хугацаанд тогтвортой, үр дүнтэй хамтран ажиллахыг сэдэлжүүлсэн шийдлүүдийг сайжруулах.
11. Зорилгын хэрэгжилтэд учирч буй асуудлуудыг үүсгэж байгаа шалтгааныг оролцогч талууд тухай бүр олж тогтоох шийдлүүдийг боловсруулах.
12. Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны гүйцэтгэл /шалтгаан/ болон үр дүн /үр дагавар/ нь тус тусдаа хэмжүүрээр хэмжих.

Стратегийн суурь тогтолцооны загварыг ашиглан системийн доголдлоо арилгаснаар байгууллага тасралтгүй хөгжих боломжтой болно. Системийн доголдлуудыг арилгах шийдлүүдийг бий болгох явцад систем болон дэд тогтолцоонуудын хоорондын нягт уялдааг анхаарах шаардлагатай.

Хурдацтай өөрчлөгдөж байгаа орчин болон бидний мэдлэгийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан системийн доголдлыг арилгах шийдлүүдийн процесс нь тасралтгүй үргэлжилнэ гэдгийг анхаарна уу.

Дэд тогтолцоонуудтой холбоотой илүү дэлгэрэнгүй санал, зөвлөмжийг доорх хэсгээс харна уу.

АМГТГ-н “Кадастрын хэлтэс”-ийн уялдааны индекс

АМГТГ-н “Кадастрын хэлтэс”-ийн системийн уялдааны индекс нь **68.92** хувийн үнэлгээтэйгээр **SU-II** ангилал буюу **системийн тогтолцооны уялдааг сайжруулах шаардлагатай** байна. Дэд тогтолцоо бүрийн хоорондох уялдааг Хүснэгт 6-т харуулав.

Хүснэгт 8: Дэд тогтолцоонуудын уялдааны түвшин


Дэд тогтолцоо	Зорилгын тайллын дэд тогтолцоо	Мэдээллийн урсгалын дэд тогтолцоо	Үүргийн гүйцэтгэлийн дэд тогтолцоо	Эргэх холбооны дэд тогтолцоо	Хэмжүүр үзүүлэлтүүдийн дэд тогтолцоо
Зорилгын тайллын дэд тогтолцоо	73.17%	73.57%	66.66%	67.38%	71.94%
Мэдээллийн урсгалын дэд тогтолцоо	73.57%	73.63%	66.84%	67.56%	72.14%
Үүргийн гүйцэтгэлийн дэд тогтолцоо	66.66%	66.84%	60.44%	61.22%	65.37%
Эргэх холбооны дэд тогтолцоо	67.38%	67.56%	61.22%	61.75%	66.07%
Хэмжүүр үзүүлэлтүүдийн дэд тогтолцоо	71.94%	72.14%	65.37%	66.07%	70.48%
Дэд тогтолцооны уялдааны дүн	71.03%	71.22%	64.71%	65.39%	69.71%
Уялдааны индексийн нийт дүн	68.92%				

1. Зорилгын тайллын дэд тогтолцооны уялдааны индекс **73.17** хувийн үнэлгээтэйгээр **SU-II** ангилалд байгаа тул **системийн уялдааг сайжруулах шаардлагатай** байна.
2. Мэдээллийн урсгалын дэд тогтолцоо **73.63** хувийн үнэлгээтэйгээр **SU-II** ангилалд байгаа тул **системийн уялдааг сайжруулах шаардлагатай** байна.
3. Үүргийн гүйцэтгэлийн дэд тогтолцооны уялдааны индекс **60.44** хувийн үнэлгээтэйгээр **SU-I** ангилалд хамаарч байна. Өөрөөр хэлбэл, **уялдааг бий болгох шаардлагатай** байна.
4. Эргэх холбооны дэд тогтолцоо **61.75** хувийн үнэлгээтэйгээр **SU-I** ангилалд байгаа тул **Уялдааг бий болгох шаардлагатай** байна.
5. Хэмжүүр үзүүлэлтийн дэд тогтолцоо **70.48** хувийн үнэлгээтэйгээр **SU-II** ангилалд байгаа тул **системийн уялдааг сайжруулах шаардлагатай** байна.

Хүснэгт 9: Дэд тогтолцоонуудын уялдааны ангилал

№	Ангилал	Уялдааны хувь	Хамаарах өнгө
1	SU I - Уялдааг бий болгох шаардлагатай	50% - 67%	
2	SU II - Уялдааг сайжруулах шаардлагатай түвшин	68% - 79%	+
3	SU III - Хэвийн түвшин	80% - 100%	

Зорилгын тайллын дэд тогтолцоо /ЗТ/



Зорилгын тайллын дэд тогтолцоо: Эрүүл байгууллага нь оролцогч талуудын хэрэгцээг холбож нэгтгэсэн, Нэгдмэл зорилго той байх ёстой. Тухайн дэд тогтолцоо нь оролцогч нэг бүрт ижил утгаар ойлгогддог Нэгдмэл зорилго той болох боломжийг олгодог.

АМГТГ-н “Кадастрын хэлтэс”-ийн зорилгын тайллын дэд тогтолцоо нь **74.54** хувийн үнэлгээтэйгээр **ASA-III** буюу “Эрсдэлийн нөлөөллийг тогтоон барих чадвартай систем”-н ангилалд хамаарч байна. *Хүснэгт 3*

Зорилгын тайллын дэд тогтолцооны уялдааны индекс **73.17** хувийн үнэлгээтэйгээр **SU-II** ангилалд хамаарч байна. Өөрөөр хэлбэл, **системийн уялдааг сайжруулах шаардлагатай** байна. *Хүснэгт 6*

Хүснэгт 10: ЗТ-ын дэд тогтолцооны оношилгооны дүн

№	Системийн хэв шинжүүд	Байвал зохих түвшин	Оношилгооны дүн /оноогоор/	Оношилгооны дүн /хувиар/	Доголдлын түвшин
ЗТ.1	Нэгдмэл зорилго нь албан ёсоор баталгаажсан байх ёстой	12	12	100.00%	Хэв шинжийг бүрэн бүрдүүлсэн
ЗТ.2	Нэгдмэл зорилгыг дэд зорилгуудад задалж томъёолсон байх ёстой.	12	12	100.00%	Хэв шинжийг бүрэн бүрдүүлсэн
ЗТ.3	Нэгдмэл зорилгын ойлголт бүрийг задалж томъёолсон байх ёстой	12	6	50.00%	Хэв шинжийг бүрдүүлээгүй
ЗТ.4	Нэгдмэл зорилго нь оролцогч бүрт нэг мөр ойлгогддог байх ёстой	12	9.36	78.00%	Хэв шинжийг харьцангуй сайн бүрдүүлсэн
ЗТ.5	Нэгдмэл зорилго нь оролцогч талуудын нийтлэг ашиг сонирхлыг тусгасан байх ёстой	12	9.25	77.08%	Хэв шинжийг харьцангуй сайн бүрдүүлсэн
ЗТ.6	Нэгдмэл зорилгын томъёолол нь тоон хэлбэрлүү шилжүүлж болохуйц ойлголтуудаар илэрхийлэгдсэн байх ёстой	12	7	58.33%	Хэв шинжийг дутуу бүрдүүлсэн
ЗТ.7	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд мөрдөгдөх тодорхой зарчмуудыг тодорхойлсон байх ёстой	12	7	58.33%	Хэв шинжийг дутуу бүрдүүлсэн
Нийт үнэлгээ		84	62.61	74.54%	ASA - III

ЗТ.1: Зорилгын тайллын дэд тогтолцооны нэгдүгээр хэв шинж буюу нэгдмэл зорилго албан ёсоор баталгаажсан байх ёстой хэв шинж **100.00** хувь бүрдсэн. */Хавсалт 2/*

ЗТ.2: Зорилгын тайллын дэд тогтолцооны хоёрдугаар хэв шинж буюу нэгдмэл зорилгыг дэд зорилгуудад задалж томъёолсон байх хэв шинж **100.00** хувь бүрдсэн байна. */Хавсалт 2/*

ЗТ.3: Зорилгын тайллын дэд тогтолцооны гуравдугаар хэв шинж **50.00** хувийн үнэлгээ авсан учраас хэв шинжийг бүрдүүлж чадаагүй байна. Үүний гол шалтгаан нь нэгдмэл зорилгын ойлголт бүрийг задалж

томьёолоогүй бөгөөд тухайн хэв шинжийг тогтвортой бүрдүүлэх үүргүүдийг дүрэм, журамд огт тусгаагүй байна. Иймд ЗТ.3-н 6 шалгуурын **бүх шалгуурыг** хангахгүй байна. Системийн зарчмын дагуу аливаа системд оюуны шийдлүүд нь албан ёсоор боловсруулагдаж, баталгаажуулагдаагүй ч үйл ажиллагаа тодорхой хэмжээ явагдаж байдаг тул системийн төлөв байдлын оношилгоогоор хамгийн багадаа 50 хувийг үнэлгээ авах юм. /Хавсалт 2/

ЗТ.4: Зорилгын тайллын дэд тогтолцооны дөрөвдүгээр хэв шинжийг **78.00** хувийн үнэлгээ авсан тул тухайн хэв шинжийг харьцангуй сайн бүрдүүлсэн байна. Бүрэн үнэлгээ авч чадаагүй шалтгаан нь ЗТ.4-н 6 шалгуурын **3** шалгуур болох нэгдмэл зорилгыг оролцогч бүрт тайлбарлах үүрэг хүлээсэн этгээд болох байгууллагын удирдлагын үүргийн хэрэгжилтийг баримт, фактад үндэслэн шалгах, үүргийн хэрэгжилтийн талаарх мэдээллийн тогтмол урсгалыг шалгах боломжгүй бөгөөд зорилгод туссан ойлголтуудыг задалж томьёолоогүй байгаагаас шалтгаалсан. /Хавсалт 2/

ЗТ.5: Зорилгын тайллын дэд тогтолцооны тавдугаар хэв шинж нь **77.08** хувийн үнэлгээ авсан тул тухайн хэв шинжийг харьцангуй сайн бүрдүүлсэн байна. Үүний шалтгаан нь ЗТ.5-н 6 шалгуурын **3** шалгуурыг хангахгүй байна. Өөрөөр хэлбэл, Нэгдмэл зорилгод оролцогч талуудын нийтлэг ашиг сонирхлыг тусгах үүргийг тодорхой этгээд болох байгууллагын удирдлагын үүргийн хэрэгжилтийг баримт, фактад үндэслэн шалгах, үүргийн хэрэгжилтийн талаарх мэдээллийн тогтмол урсгалыг шалгах боломжгүй мөн зорилгод оролцогч бүрийн нийтлэг ашиг сонирхол тусгагдаагүй байна. /Хавсалт __/

ЗТ.6: Зорилгын тайллын дэд тогтолцооны зургаадугаар хэв шинж буюу нэгдмэл зорилгын томьёолол нь тоон хэлбэрлүү шилжүүлж болохуйц ойлголтуудаар илэрхийлэгдсэн байх хэв шинжийг **58.33** хувь буюу хэв шинжийг дутуу бүрдүүлсэн бөгөөд ЗТ.5-н 6 шалгуурын **5** шалгуурыг хангахгүй байна. /Хавсалт 2/

ЗТ.7: Зорилгын тайллын дэд тогтолцооны долдугаар хэв шинж **58.33** хувийн үнэлгээ авсан бөгөөд хэв шинжийг дутуу бүрдүүлсэн байна. Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд мөрдөгдөх тодорхой зарчмуудыг тодорхойлоогүй, тухайн хэв шинжийг тогтвортой бүрдүүлэх шийдлүүдийг дүрэм, журамд огт тусгаагүйгээс ЗТ.7-н 6 шалгуурын **5** шалгуурыг хангахгүй байна. /Хавсалт 2/

Санал, зөвлөмж

Хүснэгт 11: Зорилгын тайллын дэд тогтолцоонуудын доголдлыг арилгах шийдлүүдийн зөвлөмж

№	Хангаагүй шалгуурын код	Зорилгын тайллын дэд тогтолцоонуудын доголдлыг арилгах шийдлүүдийн зөвлөмж
ЗТ.3	Ш.1	Нэгдмэл зорилгын томьёололд орсон ойлголт бүрийн хэв шинжүүдийг задалж томьёолсон байх хэв шинжийг дүрэм, журамд тусгах
	Ш.2	Нэгдмэл зорилгын ойлголт бүрийг задалж, томьёолох үүрэг бүхий этгээдийг тодорхойлж, дүрэм, журамд тусгах
	Ш.3	Нэгдмэл зорилгын ойлголт бүрийг задалж, томьёолох үүрэг бүхий этгээдийн үүргийн хэрэгжилтийг баримт, фактад үндэслэн шалгах шийдлийг боловсруулж дүрэм журамд тусгах
	Ш.4	Нэгдмэл зорилгын ойлголт бүрийг задалж, томьёолох үүргийн биелэлтийн мэдээллийг түгээх үүргийг дүрэм журамд тусгах
	Ш.5	Нэгдмэл зорилгыг томьёолохдоо ойлголт бүрийг задалж томьёолох үүргээ биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлж дүрэм, журамд тусгах
	Ш.6	Нэгдмэл зорилгын томьёололд орсон ойлголт бүрийн хэв шинжүүдийг задалж томьёолох шийдлийг Ш.1, Ш.2, Ш.3, Ш.4, Ш.5 шалгууруудад нийцүүлэн боловсруулж үйл ажиллагаандаа ашиглах
ЗТ.4	Ш.3	Нэгдмэл зорилгыг оролцогч нэг бүрт ойлгомжтой байхаар тайлбарлах үүрэг бүхий этгээдийн үүргийн хэрэгжилтийг баримт, фактад үндэслэн шалгах шийдлийг боловсруулж дүрэм, журамд тусгах

	Ш.4	Нэгдмэл зорилгыг оролцогч нэг бүрт ойлгомжтой байхаар тайлбарлах үүргийн биелэлтийн мэдээллийг түгээх үүргийг дүрэм, журамд тусгах
	Ш.6	Нэгдмэл зорилгыг оролцогч нэг бүр ойлгох шийдлийг Ш.1, Ш.2, Ш.3, Ш.4, Ш.5 шалгууруудад нийцүүлэн боловсруулж үйл ажиллагаандаа ашиглах
ЗТ.5	Ш.3	Нэгдмэл зорилгод оролцогч талуудын нийтлэг ашиг сонирхлыг тусгах үүрэгтэй этгээдийн үүргийн хэрэгжилтийг баримт, фактад үндэслэн шалгах шийдлийг боловсруулж дүрэм, журамд тусгах
	Ш.4	Нэгдмэл зорилгод оролцогч талуудын нийтлэг ашиг сонирхлыг тусгах үүргийн биелэлтийн мэдээллийг түгээх шийдлийг боловсруулж дүрэм, журамд тусгах
	Ш.6	Нэгдмэл зорилгод оролцогч талуудын нийтлэг ашиг сонирхлыг тусгах шийдлийг Ш.1, Ш.2, Ш.3, Ш.4, Ш.5 шалгууруудад нийцүүлэн боловсруулж үйл ажиллагаандаа ашиглах
ЗТ.6	Ш.1	Нэгдмэл зорилгын томьёолол нь тоон хэлбэрлүү шилжүүлж болохуйц ойлголтуудаар илэрхийлэгдсэн байх хэв шинжийг дүрэм, журамд тусгах
	Ш.2	Нэгдмэл зорилгын томьёолол нь тоон хэлбэрлүү шилжүүлж болохуйц ойлголтуудаар илэрхийлэх үүрэгтэй этгээдийг тодорхойлж дүрэм, журамд тусгах
	Ш.3	Нэгдмэл зорилгын томьёолол нь тоон хэлбэрлүү шилжүүлж болохуйц ойлголтуудаар илэрхийлэх үүрэгтэй этгээдийн үүргийн хэрэгжилтийг баримт, фактад үндэслэн шалгах шийдлийг боловсруулж дүрэм, журамд тусгах
	Ш.4	Нэгдмэл зорилгын томьёолол нь тоон хэлбэрлүү шилжүүлж болохуйц ойлголтуудаар илэрхийлэх үүргийн биелэлтийн мэдээллийг түгээх үүргийг дүрэм, журамд тусгах
	Ш.5	Нэгдмэл зорилгын томьёолол нь тоон хэлбэрлүү шилжүүлж болохуйц ойлголтуудаар илэрхийлэх үүргээ биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлж дүрэм, журамд тусгах
ЗТ.7	Ш.1	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд мөрдөгдөх тодорхой зарчмуудыг тодорхойлсон байх хэв шинжийг дүрэм, журамд тусгах
	Ш.2	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд мөрдөгдөх тодорхой зарчмуудыг батлах үүрэгтэй этгээдийг тодорхойлж дүрэм, журамд тусгах
	Ш.3	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд мөрдөгдөх тодорхой зарчмуудыг батлах үүрэгтэй этгээдийн үүргийн хэрэгжилтийг баримт, фактад үндэслэн шалгах шийдлийг боловсруулж дүрэм, журамд тусгах
	Ш.4	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд мөрдөгдөх тодорхой зарчмуудыг батлах үүргийн биелэлтийн мэдээллийг түгээх үүргийг боловсруулж дүрэм, журамд тусгах
	Ш.5	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд мөрдөгдөх тодорхой зарчмуудыг батлах үүргээ биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлж дүрэм, журамд тусгах

Мэдээллийн урсгалын дэд тогтолцоо /МУ/



Мэдээллийн урсгалын дэд тогтолцоо: Байгууллагын оролцогч талуудын хооронд чанартай өгөгдлийг хурдан, шуурхай урсгадаг байх ёстой. Тухайн дэд тогтолцоо нь хэт их мэдээлэл урсгахаас урьдчилан сэргийлж, цөөхөн гэхдээ чанартай өгөгдлийг ашиглан хурдацтай өөрчлөгдөж буй орчинд илүү дасан зохицох чадвартай болгож, шийдвэрийг хурдан бөгөөд үнэн зөв гаргах боломжийг

АМГТГ-н “Кадастрын хэлтэс”-ийн мэдээллийн урсгалын дэд тогтолцоо нь **75** хувийн үнэлгээтэйгээр ASA-IV буюу “Эрсдэлийн нөлөөллийг бууруулах чадвартай систем”-н ангилалд хамаарч байна. *Хүснэгт 5*

Тухайн дэд тогтолцооны уялдааны индекс **73.63** хувийн үнэлгээтэйгээр SU-II буюу системийн уялдааг сайжруулах шаардлагатай байна. *Хүснэгт 6*

Хүснэгт 12: МУ-ын дэд тогтолцооны оношилгооны дүн

№	Байгууллагын хэв шинжүүд	Байвал зохих түвшин	Оношилгоо ны дүн /оноогоор/	Оношилгооны дүн /хувиар/	Доголдлын түвшин
МУ.1	Урсаж байгаа мэдээлэл нь бодит баримтаар илэрхийлэгддэг байх ёстой	12	12	100.00%	Хэв шинжийг бүрэн бүрдүүлсэн
МУ.2	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх өгөгдөл, мэдээллийг цуглуулж, бүртгэдэг байх ёстой.	12	12	100.00%	Хэв шинжийг бүрэн бүрдүүлсэн
МУ.3	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх өгөгдөл, мэдээллийг шуурхай цуглуулж, бүртгэдэг байх ёстой.	12	8	66.67%	Хэв шинжийг дутуу бүрдүүлсэн
МУ.4	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх өгөгдөл, мэдээллийг бүрэн цуглуулж, бүртгэдэг байх ёстой.	12	11	91.67%	Хэв шинжийг бүрэн бүрдүүлсэн
МУ.5	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх өгөгдөл, мэдээллийг цуглуулж, ангилж бүртгэдэг байх ёстой.	12	12	100.00%	Хэв шинжийг бүрэн бүрдүүлсэн
МУ.6	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх явцад бүртгэгдсэн мэдээллийг боловсруулдаг байх ёстой.	12	8	66.67%	Хэв шинжийг дутуу бүрдүүлсэн
МУ.7	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх явцад бүртгэгдсэн мэдээллийг шуурхай/тухай бүр боловсруулдаг байх ёстой.	12	7	58.33%	Хэв шинжийг дутуу бүрдүүлсэн
МУ.8	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллийг түгээдэг байх ёстой	12	7	58.33%	Хэв шинжийг дутуу бүрдүүлсэн
МУ.9	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллийг тухай бүр/шуурхай түгээдэг байх ёстой	12	7	58.33%	Хэв шинжийг дутуу бүрдүүлсэн

Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргийг				
МУ.10 гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллийг хүртээмжтэйгээр түгээдэг байх ёстой	12	6	50.00%	Хэв шинжийг бүрдүүлээгүй
Нийт үнэлгээ	120	90	75.00%	ASA - III

МУ.1: Мэдээллийн урсгалын дэд тогтолцооны нэгдүгээр хэв шинж буюу урсаж байгаа мэдээлэл нь бодит баримтаар илэрхийлэгддэг байх хэв шинж нь **100** хувь бүрдсэн. Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэхэд бодит факт, баримтаар илэрхийлэгдэх мэдээлэл бэлтгэх нийтлэг үүрэг хүлээсэн этгээдийн үүргийн хэрэгжилтийг баримт, фактад үндэслэн шалгах боломтой бөгөөд тухайн үүргийн хэрэгжилтийн тухай мэдээллээ тогтмол урсдаг байна иймд МУ.1-н 6 шалгуурын **6** шалгуурыг хангаж байна. /Хавсралт 2/

МУ.2: Мэдээллийн урсгалын дэд тогтолцооны хоёрдугаар хэв шинж **100** хувь бүрдсэн байна. Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх өгөгдөл, мэдээллийг цуглуулж, бүртгэдэг байх ёстой хэв шинжийг бүрэн агуулсан тул МУ.2-н 6 шалгуурын **6** шалгуурыг хангаж байна./Хавсралт 2/

МУ.3: Мэдээллийн урсгалын дэд тогтолцооны гуравдугаар хэв шинж **66.67** хувь бүрдсэн. Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх өгөгдөл, мэдээллийг шуурхай цуглуулж, бүртгэх нийтлэг үүргийг ажилтнуудад хүлээлгээгүйгээс МУ.3-н 6 шалгуурын **4** шалгуурыг хангахгүй байна. /Хавсралт 2/

МУ.4: Мэдээллийн урсгалын дэд тогтолцооны дөрөвдүгээр хэв шинж **91.67** хувь бүрдсэн. Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үүргүүдийг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай өгөгдөл мэдээллүүдийг тодорхойлсон байх ёстой хэв шинжийг үйл ажиллагаандаа ашигладаггүй байна МУ.4-н 6 шалгуурын **1** шалгуурыг хангахгүй байна./Хавсралт 2/

МУ.5: Мэдээллийн урсгалын дэд тогтолцооны тавдугаар хэв шинж нь **100** хувь бүрдсэн байна. Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх өгөгдөл, мэдээллийг цуглуулж, ангилж бүртгэдэг байх ёстой хэв шинжийг дүрэм журамд бүрэн тусгасан байга тул МУ.5-н 6 шалгуурын **6** шалгуурыг хангаж байна. /Хавсралт 2/

МУ.6: Мэдээллийн урсгалын дэд тогтолцооны зургаадугаар хэв шинж **66.67** хувь бүрдсэн. Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх явцад бүртгэгдсэн мэдээллийг боловсруулдаг байх нийтлэг үүргийг дүрэм журамд тусгаагүйгээс МУ.6-н 6 шалгуурын **4** шалгуурыг хангахгүй байна./Хүснэгт /

МУ.7: Мэдээллийн урсгалын дэд тогтолцооны долоодугаар хэв шинж нь **58.33** хувь бүрдсэн байна. Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх явцад бүртгэгдсэн мэдээллийг шуурхай/тухай бүр боловсруулдаг байх нийтлэг үүргийг дүрэм журамд тусгаагүйгээс МУ.7-н 6 шалгуурын **5** шалгуурыг хангахгүй байна. /Хавсралт 2/

МУ.8: Мэдээллийн урсгалын дэд тогтолцооны наймдугаар хэв шинж **58.33** хувь бүрдсэн байна. Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллийг түгээдэг байх нийтлэг үүргийг дүрэм журамд тусгаагүйгээс МУ.8-н 6 шалгуурын **5** шалгуурыг хангаагүй./Хавсралт 2/

МУ.9: Мэдээллийн урсгалын дэд тогтолцооны есдүгээр хэв шинж **58.33** хувь бүрдсэн. Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллийг тухай бүр/шуурхай түгээдэг байх нийтлэг үүргийг дүрэм журамд тусгаагүйгээс МУ.9-н 6 шалгуурын **5** шалгуурыг хангахгүй байна./Хавсралт 2/

МУ.10: Мэдээллийн урсгалын дэд тогтолцооны аравдугаар хэв шинж **50.00** хувь бүрдсэн байна. Байгууллагын нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллийг хүртээмжтэйгээр түгээдэг байх ёстой хэв шинжийг дүрэм, журамд тусгаагүй, мэдээллийг тухай бүр/шуурхай түгээдэг байх нийтлэг үүргийг дүрэм журамд тусгаагүйгээс МУ.10-н 6 шалгуурын **6** шалгуурыг бүгдийг нь хангахгүй байна./Хавсралт 2/

Санал, зөвлөмж

Хүснэгт 13: МУ-ын дэд тогтолцооны доголдлыг арилгах шийдлүүдийн зөвлөмж

№	Хангаагүй шалгуурын код	Мэдээллийн урсгалын дэд тогтолцоонуудын доголдлыг арилгах шийдлүүдийн зөвлөмж
МУ.3	Ш.2	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх өгөгдөл, мэдээллийг шуурхай цуглуулж, бүртгэх нийтлэг үүргийг дүрэм, журамд тусгах
	Ш.3	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх өгөгдөл, мэдээллийг шуурхай цуглуулж, бүртгэх нийтлэг үүргийн хэрэгжилтийг баримт, фактад үндэслэн шалгах шийдлийг боловсруулж дүрэм, журамд тусгах
	Ш.4	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх өгөгдөл, мэдээллийг шуурхай цуглуулж, бүртгэх нийтлэг үүргийн биелэлтийн мэдээллийг түгээх шийдлийг боловсруулж дүрэм, журамд тусгах
	Ш.5	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх өгөгдөл, мэдээллийг шуурхай цуглуулж, бүртгэх нийтлэг үүргээ биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлж дүрэм, журамд тусгах
МУ.4	Ш.6	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх өгөгдөл, мэдээллийг бүрэн цуглуулж, бүртгэх шийдлийг Ш.1, Ш.2, Ш.3, Ш.4, Ш.5 шалгууруудад нийцүүлэн боловсруулж үйл ажиллагаандаа ашиглах
МУ.6	Ш.2	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх явцад бүртгэгдсэн мэдээллийг боловсруулдаг байх нийтлэг үүргийг дүрэм журамд тусгах
	Ш.3	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх явцад бүртгэгдсэн мэдээллийг боловсруулдаг байх нийтлэг үүргийн хэрэгжилтийг баримт, фактад үндэслэн шалгах шийдлийг дүрэм журамд тусгах
	Ш.4	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх явцад бүртгэгдсэн мэдээллийг боловсруулдаг байх нийтлэг үүргийн хэрэгжилтийн тухай мэдээлэл тогтмол урсдаг байх шийдлийг дүрэм журамд тусгах
	Ш.5	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх явцад бүртгэгдсэн мэдээллийг боловсруулдаг байх нийтлэг үүргээ биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлж дүрэм, журамд тусгах
МУ.7	Ш.2	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх явцад бүртгэгдсэн мэдээллийг шуурхай/тухай бүр боловсруулдаг байх нийтлэг үүргийг дүрэм журамд тусгах
	Ш.3	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх явцад бүртгэгдсэн мэдээллийг шуурхай/тухай бүр боловсруулдаг байх нийтлэг үүргийн хэрэгжилтийг баримт, фактад үндэслэн шалгах шийдлийг боловсруулан дүрэм, журамд тусгах
	Ш.4	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх явцад бүртгэгдсэн мэдээллийг шуурхай/тухай бүр боловсруулдаг байх нийтлэг үүргийн хэрэгжилтийн тухай мэдээлэл тогтмол урсдаг байх шийдлийг боловсруулан дүрэм, журамд тусгах
	Ш.5	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх явцад бүртгэгдсэн мэдээллийг шуурхай/тухай бүр боловсруулдаг байх нийтлэг үүргээ биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлж дүрэм, журамд тусгах
	Ш.6	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх явцад бүртгэгдсэн мэдээллийг шуурхай/тухай бүр боловсруулдаг байх шийдлийг Ш.1, Ш.2, Ш.3, Ш.4, Ш.5 шалгууруудад нийцүүлэн боловсруулж үйл ажиллагаандаа ашиглах
МУ.8	Ш.2	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллийг түгээдэг байх нийтлэг үүргийг дүрэм журамд тусгах
	Ш.3	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллийг түгээдэг байх нийтлэг үүргийн хэрэгжилтийг баримт, фактад үндэслэн шалгах шийдлийг боловсруулж дүрэм, журамд тусгах
	Ш.4	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллийг түгээдэг байх нийтлэг үүргийн биелэлтийн мэдээллийг түгээх шийдлийг боловсруулж дүрэм,

		журамд тусгах
	Ш.5	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллийг түгээдэг байх нийтлэг үүргээ биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлж журамд тусгах
	Ш.6	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллийг түгээдэг байх шийдлийг Ш.1, Ш.2, Ш.3, Ш.4, Ш.5 шалгууруудад нийцүүлэн боловсруулж үйл ажиллагаандаа ашиглах
МУ.9	Ш.2	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллийг тухай бүр/шуурхай түгээдэг байх нийтлэг үүргийг дүрэм журамд тусгах
	Ш.3	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллийг тухай бүр/шуурхай түгээдэг байх нийтлэг үүргийн хэрэгжилтийг баримт, фактад үндэслэн шалгах шийдлийг боловсруулж дүрэм, журамд тусгах
	Ш.4	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллийг тухай бүр/шуурхай түгээдэг байх нийтлэг үүргийн биелэлтийн мэдээллийг түгээх шийдлийг боловсруулж дүрэм, журамд тусгах
	Ш.5	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллийг тухай бүр/шуурхай түгээдэг байх нийтлэг үүргээ биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлж журамд тусгах
	Ш.6	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллийг тухай бүр/шуурхай түгээдэг байх шийдлийг Ш.1, Ш.2, Ш.3, Ш.4, Ш.5 шалгууруудад нийцүүлэн боловсруулж үйл ажиллагаандаа ашиглах
МУ.10	Ш.1	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллийг хүртээмжтэйгээр түгээдэг байх ёстой хэв шинжийг дүрэм, журамд тусгах
	Ш.2	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллийг тухай бүр/шуурхай түгээдэг байх нийтлэг үүргийг дүрэм журамд тусгах
	Ш.3	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллийг тухай бүр/шуурхай түгээдэг байх нийтлэг үүргийн хэрэгжилтийг баримт, фактад үндэслэн шалгах шийдлийг боловсруулж дүрэм, журамд тусгах
	Ш.4	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллийг тухай бүр/шуурхай түгээдэг байх нийтлэг үүргийн биелэлтийн мэдээллийг түгээх шийдлийг боловсруулж дүрэм, журамд тусгах
	Ш.5	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллийг тухай бүр/шуурхай түгээдэг байх нийтлэг үүргээ биелүүлээгүй албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлж журамд тусгах
	Ш.6	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллийг хүртээмжтэйгээр түгээдэг байх шийдлийг Ш.1, Ш.2, Ш.3, Ш.4, Ш.5 шалгууруудад нийцүүлэн боловсруулж үйл ажиллагаандаа ашиглах

Үүргийн гүйцэтгэлийн дэд тогтолцоо /ҮГ/



Үүргийн гүйцэтгэлийн дэд тогтолцоо: Эрүүл байгууллагын оролцогч тал бүр харилцан уялдаатай үүргүүд хүлээдэг байх ёстой. Тухайн дэд тогтолцоо нь оролцогч талууд цаг хугацаа, орон зай болон логикийн хувьд зөрчилдөөгүй, харилцан бие биенээ дэмжсэн, хэмжиж болох үүргүүдтэй болгох боломжийг олгодог.

АМГТГ-н “Кадастрын хэлтэс”-ийн үүргийн гүйцэтгэлийн дэд тогтолцоо нь **61.25** хувийн үнэлгээтэйгээр ASA-IV буюу “Эрсдэлийн нөлөөллийг бууруулах чадвартай систем”-н ангилалд хамаарч байна. *Хүснэгт 7*

Тухайн дэд тогтолцооны уялдааны индекс **60.44** хувийн үнэлгээтэйгээр **SU-I** ангилалд хамаарч байна. Өөрөөр хэлбэл, уялдааг бий болгох шаардлагатай байна. *Хүснэгт 6*

Хүснэгт 14: ҮГ-ийн дэд тогтолцооны оношилгооны дүн

№	Байгууллагын хэв шинжүүд	Байвал зохих түвшин	Оношилгооны дүн /оноогоор/	Оношилгооны дүн /хувиар/	Доголдлын түвшин
ҮГ.1	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь албадан гүйцэтгэгддэг үйлдлүүд /үүргүүд/-ээс бүрдсэн байх ёстой	12	6.6	55.00%	Хэв шинжийг бүрдүүлээгүй
ҮГ.2	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргүүдийг нийтлэг хэв шинжүүдээр нь ангилж тодорхойлсон байх ёстой	12	6.5	54.17%	Хэв шинжийг бүрдүүлээгүй
ҮГ.3	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргүүд нь бие биентэйгээ уялдсан байх ёстой.	12	7	58.33%	Хэв шинжийг дутуу бүрдүүлсэн
ҮГ.4	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргүүдийн гүйцэтгэлийг тоон утгаар хэмжиж болдог байх ёстой.	12	7	58.33%	Хэв шинжийг дутуу бүрдүүлсэн
ҮГ.5	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргүүдийг тухайн үүргийг хүлээсэн оролцогч бүр хүлээн зөвшөөрсөн байх ёстой	12	6	50.00%	Хэв шинжийг бүрдүүлээгүй
ҮГ.6	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргүүдийг гүйцэтгэхэд шаардлагатай нөөцийг бүрдүүлэх чадвартай байх ёстой.	12	11	91.67%	Хэв шинжийг бүрэн бүрдүүлсэн
Нийт үнэлгээ		72	44.1	61.25%	ASA - IV

ҮГ.1: Үүргийн гүйцэтгэлийн дэд тогтолцооны нэгдүгээр хэв шинжийг **55.00** хувь бүрдүүлсэн байна. Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь албадан гүйцэтгэгддэг үйлдлүүд /үүргүүд/-ээс бүрдүүлэх хэв шинжийг дүрэм, журамд огт тусгаагүй боловч хөдөлмөрийн дотоод журмыг үүргүүд болон эрхүүдээс аль алинаар нь бүрдүүлсэн байгаа тул ҮГ.1-н 6 шалгуурын **1** шалгуурыг бүрэн бус хангаж, үлдсэн **5** шалгуурыг хангаагүй. */Хавсралт 2/*

ҮГ.2: Үүргийн гүйцэтгэлийн дэд тогтолцооны хоёрдугаар хэв шинжийг **54.17** хувь бүрдүүлсэн. Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргүүдийг нийтлэг хэв шинжүүдээр нь ангилж тодорхойлох хэв шинжийг дүрэм, журамд бүрэн тусгаагүйгээс ҮГ.2-н 6 шалгуурын **1** шалгуурыг бүрэн бус хангаж, үлдсэн **5** шалгуурыг хангаагүй. */Хавсралт 2/*

ҮГ.3: Үүргийн гүйцэтгэлийн дэд тогтолцооны гуравдугаар хэв шинжийг **58.33** хувь бүрдүүлсэн. Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргүүд нь бие биетэйгээ уялдсан байх хэв шинжийг дүрэм, журамд бүрэн тусгаагүйгээс ҮГ.3-н 6 шалгуурын **5** шалгуурыг хангаагүй. /Хавсралт 2/

ҮГ.4: Үүргийн гүйцэтгэлийн дэд тогтолцооны дөрөвдүгээр хэв шинж нь **58.33** хувь бүрдсэн байна. Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргүүдийн гүйцэтгэлийг тоон утгаар хэмжих хэв шинжийг дүрэм, журамд тусган, үйл ажиллагаандаа ашиглаж байгаа боловч тухайн хэв шинжийг хангасан шийдлийг тодорхойлох үүрэг хүлээсэн албан тушаалтан байхгүй байгаа тул ҮГ.4-н 6 шалгуураас **1** шалгуурыг хангаж, **5** шалгуурыг хангахгүй байна. /Хавсралт 2/

ҮГ.5: Үүргийн гүйцэтгэлийн дэд тогтолцооны тавдугаар хэв шинж нь **50.00** хувь бүрдсэн байна. Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргүүдийг тухайн үүргийг хүлээсэн оролцогч бүр хүлээн зөвшөөрсөн байх хэв шинжийн ҮГ.5-н 6 шалгууруудыг **бүх шалгуурыг** хангаагүй. /Хавсралт 2/

ҮГ.6: Үүргийн гүйцэтгэлийн дэд тогтолцооны зургаадугаар хэв шинж нь **91.67** хувийн үнэлгээ авсан тул хэв шинжийг бүрэн бүрдүүлсэн байна. /Хавсралт 2/

Санал, зөвлөмж

Хүснэгт 15: Үүргийн гүйцэтгэлийн дэд тогтолцооны доголдлыг арилгах шийдлүүдийн зөвлөмж

№	Хангаагүй шалгуурын код	Үүргийн гүйцэтгэлийн дэд тогтолцоонуудын доголдлыг арилгах шийдлүүдийн зөвлөмж
ҮГ.1	Ш.1	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь албадан гүйцэтгэгддэг үйлдлүүд /үүргүүд/-ээс бүрдсэн байх ёстой хэв шинжийг дүрэм, журамд тусгах
	Ш.2	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь албадан гүйцэтгэгддэг үйлдлүүд /үүргүүд/-ээс бүрдүүлэх үүрэгтэй этгээдийг тодорхой болгож дүрэм, журамд тусгах
	Ш.3	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь албадан гүйцэтгэгддэг үйлдлүүд /үүргүүд/-ээс бүрдүүлэх үүрэгтэй этгээдийн үүргийн хэрэгжилтийг баримт, фактад үндэслэн шалгах шийдлийг боловсруулж дүрэм, журамд тусгах
	Ш.4	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь албадан гүйцэтгэгддэг үйлдлүүд /үүргүүд/-ээс бүрдүүлэх үүрэгтэй этгээдийн үүргийн хэрэгжилтийн тухай мэдээллийг түгээх үүргийг боловсруулж дүрэм, журамд тусгах
	Ш.5	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь албадан гүйцэтгэгддэг үйлдлүүд /үүргүүд/-ээс бүрдүүлэх үүрэгтэй этгээдийн үүрэг хэрэгжээгүй тохиолдолд хүлээх хариуцлагыг тодорхой болгож дүрэм, журамд тусгах
	Ш.6	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь албадан гүйцэтгэгддэг үйлдлүүд /үүргүүд/-ээс бүрдүүлэх шийдлийг Ш.1, Ш.2, Ш.3, Ш.4, Ш.5 шалгууруудад нийцүүлэн боловсруулж үйл ажиллагаандаа ашиглах
ҮГ.2	Ш.1	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргүүдийг нийтлэг хэв шинжүүдээр нь ангилж тодорхойлсон байх ёстой хэв шинжийг дүрэм, журамд тусгах
	Ш.2	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргүүдийг нийтлэг хэв шинжүүдээр нь ангилж тодорхойлох үүрэгтэй этгээдийг тодорхой болгож дүрэм, журамд тусгах
	Ш.3	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргүүдийг нийтлэг хэв шинжүүдээр нь ангилж тодорхойлох үүрэгтэй этгээдийн үүргийн хэрэгжилтийг баримт, фактад үндэслэн шалгах шийдлийг боловсруулж дүрэм, журамд тусгах
	Ш.4	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргүүдийг нийтлэг хэв шинжүүдээр нь ангилж тодорхойлох үүрэгтэй этгээдийн үүргийн хэрэгжилтийн тухай мэдээллийг түгээх үүргийг боловсруулж дүрэм, журамд тусгах
	Ш.5	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргүүдийг нийтлэг хэв шинжүүдээр нь ангилж тодорхойлох үүрэгтэй этгээдийн үүрэг хэрэгжээгүй тохиолдолд хүлээх хариуцлагыг тодорхой болгож дүрэм, журамд тусгах

	Ш.6	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргүүдийг нийтлэг хэв шинжүүдээр нь ангилж тодорхойлох шийдлийг Ш.1, Ш.2, Ш.3, Ш.4, Ш.5 шалгууруудад нийцүүлэн боловсруулж үйл ажиллагаандаа ашиглах
ҮГ.3	Ш.1	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргүүд нь бие биетэйгээ уялдсан байх ёстой хэв шинжийг дүрэм, журамд тусгах
	Ш.2	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргүүдийг бие биетэй нь уялдуулах үүрэгтэй этгээдийг тодорхой болгож дүрэм, журамд тусгах
	Ш.3	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргүүдийг бие биетэй нь уялдуулах үүрэгтэй этгээдийн үүргийн хэрэгжилтийг баримт, фактад үндэслэн шалгах шийдлийг боловсруулж дүрэм, журамд тусгах
	Ш.4	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргүүдийг бие биетэй нь уялдуулах үүрэгтэй этгээдийн үүргийн хэрэгжилтийн тухай мэдээллийг түгээх үүргийг дүрэм, журамд тусгах
	Ш.5	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргүүдийг бие биетэй нь уялдуулах үүрэгтэй этгээдийн үүрэг хэрэгжээгүй тохиолдолд хүлээх хариуцлагыг тодорхой болгож дүрэм, журамд тусгах
ҮГ.4	Ш.1	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргүүдийн гүйцэтгэлийг тоон утгаар хэмжиж болдог байх ёстой хэв шинжийг дүрэм, журамд тусгах
	Ш.2	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргүүдийн гүйцэтгэлийг тоон утгаар хэмжихдэхүйц томьёоллоор тодорхойлох үүрэгтэй этгээдийг тодорхой болгож дүрэм, журамд тусгах
	Ш.3	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргүүдийн гүйцэтгэлийг тоон утгаар хэмжихдэхүйц томьёоллоор тодорхойлох үүрэг хүлээсэн этгээдийн үүргийн хэрэгжилтийг баримт, фактад үндэслэн шалгах шийдлийг боловсруулж дүрэм, журамд тусгах
	Ш.4	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргүүдийн гүйцэтгэлийг тоон утгаар хэмжихдэхүйц томьёоллоор тодорхойлох үүрэг хүлээсэн этгээдийн үүргийн хэрэгжилтийн тухай мэдээллийг түгээх үүргийг боловсруулж дүрэм, журамд тусгах
	Ш.5	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргүүдийн гүйцэтгэлийг тоон утгаар хэмжихдэхүйц томьёоллоор тодорхойлох үүрэг хүлээсэн этгээдийн үүрэг хэрэгжээгүй тохиолдолд хүлээх хариуцлагыг тодорхой болгож дүрэм, журамд тусгах
ҮГ.5	Ш.1	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргүүдийг тухайн үүргийг хүлээсэн оролцогч талуудад хүлээн зөвшөөрүүлсэн байх ёстой хэв шинжийг дүрэм, журамд тусгах
	Ш.2	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргүүдийг тухайн үүргийг хүлээсэн оролцогч талуудад хүлээн зөвшөөрүүлэх үүрэгтэй этгээдийг тодорхой болгож дүрэм, журамд тусгах
	Ш.3	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргүүдийг тухайн үүргийг хүлээсэн оролцогч талуудад хүлээн зөвшөөрүүлэх этгээдийн үүргийн хэрэгжилтийг баримт, фактад үндэслэн шалгах шийдлийг боловсруулж дүрэм, журамд тусгах
	Ш.4	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргүүдийг тухайн үүргийг хүлээсэн оролцогч талуудад хүлээн зөвшөөрүүлэх этгээдийн үүргийн хэрэгжилтийн тухай мэдээллийг түгээх үүргийг боловсруулж дүрэм, журамд тусгах
	Ш.5	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргүүдийг тухайн үүргийг хүлээсэн оролцогч талуудад хүлээн зөвшөөрүүлэх этгээдийн үүрэг хэрэгжээгүй тохиолдолд хүлээх хариуцлагыг тодорхой болгож дүрэм, журамд тусгах
	Ш.6	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргүүдийг тухайн үүргийг хүлээсэн оролцогч талуудад хүлээн зөвшөөрүүлэх шийдлийг Ш.1, Ш.2, Ш.3, Ш.4, Ш.5 шалгууруудад нийцүүлэн боловсруулж үйл ажиллагаандаа ашиглах
ҮГ.6	Ш.4	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргүүдийг гүйцэтгэхэд шаардлагатай нөөцүүдийг бүрдүүлэх шийдлүүдийг батлах үүрэгтэй этгээдийн үүрэг хэрэгжилтийн мэдээлэл буюу баталсан төсөв, төлөвлөгөөний мэдээллийг ажилтнуудад тогтмол түгээх үүргийг дүрэм, журамд тусгах

Эргэх холбооны дэд тогтолцоо /ЭХ/



Эргэх холбооны дэд тогтолцоо: Эрүүл байгууллага нь системийн доголдуудаа тасралтгүй засаж байх ёстой. Тухайн дэд тогтолцоо нь байгууллагын дархлааг системтэйгээр сайжруулах зорилготой, тоон, ил тод, үзэмжийн бус цалин хөлс, урамшуулал ба хариуцлагын тогтолцоог бий болгох боломжийг олгодог.

АМГТГ-н “Кадастрын хэлтэс”-ийн эргэх холбооны дэд тогтолцоо нь **62.50** хувийн үнэлгээтэйгээр **ASA - IV** буюу “Эрсдэлийн нөлөөллийг бууруулах чадвартай систем”-н ангилалд хамаарч байна. *Хүснэгт 9*

Тухайн дэд тогтолцооны уялдааны индекс **61.75** хувийн үнэлгээтэйгээр **SU-I** буюу системийн уялдааг бий болгох шаардлагатай байна. *Хүснэгт 6*

Хүснэгт 16: ЭХ-ын дэд тогтолцооны оношилгооны дүн

№	Байгууллагын хэв шинжүүд	Байвал зохих түвшин	Оношилгооны дүн /оноогоор/	Оношилгооны дүн /хувиар/	Доголдлын түвшин
ЭХ.1	Нэгдмэл зорилгын хэрэгжилтийн үр дүн нь оролцогч талуудын ашиг сонирхлыг хангахад шууд нөлөө үзүүлдэг байх ёстой	12	7	58.33%	Хэв шинжийг дутуу бүрдүүлсэн
ЭХ.2	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргүүдийн биелэлт нь оролцогч талуудын ашиг сонирхлыг хангахад шууд нөлөө үзүүлдэг байх ёстой.	12	7	58.33%	Хэв шинжийг дутуу бүрдүүлсэн
ЭХ.3	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцогч талуудыг урт хугацаанд тогтвортой хамтран ажиллахыг сэдэлжүүлсэн байх ёстой	12	7	58.33%	Хэв шинжийг дутуу бүрдүүлсэн
ЭХ.4	Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцогч талуудыг урт хугацаанд үр дүнтэй хамтран ажиллахыг сэдэлжүүлсэн байх ёстой	12	7	58.33%	Хэв шинжийг дутуу бүрдүүлсэн
ЭХ.5	Нэгдмэл зорилгын хэрэгжилтэд учирч буй асуудлуудыг үүсгэж байгаа шалтгааныг оролцогч талууд тухай бүр олж тогтоодог байх ёстой	12	6	50.00%	Хэв шинжийг бүрдүүлээгүй
ЭХ.6	Нэгдмэл зорилгын хэрэгжилтэд учирч буй асуудлуудыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад чиглэсэн ажлуудыг төлөвлөдөг байх ёстой.	12	11	91.67%	Хэв шинжийг бүрэн бүрдүүлсэн
Нийт үнэлгээ		72	45	62.50%	ASA - IV

ЭХ.1: Эргэх холбооны дэд тогтолцооны нэгдүгээр хэв шинжийг **58.33** хувь бүрдүүлсэн байна. Нэгдмэл зорилгын хэрэгжилтийн үр дүн нь ажилтнуудын ашиг сонирхлыг хангахад шууд нөлөө үзүүлдэг байх хэв шинж болон шийдлүүдийг дүрэм, журамд бүрэн тусгаагүй боловч байгууллагын үйл ажиллагаанд тус хэв шинжийг агуулсан шийдлийг ашиглаж байгаа тул ЭХ.1-н 6 шалгуурын 1 шалгуурыг хангаж, үлдсэн **5** шалгуурыг хангахгүй байна. /Хавсралт 2/

ЭХ.2: Эргэх холбооны дэд тогтолцооны хоёрдугаар хэв шинжийг **58.33** хувь бүрдүүлсэн байна. Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үүргүүдийн биелэлт нь оролцогч талуудын ашиг сонирхлыг хангахад шууд нөлөө үзүүлдэг байх ёстой хэв шинжийг дүрэм, журамд бүрэн тусгаагүй боловч байгууллагын үйл ажиллагаанд

тус хэв шинжийг агуулсан шийдлийг ашиглаж байгаа тул ЭХ.2-н 6 шалгуурын **1** шалгуурыг хангаж, үлдсэн **5** шалгуурыг хангахгүй байна /Хавсралт 2/

ЭХ.3: Эргэх холбооны дэд тогтолцооны гуравдугаар хэв шинжийг **58.33** хувь бүрдүүлсэн байна. Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцогч талуудыг урт хугацаанд тогтвортой хамтран ажиллахыг сэдэлжүүлсэн байх ёстой хэв шинжийг дүрэм, журамд тусгаагүй боловч байгууллагын үйл ажиллагаанд тус хэв шинжийг агуулсан шийдлийг ашиглаж байгаа тул ЭХ.3-н 6 шалгуурын **5 шалгуурыг** хангахгүй байна. /Хавсралт 2/

 - 2.3. **The Director General of Mines:** Уул уурхай, аж үйлдвэрийн зохицуулалт, аюулгүй байдлын газрын гүйцэтгэх захирал.
3. **Private land owner:** Хайгуулын тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргаж буй газрын эзэмшигч.

Баруун Австралийн Mining Act болон Mining Regulation эрх зүйн баримт бичгийн хүрээнд Хүснэгт 31-т туссан нөхцөлөөр хайгуулын тусгай зөвшөөрөл олгодог.

Хүснэгт 31: Баруун Австралийн хайгуулын тусгай зөвшөөрөл олгох нөхцөл

Үзүүлэлт	Хайгуулын тусгай зөвшөөрөл /mineral claim/
Хугацаа	5 жил
Дахин олгогдох боломж	Хайгуулын ажлын шаардлагатай зардлыг зарцуулж, холбогдох журмыг дагах мөрдсөн бол 5 жил эхний удаа, 2 жил давтан хүсэлт гаргасан тохиолдолд сунгагдах боломжтой
Төлбөр	1–3-р жилд: 1блок нь \$138.00 4, 5-р жилд: 1блок нь \$233.00 6, 7-р жилд: 1блок нь \$318.00 8 ба түүнээс дээш жилүүдэд: 1блок нь \$601.00
Талбайн хэмжээ	70 хүртэл блок /1блок нь дунджаар 3.2км.кв/
Нэгж талбайн зарцуулах зардал	1–3-р жилд: 1блоkd \$1000.00 4, 5-р жилд: 1блоkd \$1500.00 6, 7-р жилд: 1блоkd \$2000.00 8 ба түүнээс дээш жилүүдэд: 1блоkd \$3000.00
Тусгай зөвшөөрлөөр олгох эрх	Газраас 1000 тонн хүртэлх материалыг олборлох.

7.1.2 Баруун Австрали мужийн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог цахимжуулсан арга зам, програмын тухай мэдээлэл

Баруун Австрали нь уул уурхайн салбарын үйл ажиллагаагаа хэрэглэгчдэд шуурхай үйлчилгээ үзүүлэх зорилгоор эрх зүйн баримт бичгүүдийг дижиталжуулж, 14 платформыг хөгжүүлсэн байна.

Зураг 9: Баруун Австрали мужийн уул уурхайн салбарт ашиглагдаж буй дижитал шийдлүүд



Airborne Geophysics Index (MAGIX)
MAGIX is a register of datasets from privately commissioned airborne geophysical surveys and government-commissioned airborne and ground regional geophysical surveys.

[ABOUT](#) [ACCESS](#)



Dangerous Goods Road Transport Decoder App
Download the Dangerous goods road transport decoder app to access guidance information directly from your phone, tablet or computer.

[ABOUT](#) [ACCESS](#)



Data and Software Centre
A facility that allows you to download spatial datasets relating to geology, mining and petroleum titles, geochemistry and other geoscience information.

[ABOUT](#) [ACCESS](#)



Environmental Assessment and Regulatory System (EARS)
EARS Online allows online lodgement and tracking of Mineral and Petroleum Environmental Applications.

[ABOUT](#) [ACCESS](#)



Environmental Assessment and Regulatory System 2 (EARS2)
EARS 2 allows online lodgement and tracking of Mineral Environmental Compliance Reports.

[ABOUT](#) [ACCESS](#)



Company mineral drillhole and surface geochemistry data
This database contains more than 2.4 million historic drillholes, and more than 6 million surface samples.

[ABOUT](#) [ACCESS](#)



eBookshop
Access to almost 5000 geological products including books, maps and data packages. Most are available free of charge as PDF files.

[ABOUT](#) [ACCESS](#)



Explanatory Notes System (ENS)
A digital repository that integrates stratigraphic relationships with links to all tectonic units and events recognized in Western Australia.

[ABOUT](#) [ACCESS](#)



Geochronology
Access to radiogenic isotope geochronology used to determine the absolute timing of geological events.

[ABOUT](#) [ACCESS](#)



Geoscience Thesaurus (GeMPeT)
Provides geoscience professionals with a standardised terminology with which to index information assets such as reports, maps and digital datasets.

[ABOUT](#) [ACCESS](#)

**Geochemistry (GeoChem Extract)**

Access to geochemical data generated from samples collected during Geological Survey of Western Australia (GSWA) mapping and mineralisation programs.

[ABOUT](#) [ACCESS](#)

**Historical Mining Tenement Maps**

Before TENGRAPH, hard copy maps were maintained. Access historical maps showing the location of mining tenements within Western Australia.

[ABOUT](#)

**Library catalogue**

Search the department's Mineral House Library for publications on Western Australian geology, mining, petroleum and environmental subjects.

[ABOUT](#) [ACCESS](#)

**Mineral Titles Online (MTO)**

Title details of mineral exploration and mining tenements throughout Western Australia

[ABOUT](#) [ACCESS](#)

**Mining Notices (including application advertising)**

Displays mining tenement applications that have been lodged and also notification of the lodgement and finalisation of surrenders and withdrawals.

[ABOUT](#) [ACCESS](#)

**Petroleum Geothermal Register (PGR)**

Access to information relating to petroleum and geothermal titles.

[ABOUT](#) [ACCESS](#)

**Interactive geological map (GeoVIEW.WA)**

An interactive, GIS-based mapping system. Construct your own geological map and incorporate other mineral and petroleum exploration datasets including mines and mineral deposits, petroleum wells, active leases, and much more.

[ABOUT](#) [ACCESS](#)

**Mineral exploration reports (WAMEX)**

Exploration reports and data for public download.

[ABOUT](#) [ACCESS](#)

**Mineral Systems Atlas**

An evolving platform where GSWA uses the Mineral Systems Analysis approach to deliver tailored derived data layers relevant to mineral deposits in Western Australia in an interactive GIS-based platform.

[ABOUT](#) [ACCESS](#)

**Mines and mineral deposits (MINEDEX)**

A comprehensive database of mines, mineral deposits and prospects along with their operating status, location, mineral resource estimates, mineral production, and project ownership.

[ABOUT](#) [ACCESS](#)

**Petroleum and Geothermal Information (WAPIMS)**

Petroleum exploration database containing non-confidential data on wells, geophysical survey titles and other related exploration and production data.

[ABOUT](#) [ACCESS](#)

**Royalties Online**


System for Western Australian mineral and petroleum producers to electronically prepare, lodge and view royalty returns and production reports.

2015 оны байдлаар Уул уурхай, аж үйлдвэрийн зохицуулалт, аюулгүй байдлын газраас мэдээллэснээр нийт хайгуулын тусгай зөвшөөрөл олгох хүсэлт, өргөдлүүдийн 78% нь цахим платформуор дамжуулан хүлээн авч, шийдвэрлэгдсэн байна.

Дээр дурдсан уул уурхайн үйл ажиллагааг зохицуулдаг баримт бичгүүдээс хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд **Mining Titles Online, Mining Notices, Tenagraph Web** зэрэг програм хангамжууд ашиглагдаж байна.


1. Mining Titles Online - Mining Act, Mining Regulation-д туссан үүргүүдийг гүйцэтгэхэд ашиглагдаж буй маягтуудыг цахимаар бүртгэх, шийдвэрлэх боломжийг бүрдүүлсэн платформ юм. Энэхүү платформуор дамжуулан Mining Regulation-д туссан нийт 43 маягтын 36-г нь цахимаар илгээх, бүртгүүлэх, шийдвэрлүүлэх боломж бүрдсэн ба мөн бусад нэмэлт журамд туссан үүргүүдийг энэ платформуор дамжуулан гүйцэтгэх боломжтой байна.

Зураг 10: Mining Titles Online системд нэвтэрсний дараах нүүр хуудас




2. Mining Notices - Энэхүү платформ нь ашиг малтмал, уул уурхайн үйл ажиллагааг явуулах хүсэлт хүлээн авсан, олгосон талаар оролцогч талуудад ил тод мэдэгдэх зорилготой цахим платформ юм.

Зураг 11: Mining Notices системээр дамжуулан нийт бүртгэгдсэн тусгай зөвшөөрлийн хүсэлтийг хайх, харах хуудас



3. Tenegraph Web нь Баруун Австралийн уул уурхайн ашиглалт, газрын тосны газрын байршил, газрын бусад мэдээлэлтэй холбоотой байр суурийг харуулсан орон зайн лавлагаа, зураглалын систем юм. Энэ нь уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй газрын одоогийн бодит дүр зургийг гаргаж, ашигт малтмалын хайгуул хийх боломжтой газрыг тогтооход ашигладаг.

Зураг 12: Tenegraph Web системээр дамжуулан байрилын талаар мэдээлэл харах хуудас



Эдгээр гурван програмууд нь бүгд “Mining Act”, “Mining Regulation” эрх зүйн баримт бичгүүдийг суурь оюуны шийдлээ болгож ашиглан, цахимжуулсаны үр дүнд бий болсон байна. Ингэснээр дижитал шийдлүүд болон хууль дүрэм журмуудыг уялдуулан сайжруулж, хүсэлт гаргагч этгээд дижитал платформуур дамжуулан үүргээ гүйцэтгэх боломжийг бүрдүүлж өгсөн байна.

Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох процессийн зураглал:

Баруун Австралийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох процессыг судлан, зураглал оруулсныг Зураг 13-т харуулав.

Зураг 13: Баруун Австрали мужийн хайгуулын тусгай зөвшөөрөл олгох процессийн зураглал




Баруун Австрали мужийн уул уурхай, аж үйлдвэрийн зохицуулалт, аюулгүй байдлын газрын гаргасан зөвлөмжийн дагуу хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа нь үндсэн 8 үе шатнаас бүрддэг. Энэхүү 8 үе шат нь Mining Regulation-д туссан 12 үүргийн заалт, 56 тодотгох заалт, 6 маягтаас бүрдэж байна. Баруун Австралийн хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа нь “first come first serve” буюу түрүүлж хүсэлт гаргасан этгээдэд хүсэлт гаргасан газарт нь хайгуулын зөвшөөрөл олгодог зарчмаар үйлчилдэг. Улмаар хүсэлт гаргасан этгээд дүрэм журмын дагуу хүсэлт гаргасан тохиолдолд хайгуулын зөвшөөрлийг богино хугацаанд авах боломжтой.

Гэхдээ газар эзэмшигч, орон нутгын захиргааны нэгж байгууллага гэх мэт бусад оролцогч талуудын ашиг сонирхолыг харгалзан үзэх зорилгоор дэлгэрэнгүй зохицуулалтын заалтуудыг хууль, дүрэм журамд тусгаж өгсөн байна. Улмаар хайгуулын тусгай зөвшөөрөл авах хүсэлтийг татгалзах санал гуравдагч этгээд эсвэл газар эзэмшигчээс ирсэн тохиолдолд, тухайн асуудлыг шүүхээр шийдвэрлэх зорилготой нийт зохицуулалтын 68 заалт, 10 маягт байна.

Зураг 14: Баруун Австрали мужийн хайгуулын тусгай зөвшөөрөл олгох процессийн зураглал /Монголын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох процессийн ерөнхий үе шатууд дээр тусган харуулсан/

Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны цахимжуулалтын бэлэн байдлын үнэлгээ




Энэхүү Баруун Австралийн хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үе шатуудыг Монголын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны ерөнхий үе шатуудаар харьцуулсныг **Зураг 14**-д харуулав. Баруун Австрали мужийн хайгуулын тусгай зөвшөөрөл олгох процесс нь first come first serve буюу түрүүлж хүсэлт гаргасан этгээдэд хүсэлт гаргасан талбайн хайгуулын тусгай зөвшөөрөл олгох зарчмаар явагддаг тул Монголын хайгуулын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтын журмын үүргүүдийн урсгал зурагт туссан сааралтуулсан 2 үе шатуудыг алгасаж байна.

7.1.3 Баруун Австрали мужийн хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны цахимжуулалтын үнэлгээ

Баруун Австрали мужийн хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны судалгаатай уялдуулан Баруун Австрали мужийн хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны **цахимжуулалтын** бэлэн байдал болон **цахимжуулсан** байдлын үнэлгээг гүйцэтгэсэн. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны цахимжуулалтын бэлэн байдлын үнэлгээний нэгдсэн дүнг **Зураг 15**-д харуулав.


Зураг 15: Баруун Австрали мужийн хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны цахимжуулалтын бэлэн байдлын түвшин



Баруун Австрали мужийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох процессын **цахимжуулалтын** бэлэн байдлын үнэлгээ **91.7** хувьтай гарсан. Энэ нь цахимжуулалтын бэлэн байдлын **нэгдүгээр түвшинд** хамаарч байгаа бөгөөд дижиталжуулах ажлын зохион байгуулах нөхцөл бүрэн бүрдсэн байсан байна.


Баруун Австрали мужийн хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны цахимжуулалтын бэлэн байдлын үнэлгээний шалгуур тус бүрийн задаргааг **Зураг 16**-д дэлгэрэнгүй харуулав.

Зураг 16: Баруун Австрали мужийн ашигт малтмалын зөвшөөрлийн бүртгэлийн журмын цахимжуулалтын бэлэн байдлын үнэлгээний үзүүлэлтийн дүн



Баруун Австрали мужийн хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог голчлон зохицуулдаг “Mining regulation” журамд туссан тусгай зөвшөөрлийн бүртгэлтэй холбоотой 12 үүргийг жишиг болгон сонгон авч шинжилгээ хийхэд үүрэг бүрт гүйцэтгэх үйлдэл болон үйлдэлд өртөх объектыг бүрэн тодорхойлсон байсан боловч үүрэг гүйцэтгэгчийг үүргүүдийн 100 хувьд нь л тодорхойлж, үүргүүдийг гүйцэтгэхэд ашиглах маягт 83.3 хувьд нь тодорхойлж томьёолсон байсан. Иймд тухайн 17 хувийн доголдол нь нийт цахимжуулалтын бэлэн байдлын түвшинд сөрөг нөлөө үзүүлсэн.

Зураг 17: Баруун Австрали мужийн хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны цахимжуулсан байдлын түвшин



Баруун Австралид ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоонд мөдөгддөг хууль, дүрэм, журмуудад туссан тухайн үйл ажиллагаатай шууд хамааралтай үүргүүдийг **цахимжуулсан** байдлын түвшин **100** хувьтай гарсан. Үүнээс дүгнэхэд Баруун Австралийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны цахимжуулалтын бэлэн байдлын түвшин нь **91.6** хувьтай, цахимжуулсан байдлын түвшин **100.00** хувьтай гарсан.

7.2 Канад улсын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоо, цахимжуулсан арга зам

Канад улс бол үндсэн хуульт хаант болон парламентын засаглалтай ардчилсан улс бөгөөд 10 муж, гурван нутаг дэвсгэрээс бүрдсэн холбооны улс юм. Энэхүү ардчилсан бүтцэд хамаарах чиг үүргүүдийг парламентын засаглалын холбооны системээр дамжуулан хэрэгжүүлдэг.

Канад улс нь ашигт малтмалын үйл ажиллагаатай холбоотой дараах гурван төрлийн тусгай зөвшөөрлийн олгодог.

1. Эрлийн тусгай зөвшөөрөл
2. Хайгуулын тусгай зөвшөөрөл
3. Олборлолтын тусгай зөвшөөрөл

Ашигт малтмалын хайгуул хийх эрхийг ашигт малтмалын тусгай зөвшөөрөл /эсвэл зөвшөөрөл/-ыг хүсэлт гаргах тендерээр олж авдаг. Хүсэлт гаргахын өмнө холбогдох төлбөр, баримт бичиг шаардлагатай бөгөөд зарим мужуудад (жишээлбэл, Юкон) бүртгэл хийхээс өмнө эсвэл хайгуулын хөтөлбөр зохион байгуулахаас өмнө уугуул оршин суугчдын холбоонд мэдэгдэж, холбоо тогтоох шаардлагатай байдаг.

Канад улсын 10 мужуудаас судалгаанд оновчтой тохирох мужийг сонгохдоо хайгуулд зарцуулж буй хөрөнгө, ордын үнэлгээний хэмжээ хамгийн өндөр болон хөрөнгө оруулалтын орчны таатай байдлыг судлан **Саскачеван** мужийг сонгосон.

“Fraser Institute”-н 2020 онд хийсэн уул уурхайн салбарын судалгаанд уул уурхай болон хайгуулын үйл ажиллагааны бий болгож буй үр өгөөж, хөрөнгө оруулалтын орчноор нь улс орнууд, тэдгээрийн мужуудыг эрэмблэн жагсаасан. Тус судалгаанд Хөрөнгө оруулалтын сонирхол татахуйц индексээр нэгдүгээр байранд Невада орсон бөгөөд Канад улсын мужуудаас **Саскачеван муж** 3 дугаар байранд орсон юм.

7.2.1 Саскачеван мужийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоо

Канад улсын муж болон газар нутгаас хамаарч First Nation байгууллагаас хайгуулын тусгай зөвшөөрөл авах үйл ажиллагаанд тодорхой эрхтэйгээр оролцдог.

Саскачеван мужийн уул уурхайн салбарын үйл ажиллагааг удирддаг, зөвшөөрөл олгодог байгууллага нь Саскачеван мужийн Эрчим Хүч, Байгалийн Баялгийн Яам юм.

Зураг 18: Саскачеван мужийн ТЗ олгох үйл ажиллагаанд оролцогч талууд



Эрчим хүч, нөөцийн яам нь Саскачеван мужийн байгалийн баялгийн салбарын өсөлт, хариуцлагатай хөгжлийг дэмжих бодлого, хөтөлбөр боловсруулж, зохицуулж, хэрэгжүүлдэг. Тус яам нь газрын тос, байгалийн хийн салбарын зохицуулах анхан шатны байгууллага болж ажилладаг бөгөөд тухайн газар нутагт харьяалагдах бүх байгалийн нөөцийн тогтолцоог өрсөлдөх чадвартай роялти систем, журам, бодлогыг хангаж ажилладаг.

Канадын Саскачеван мужийн газар нутагт тусгай зөвшөөрөл хүсэгч этгээд нь Эрчим хүч, байгалийн баялагийн яамд “**Subsurface mineral tenure regulation**”-н дагуу өргөдөл гаргаж, тендерт оролцон хайгуулын тусгай зөвшөөрлийг олж авдаг. Саскачеван муж нь уул уурхайн ашигт малтмалын үйл ажиллагааг дараах эрх зүйн бичиг баримтаар зохицуулдаг. Үүнд:

1. Subsurface mineral tenure regulation, 2015
2. Mineral resource act, 1985
3. Mines regulation, 2018
4. **Mineral tenure registry regulation, 2012**
5. **Mineral disposition regulation, 1986**

Эдгээр таван эрх зүйн баримт бичгээс ашигт малтмалын үйл ажиллагааг нарийвчлан зохицуулдаг “Mineral tenure registry regulation” болон “Mineral disposition regulation”-г түлхүү судалсан.

Mineral tenure registry regulation нь нийт 12 хэсэг, 94 зүйлээс бүрдсэн. Үүнээс ашигт малтмалын зөвшөөрлийн бүртгэлтэй холбоотой 20 зүйл байна.

Харин Mineral disposition regulation-н хувьд 8 хэсэг, 53 зүйлтэй.

Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг олгож буй арга, нөхцөл болзол:

Канад улсын Саскачеван муж нь ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг олгохдоо **олон нийтийн тендерийн** аргыг ашигладаг. Ашигт малтмалын хайгуулын эрхийг олон нийтэд нээлттэй тендер хэлбэрээр өгөх тохиолдолд сайд холбогдох зөвлөлтэй зөвлөлдсөний дараа тендерийн тухай мэдэгдэл бэлтгэх ёстой. Сайд тендерийн тухай зарласан саналын хувийг хэвлэхээсээ өмнө зөвлөлд танилцуулж, албан ёсны вебсайтад хэвлэн нийтлэх ёстой.

Газрын доорхи ашигт малтмалын ашиглалтын журмын дагуу олон нийтэд санал болгох үйл явц нь газрын тос, байгалийн хийн олголтын процесстэй ижил төстэй явагддаг.

Хүснэгт 32: Канад улсын Саскачеван мужийн ашигт малтмалын зөвшөөрөл олгох нөхцөл

Үзүүлэлт	Хайгуулын тусгай зөвшөөрөл /mineral claim/
Хугацаа	1 жил /хамгийн ихдээ 8 жил/
Дахин олгогдох боломж	Хайгуулын ажлын шаардлагатай зардлыг зарцуулж, холбогдох журмыг дагах мөрдсөн бол жил бүр сунгагдана
Төлбөр	Нэг га-д 0.60 доллар, хамгийн багадаа 300 доллар
Талбайн хэмжээ	6000 га-аас ихгүй
Нэгжид ногдох зардал	Хоёр жилийн хугацаанд 15-аас 25 долларын хооронд хэлбэлздэг бөгөөд хамгийн багадаа 240 - 400 долларын хооронд байна.
Тусгай зөвшөөрлөөр олгох эрх	1. Шинжилгээ, туршилт; 2.Металлургийн, эрдэс судлалын болон бусад шинжлэх ухааны судалгаа хийх 3.Журамд заасан шаардлагыг хангасны тохиолдолд зөвшөөрлөө бусдад шилжүүлэх 4.Сайдад мэдэгдэсний үндсэн дээр бөөнөөр түүвэрлэлт хийх 5.Эрлийн тусгай зөвшөөрлөө хайгуулын тусгай зөвшөөрөлрүү шилжүүлэх


Эх үүсвэр: Global mining guide, 2020, Baker McKenzie

7.2.2 Саскачеван мужийн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог цахимжуулсан арга зам, программын тухай мэдээлэл

Саскачеван мужийн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргах, бүртгүүлэх үйл ажиллагааг “Mineral tenure registry regulation буюу ашигт малтмалын зөвшөөрлийн бүртгэлийн журам” /цаашид АМЗБ журам/ болон “Mineral disposition regulation буюу ашигт малтмалын эрхийн журам” /цаашид АМЭ журам/-аар зохицуулдаг.

Саскачеван мужийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргах, хүлээн авах процессыг судлан, зурагласныг Зураг 19-т үзүүлэв. Тухайн процессыг зураглахдаа дөрвөн үе шатад ангилж, үе шат тус бүрт гүйцэтгэх үйлдлүүдийг тодорхойлсон.

Зураг 19: Саскачеван мужийн хайгуулын тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргах, хүлээн авах процессын зураг



*цахимжуулсан үйлдлүүдийг цэнхэр өнгөөр будаж тэмдэглэв.

Хайгуулын тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргагч этгээд нь Эрчим Хүч, Байгалийн Баялгийн Яамд “Subsurface mineral tenure regulation”-н дагуу өргөдөл гаргахаас өмнө боломжит ашигт малтмалын газрыг тодорхойлохдоо ISC /Ашигт малтмалын өмчлөл/ болон Geoatlas /олгогдсон тусгай зөвшөөрөл, эрх/ашиглана. Эдгээр вебсайтуудаас олж авсан мэдээлэл нь ашигт малтмалын эрхийн хүртээмжийг тодорхойлоход ашиглагддаг. IRIS-д тендерийн өргөдөл гаргахыг хүсч буй хүн бүр IRIS дахь олон нийтийн санал авах хуваарь руу орж цахим дебит кодтой болох ёстой. Бүх саналыг IRIS-ээр олон нийтэд санал болгож буй өдрийн стандарт цагийн хуваарийн дагуу өдрийн 12:00 цаг хүртэл хүлээн авах ёстой.

Тендерийн үнийн санал нь санал болгож буй бодис, зориулалтын төрлөөс хамааран хоёр хэлбэрээр байж болно.

1. Бүх түрээс, хайгуулын тусгай зөвшөөрөл, газрын тос, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл нь урамшууллын санал шаарддаг. Урамшуулал гэдэг нь илгээмжийн өмнөөс санал болгож буй дүн юм.
2. Газрын тос, байгалийн хий, шатдаг занар, ашигт малтмалын тусгай хайгуулын зөвшөөрөл нь ажлын даалгаврын саналыг шаарддаг. Ажлын даалгавар гэдэг нь зөвшөөрлийн хугацааны эхний хоёр жилийн хугацаанд компанийн шаардлага хангасан ажилд гектар тутамд зарцуулах ёстой мөнгөний хэмжээг хэлнэ.


Шалгуур нөхцөл:

Дээрх тодорхойлсон процессын дагуу хайгуулын тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргаж, авахын тулд хүсэлт гаргагч этгээд бүр дараах шалгуурыг хангасан байх шаардлагатай.

4. IRIS бүртгэл болон IRIS-ийн аюулгүй байдлын зохицуулагч өгсөн зохих зөвшөөрөлтэй байх.
5. Тендерийн саналуудыг тусад нь ирүүлэх эсвэл нэг тендер ирүүлэх байдлаар илгээж болно. Тендерийн бүх саналуудад дараах мэдээллүүд багтсан байх ёстой.
 - а. Төлбөр төлөгч
 - б. Холбоо барих мэдээлэл
 - с. Итгэмжлэгдсэн төлөөлөгч
 - д. Тусгай зөвшөөрөл эзэмших этгээдийн мэдээлэл
6. Саскачеваны Эрчим хүч, байгалийн баялгийн яамтай урьдчилж зөвшөөрөгдсөн дебит (PAD) төлбөртэй байх

Саскачеван мужийн хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоонд харилцан уялдаатай хэд хэдэн программыг ашигладаг. Тухайн тогтолцоонд ашиглаж буй программуудын уялдаа холбоог **Зураг 20-д** харуулав.

Зураг 20: Саскачеван мужийн ашигт малтмалын үйл ажиллагаанд ашиглагддаг программуудын уялдааны зураглал



Дээрх зурагт Саскачеван мужийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоонд шууд болон шууд бус ашиглагддаг программуудыг зурагласан байгаа бөгөөд үйл

ажиллагаанд шууд ашиглагддаг программыг цэнхэр өнгөөр, шууд бус ашиглагддаг программыг цагаан өнгөөр будсан.

Саскачеван мужийн хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоонд Petrinex, Saskatchewan.ca, MARS болон IRIS системүүд шууд хамааралтайгаар оролцдог. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл авах үе шатанд хүсэлт гаргагч иргэн эсвэл аж ахуй нэгж “BA ID буюу бизнесийн түншийн тодорхойлолтын код”-г Petrinex системээс авдаг. Тухайн кодыг авсны дараа хүсэлт гаргагч нь MARS систем болон IRIS системд бүртгүүлж, мэдээллээ байршуулснаар олон нийтийн тендерийн үйл ажиллагаанд оролцох боломжтой болно. Харин GeoAtlas системийн хувьд ашигт малтмалын тандалт судалгаа хийх, эрэл хайгуул хийхэд шаардлагатай мэдээлэл цуглуулахад түлхүү ашиглагддаг систем юм.

MARS, IRIS, GeoAtlas системүүд нь SaskGrid, Mineral cadastral систем, SMAD систем, Geohub систем болон SMDI системүүдтэй харилцан уялдаа хамааралтай ажилладаг.

“Mineral tenure registry regulation” журмын дагуу бүртгэлийг хайх, ашигт малтмалын нөөцийг олж авах, шилжүүлэх, аливаа хэрэгслийг бүртгэх, өргөдөл, мэдүүлэг гаргах хүсэлтээ иргэн эсвэл хуулийн этгээд бүртгүүлсэн байх ёстой. Системд бүртгүүлэх иргэн эсвэл хуулийн этгээд нь дараах мэдээллийг мэдэгдэж, бүртгэлийн хураамж төлөх ёстой. Үүнд:

1. Нэр
2. Утасны дугаар
3. Хаяг байршил
4. Цахим шуудангийн хаяг
5. Хэрвээ хуулийн этгээд бол байгууллагын регистрээ бүртгүүлнэ.

Өргөдөл гаргасан этгээд хураамж төлөхдөө албан ёсны маягтаар өргөдөл гаргаснаас хойш **15 минутын** дотор төлөх ёстой. АМЗБ журмын 33.2 дэд хэсэгт заасны дагуу бүртгэлд өргөдөл гаргасан этгээд гүйцэтгэлийн бэлэн мөнгөний барьцааг батлагдсан хэлбэр, журмаар төлөх ёстой бөгөөд уг төлбөрийг өргөдөл гаргасан өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор сайд хүлээн авах ёстой. Хэрэв нэг ашигт малтмалын талбайд нэгээс илүү хүн өргөдөл гаргасан бол өргөдлийг цахимаар бүртгүүлсэн огноо, цаг хугацаагаар **хамгийн эхэнд бүртгүүлсэн** хүнд давуу эрх олгогддог /АМЗБ журмын 16/.

Саскачеван мужийн “Ашигт малтмалын зөвшөөрлийн бүртгэлийн журам”-н дагуу дараах үндсэн 2 системийг хөгжүүлдэг.

1. SaskGrid систем буюу Саскачеван мужийн **Мэдээллийн үйлчилгээний корпораци /ISC/-н** үүсгэн байгуулж, ажиллуулж буй газарзүйн мэдээллийн лавлах систем;
2. Газрын кадастрын зураглалын систем

Саскачеван мужид үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуй нэгжүүд Саскачеваны засгийн газарт тайлагнах зохицуулалт, хууль тогтоох, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөртэй холбоотой тайлагнах талаарх мэдээллийг <http://www.saskatchewan.ca/> вебсайт дээрээс олж авах боломжтой байдаг.

1. Мэдээллийн үйлчилгээний корпораци /ISC/¹



Канад улсад төвтэй ISC нь олон нийтийн мэдээлэл, бүртгэлийн бүртгэл, мэдээллийн менежментийн үйлчилгээгээр тэргүүлэгч байгууллага юм. ISC нь үндсэн бизнесээ тогтвортой хөгжүүлэхэд чиглэсэн, өсөлтийн шинэ боломжийг эрэлхийлж буй байгууллага бөгөөд ISC нэрийн дор А ангиллын хувьцаа Торонтогийн хөрөнгийн бирж дээр арилжаалагддаг. ISC нь хувийн хэвшил, олон нийтийн байгууллага болон Засгийн Газрын үйл ажиллагааг цахимжуулсан маш их туршлагатай байгууллага юм. Тухайн байгууллага нь үйлчлүүлэгчдийнхээ хэрэгцээ, саад бэрхшээлийг шийдвэрлэхэд чиглэсэн мэдээллээ хамгаалах, удирдах цогц үйлчилгээ, технологийн шийдлүүдийг боловсруулан хүргэдэг ба дижитал шийдлүүдээ

¹ Эх үүсвэр: <https://company.isc.ca/who-we-are/default.aspx>

боловсруулахдаа хэрэглэгч байгууллагын оюуны шийдлүүдийг оновчлох арга замаар үйлчилгээгээ үзүүлдгээрээ илүү давуу талтай.

Үнэ цэнэ бүтээх арга замууд:


- Байгууллагын мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хадгалах бодлого, журам боловсруулах.
- Бүртгэлийн мэдээллийн технологи, мэдээллийн менежмент, нэвтрэлт танилтын үйл явцыг удирдах.
- Үйлчлүүлэгчид бүртгэлийн мэдээлэлтэй хэрхэн харьцдаг болохыг хялбарчилж, хурдасгах.
- Сонгосон салбаруудад тохируулсан бүртгэлийн систем, процессыг боловсруулах.

Гүйцэтгэсэн ажлууд:

- Saskatchewan Personal Property Registry
- Saskatchewan Land Titles Registry: цаасан суурьт үйл ажиллагааг цахимжуулсан
- Geo Sask: Launched online portal
- Saskatchewan Corporate Registry
- Enhanced Mineral Cadastral: засгийн газар ашигт малтмалын түрээсийг үйлдвэрлэлийн гэрээрүү шилжүүлэх үйл ажиллагааны суурийг бүрдүүлсэн.
- Business Registrations Saskatchewan
- Yukon Land Title Registry: Цаасан дээр суурилсан газар өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагааг газар эзэмших эрхийн бүртгэлийн цахим системд шилжүүлсэн.
- Nova Scotia Registry of Joint Stock Companies, Canada

2. Petrinex

Зураг 21: Petrinex вебсайтын нүүр хуудас



Эх үүсвэр: <https://www.petrinex.ca/Pages/default.aspx>

Petrinex бол Канадын дээд, дунд, доод газрын тосны үйлдвэрийг дэмжих стратегийн хамтарсан байгууллага бөгөөд одоогоор Засгийн газар (Альберта Эрчим хүчний яам (ТМБ), Альберта Эрчим хүчний зохицуулагч (AER), Саскачеван улсын Эрчим хүч, нөөцийн яам (ER), Британийн Колумбын Сангийн яам (FIN) ба Эрчим хүч, Уурхай ба бага нүүрстөрөгчийн инноваци (EMLI), Британийн Колумбын газрын тос, байгалийн хийн комисс (Комисс), Манитоба Хөдөө аж ахуй, нөөцийн хөгжлийн яам (ARD), Аж үйлдвэр (төлөөлж буй Канадын газрын тос үйлдвэрлэгчдийн холбоо (CAPP) ба Канадын хайгуулчид, үйлдвэрлэгчдийн холбоо (EPAC)) нар хамтран, үйл ажиллагаагаа тус системээр дамжуулан явуулж байна.


Petrinex нь Хатан хааны засаглал, Яамны удирдлага болон санхүүжилтийн бүтцийн дор үйл ажиллагаагаа явуулдаг. Тус систем нь олон улсын харьяаллын дагуу олон оролцогч талуудад үйлчилдэг бөгөөд газрын тосны салбарын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай "бүртгэлийн өгөгдөл" мэдээллийн үр ашигтай, стандартчилагдсан, аюулгүй, үнэн зөв менежмент, солилцоог явуулдаг.

Petrinex системээс бий болох үр дүн:

1. Алберта, Саскачеван, Британийн Колумб, Манитоба мужуудад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг үнэлэх, хураах, цуглуулахад шаардагдах чухал бизнесийн үйл явц, мэдээлэл.
2. Альберта, Саскачеван, Бритиш Колумб, Манитоба мужуудын зохицуулалтын эрх мэдэл, хууль тогтоомжийг дэмжихэд зайлшгүй шаардлагатай мэдээлэл.
3. Бизнесийн түншийн тайлагнах, газрын тосны маркетинг, санхүүгийн анализ, нийцлийн баталгаа, үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэл зэрэг салбарын чухал арилжааны үйл ажиллагааг хөнгөвчлөх гол үйлчилгээнүүд.

3. Saskatchewan.ca

Зураг 22: Саскачеван мужийн засгийн газрын вебсайтын нүүр хуудас




Эх үүсвэр: <https://www.saskatchewan.ca/>

Saskatchewan.ca нь Саскачеван мужийн Засгийн Газрын албан ёсны мэдээлэл түгээх вебсайт юм. Тус вебсайтаар дамжуулан төрийн бүх үйлчилгээтэй холбоотой мэдээллийг хүргэдэг бөгөөд үндсэн 4 цэсээс бүрддэг.

4. MARS

Зураг 23: MARS программын нүүр хуудас



Эх үүсвэр: <https://mars.isc.ca/MARSWeb/default.aspx>

Ашигт малтмалын захиргааны бүртгэл /MARS/-н систем нь ашигт малтмалын зөвшөөрлийн бүртгэлийн журмын дагуу Саскачеван дахь ашигт малтмалын эрхийг олгох цахим бүртгэл юм. Тус систем нь 2012 оны 12-р сард ашиглалтад орсон бөгөөд уул уурхайн салбарт ашигт малтмалын зөвшөөрлийг онлайнаар олж авах, удирдах боломжийг олгодог. MARS системийг ашиглан ашигт малтмалын эрх олгох үйл ажиллагаа нь хоёр төрлийн цахим систем дээр суурилдаг.

5. IRIS

Зураг 24: IRIS программын нүүр хуудас

Published	Title	Description
Monday, May 3, 2021, 10:00 PM	Alert	IRIS Release 8.0.1 was successfully implemented May 1, 2021. To see what was implemented see EOR Grouping Release Notes 8.0.1
Saturday, Apr 24, 2021, 02:00 AM	Alert	The 2021 Orphan Fund Levy invoices will be issued/available on May 3, 2021, through IRIS. Please refer to the Orphan Fund Levy webpage for further information.
Friday, Apr 23, 2021, 02:00 AM	Alert	IRIS will be unavailable from 9PM Saturday, April 24, 2021 to 6AM Sunday, April 25, 2021 CST for system improvements and maintenance
Monday, Apr 12, 2021, 10:00 PM	Alert	IRIS Release 8.0 was successfully implemented April 10, 2021. To see what was implemented see MOSR3 Release Notes 8.0
Tuesday, Apr 6, 2021, 10:00 PM	Alert	Information Circulars PR-IC11 and PR-IC11A, related to the Royalty/Tax Regime Applicable to Enhanced Oil Recovery Projects, have been updated. For further information, please refer to the Crown Royalty and Freehold


Эх үүсвэр: <https://iris.gov.sk.ca/Portal/Security/Credentials/Login.aspx?ReturnUrl=%2fPortal>

Саскачеваны тендер зарлах үйл ажиллагааг нөөцийн мэдээллийн нэгдсэн систем /IRIS/-ээр дамжуулан онлайнаар зохион байгуулдаг. Харин Geohub буюу Саскачеван уул уурхай ба газрын тосны геоАтлас аппликейшн нь олон нийтийн гео шинжлэх ухаан, ашигт малтмал, газрын тосны холбогдолтой мэдээллийн порталаар хангах зорилготой юм.

Олон нийтийн санал асуулгад оролцож буй ВА буюу бизнесийн түнш бүрт нэг удаагийн хэрэглээний EDC хуваарилахын тулд IRIS системийн аюулгүй байдлыг маш сайн хөгжүүлсэн.

6. GeoAtlas

Зураг 25: GeoAtlas программын нүүр хуудас




Эх үүсвэр: <https://gisappl.saskatchewan.ca/Html5Ext/index.html?viewer=GeoAtlas>

Саскачеван уул уурхай ба газрын тосны геоАтлас аппликейшн нь олон нийтийн гео шинжлэх ухаан, ашигт малтмал, газрын тосны холбогдолтой мэдээллийн порталаар хангах зорилготой юм. Тус системд байгаа мэдээллүүдэд Засгийн Газар баталгаа өгдөггүй бөгөөд хариуцлага хүлээдэггүй тул хэрэглэгч мэдээллээ ашиглахаасаа өмнө мэдээллүүдээ шалгах хэрэгтэй.

7.2.3 Канадын Саскачеван мужийн ашигт малтмалын зөвшөөрлийн бүртгэлийн журмын цахимжуулалтын үнэлгээ

Саскачеван мужийн хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны судалгаатай уялдуулан Саскачеван мужийн хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны **цахимжуулалтын** бэлэн байдал болон **цахимжуулсан** байдлын үнэлгээг гүйцэтгэсэн. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны **цахимжуулалтын** бэлэн байдлын үнэлгээний нэгдсэн дүнг **Зураг 26**-д харуулав.


Зураг 26: Саскачеван мужийн ашигт малтмалын зөвшөөрлийн бүртгэлийн журмын цахимжуулалтын бэлэн байдлын түвшин



Канад улсын Саскачеван мужийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох процессын **цахимжуулалтын** бэлэн байдлын үнэлгээ **98.5** хувьтай гарсан. Энэ нь цахимжуулалтын бэлэн байдлын **нэгдүгээр түвшинд** хамаарч байгаа бөгөөд дижиталжуулах ажлын зохион байгуулах нөхцөл бүрэн бүрдсэн байсан байна.


Саскачеван мужийн хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны цахимжуулалтын бэлэн байдлын үнэлгээний шалгуур тус бүрийн задаргааг Зураг 27-д дэлгэрэнгүй харуулав.

Зураг 27: Саскачеван мужийн ашигт малтмалын зөвшөөрлийн бүртгэлийн журмын цахимжуулалтын бэлэн байдлын үнэлгээний үзүүлэлтийн дүн



Саскачеван мужийн хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог голчлон зохицуулдаг “Mineral tenure registry regulation” журамд туссан бүртгэлтэй холбоотой 11 үүргийг жишиг болгон сонгон авч шинжилгээ хийхэд үүрэг бүрийн гүйцэтгэх үйлдэл болон үйлдэлд өртөх объектыг бүрэн тодорхойлсон байсан боловч үүрэг гүйцэтгэгчийг үүргүүдийн 90 хувьд нь л тодорхойлж томъёолсон байсан. Иймд тухайн 10 хувийн доголдол нь нийт цахимжуулалтын бэлэн байдлын түвшинд сөрөг нөлөө үзүүлсэн. Тодорхойлсон үүргүүдийг гүйцэтгэх маягттай байх шалгуурын хувьд 100 хувь бүрдүүлсэн байна гэж дүгнэсэн. Үүний үндэслэл нь тухайн журам үүргүүдийг гүйцэтгэхэд шаардлагатай маягтуудыг бүрэн хавсаргаагүй байсан ч гэсэн албан ёсны вебсайт болох saskatchewan.ca сайтдаа шаардлагатай маягтуудыг хэрэглэгч бүрэн татан авч, ашиглах боломжтой байсан.

Зураг 28: Саскачеван мужийн ашиг малтмалын зөвшөөрлийн бүртгэлийн журмын цахимжуулсан байдлын түвшин



Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог цахимжуулсан байдлын түвшин **100** хувьтай гарсан. Өөрөөр хэлбэл, Саскачеван мужийн хайгуулын тусгай зөвшөөрөл олгох процессын дижиталжуулах боломжтой үүргүүдийг бүрэн цахимжуулсан байна. Саскачеван мужийн Эрчим Хүч, Байгалийн Баялгийн Яам нь тусгай зөвшөөрөл олгох тогтолцоогоо MARS, IRIS, Petrinex болон Saskatchewan.ca зэрэг сайтуудыг уялдаа холбоотойгоор ашиглан бүрэн цахимжуулсан байна. Цахимжуулалтын бэлэн байдлын түвшин өндөр байгаа учраас цахимжуулсан байдлын түвшин өндөр гарсан.

Fraser институтийн 2020 оны судалгаагаар Саскачеван муж уул уурхайн хөрөнгө оруулалтын таатай орчноор **гуравдугаар** байранд ороход нь дижиталжуулахад бэлэн байдал болон цахимжуулсан түвшин хүчтэй нөлөө үзүүлсэн байх магадлалтай.

Судалгаанаас дүгнэхэд Канад улсын Саскачеван мужийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны цахимжуулалтын бэлэн байдлын түвшин нь **98.5** хувьтай, цахимжуулсан байдлын түвшин **100.00** хувьтай гарсан.

7.3 Орос Холбооны Улсын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоо, цахимжуулсан арга зам

Оросын Холбооны Улс /ОХУ/ нь Холбооны хагас ерөнхийлөгчийн засаглалтай бүгд найрамдах улс бөгөөд ОХУ-ын Үндсэн хууль болон ‘ОХУ-ын Засгийн газрын тухай’ холбооны үндсэн хуулийн хуультай. ОХУ-нь ашигт малтмалын үйл ажиллагаатай холбоотой дараах гурван төрлийн тусгай зөвшөөрлийн олгодог. Үүнд:


1. Геологийн судалгаа хийх тусгай зөвшөөрөл - 5 жилээр олгодог
2. Ашигт малтмалын олборлолт - 20 жилээр олгодог
3. Геологийн судалгаа болон олборлолтын тусгай зөвшөөрлийг - 25 жилээр

Лицензийн хугацааг бүртгэгдсэн өдрөөс эхлэн тооцдог бөгөөд зарим төрлийн газар доорх байгууламж барих, ашиглах, тусгай хамгаалалттай барилга байгууламж барих тусгай зөвшөөрлийг хүчинтэй байх хугацааг нь хязгаарлалгүйгээр олгодог байна. Ашигт малтмалын ордыг ашиглах, төслийн хугацаа 20 жилээс дээш бол тусгай зөвшөөрөл эзэмшигчийн санаачилгаар түүний хүчинтэй байх хугацааг сунгаж болно.

ОХУ-н газрын хэвлий хайгуул хийх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа болон цахимжуулсан арга замыг судлахын тулд, тусгай зөвшөөрлийг олгож буй байгууллага, уг үйл ажиллагаанд оролцогч талууд болон зохицуулж буй гол эрх зүйн баримт бичгийн судалгааг хийсэн болно.

7.3.1 ОХУ-н ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоо

Зураг 29: ОХУ-н ТЗ олгох үйл ажиллагаанд оролцогч талууд



Байгалийн нөөц, байгаль орчны яам нь /Министерство природных ресурсов и экологии Российской Федерации/ уул уурхайн үйл ажиллагаанд хамаарах тусгай зөвшөөрлийн дэглэмийг удирдаж, уул уурхайн салбарыг зохицуулдаг агентлагууд болон бусад байгууллагуудын ажилд хяналт тавьдаг. Харин хайгуулын тусгай зөвшөөрлийг “Роснедра” буюу Холбооны газрын хэвлий ашиглах агентлаг олгодог.

Холбооны газрын хэвлий ашиглах агентлаг /Роснедра/ цаашид “ХГХАА”-нь газрын хэвлий ашиглалтын чиглэлээр төрийн үйлчилгээ үзүүлэх, төрийн өмчийн гүйцэтгэх байгууллага юм. Уг байгууллага нь орон нутгийн харьяа байгууллагуудаараа дамжуулан газрын хэвлийн хайгуул хийх эрхийн сонгон шалгаруулалт, дуудлага худалдааг тогтоосон журмын дагуу зохион байгуулдаг байна. Түүнчлэн ОХУ-ын хууль тогтоомжоор тогтоосон журмаар газрын хэвлийн талбай хайгуул хийх, эрхийн тухай тендер, дуудлага худалдааны дүнг батлах тухай эрх зүйн баримт бичиг боловсруулах, газрын хэвлий хайгуул хийх эрх олгох, түүнчлэн тусгай зөвшөөрлийг сунгах ажлыг гүйцэтгэдэг байна.

Роснедра-ийн зохион байгуулдаг газрын хэвлийн хайгуул хийх эрхийн сонгон шалгаруулалт болон дуудлага худалдаанд:

1. Байгаль орчин, технологи, цөмийн хяналт шалгалтын холбооны алба (Ростехнадзор России) нь технологийн аюулгүй байдлын чиглэлээр хяналт хийх чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.
2. Харин байгалийн менежментийн холбооны алба (Росприроднадзор)-нь газрын хэвлийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн “Газрын хэвлийн тусгай зөвшөөрлийн нөхцөлийг” дагаж мөрдөхөд хяналт тавьж, байгаль орчныг хамгаалах, газрын хэвлийг зохистой ашиглахад хяналт тавьж, Газрын хэвлийд тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд тогтмол хяналт шалгалт хийдэг байна.

Дээр дурьдсан оролцогч талуудын газрын хэвлийн хайгуул хийх эрхийг олгох үйл ажиллагаанд гүйцэтгэх үүргийг ОХУ-н ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох процессын зураглалын дүгнэлтээс харж болно. Ямарваа нэгэн үйл ажиллагаа тогтоосон дүрэм журмын дагуу явагддаг тул, уг үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм журмыг судласан.

Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг олгох үйл ажиллагааг зохицуулж буй гол эрх зүйн баримт бичиг /хууль, журам/

Ашигт малтмал хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохицуулж буй гол эрх зүйн баримт бичиг нь ОХУ-н “**Газрын хэвлийн тухай хууль**” байдаг байна. Газрын хэвлий тухай бусад эрх зүйн баримт бичиг нь бүгд уг хуулийн хүрээнд боловсруулагдсан байна. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгодог байгууллага нь дээр дурдсанчлан Роснедра байх буюу өөрийн орон нутгийн харьяа байгууллагаараа дамжуулан 2.5-д заасан захиргааны журмын дагуу тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулж, удирддаг байна.

Роснедрагийн харьяа орон нутгийн байгууллагууд нь Роснедра-аас гаргасан журам, дүрмийг өөрийн орон нутгийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаандаа дагаж мөрддөг. Жишээ нь: 2.3-т заасан Роснедра-ийн харьяа байгууллага “Приволжскнедра”-нь Башкортостаны/Приволжскнедра-д газар зүйн хувьд харьяалагдах орон нутаг/ 2020 оны 11 сард зарласан лицензийн дуудлага худалдааны журмийг уг Башкортостаны дуудлага худалдаанд ашигласан байна.

Энэхүү судалгааг Роснедрагийн захиргааны журмыг үндэслэн хийсэн болно. Дээр дурдсан дүрэм, журмаас гадна дараах эрх зүйн баримт бичиг ОХУ-н газрын хэвлийн хайгуул хийх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд мөрдөгддөг байна:

- Газрын хэвлийн тухай хууль
- Тусгай үйл ажиллагааг лицензжуулах тухай хууль /о лицензировании отдельных видов деятельности/
- Тухайн газар орон нутгийн лиценз олголтийн тухай журам. Жишээ нь: Башкортостаны 2020 оны 11 сард зарласан лицензийн дуудлага худалдааны журам.

- Положение о порядке лицензирования пользования недрами, утвержденное Постановлением Верховного Совета Российской Федерации от 15.07.1992 № 3314-1;
- Административный регламент предоставления Федеральным агентством по недропользованию государственной услуги по организации проведения в установленном порядке конкурсов и аукционов на право пользования недрами (Приказ от от 19.03.2020 № 110)

7.3.2 ОХУ-н ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог цахимжуулсан арга зам, программын тухай мэдээлэл

ОХУ-нь ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг дараах 2 аргаар олгодог байна. Үүнд:


1. Сонгон шалгаруулалт
2. Дуудлага худалдаа

Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох захиргааны үйл ажиллагаа албан ёсны вебсайт дээр газрын хэвлий ашиглах болон хайгуул хийх эрхийн тендер, дуудлага худалдаа байршуулсан өдрөөс хойш дуудлага худалдаа 70-аас дээшгүй хоногийн дотор, сонгон шалгаруулалтын хугацаа нь 115 хоногоос илүүгүй хугацаанд гүйцэтгэгддэг байна. (давагдашгүй нөхцөл байдал үүсэхгүй бол). /Роснедрагийн захиргааны дүрмийн 12-р зүйл. ОХУ-д тусгай зөвшөөрлийг олгох үйл ажиллагааг хэрхэн цахимжуулсан талаарх дүгнэлтийг гаргахын тулд, тус үйл ажиллагааны процессыг судлах хэрэгцээ, шаардлага гарсан тул тусгай эрх олгогч байгууллага буюу Роснедра нь уг үйл ажиллагааг зохицуулж буй гол эрх зүйн баримт бичиг буюу “Роснедрагийн газрын хэвлий ашиглах, хайгуул хийх эрхийн дуудлага худалдаа, сонгон шалгаруулалт зохион байгуулах захиргааны дотоод журам”-д үндэслэн дараах ОХУ-н ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох процессын зургийг боловсруулав.

Зураг 30: ОХУ-н ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох процесс

Роснедрин захиргааны дүрэмд заасан газрын хэвлий ашиглах эрхий дуудлага худалдаа, сонгон шалгаруулалт зохион байгуулах ажлын үе шат

Үе шатны оролцогч тал



Иргэн, хуулийн этгээд нь ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн дуудлага худалдаа сонгон шалгаруулалтад оролцохын тулд өргөдөл гаргагч нь сонгон шалгаруулалт, дуудлага худалдаа зохион байгуулах журамд заасан хугацаанд Роснедра эсвэл түүний нутаг дэвсгэрийн байгууллагуудад өргөдөл ирүүлэх бөгөөд үүнд Газрын хэвлийг ашиглах холбооны агентлагийн “Газрын хэвлийг ашиглах эрхийн сонгон шалгаруулалт, дуудлага худалдаа зохион байгуулах төрийн үйлчилгээ үзүүлэх захиргааны журмын 14-т заасан мэдээллийг өргөдөлд тусган, захиргааны журмын 15-т заасан баримт бичгийг тамгалсан дугтуйнд хийж, өргөдөлд хавсаргана.

Уг захиргааны журам нь 2 хавсралттай бөгөөд дуудлага худалдаа сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй этгээдийн бөглөх өргөдлийг хавсралт 1-т, хавсралт 2-т нь ОХУ-н ашигт малтмалын нөөцийн талаарх хүснэгтийг тус тус хавсаргасан. Гэвч журамд туссан үүрэг хүлээсэн албан тушаалтны үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай маягт боловсруулж, хавсаргаагүй байна.

“Роснедрагийн газрын хэвлийн хайгуул хийх эрхийн дуудлага худалдаа, сонгон шалгаруулалт зохион байгуулах захиргааны дотоод журам”-д үндэслэн боловсруулсан дээрх зураглалд “Албан ёсны вебсайтад газрын хэвлийн хайгуул хийх эрхийн сонгон шалгаруулалт, дуудлага худалдааны зарыг байрлуулах” болон “Газрын хэвлийг ашиглах эрхийн тендер, дуудлага худалдааны үр дүнг батлах”- үе шатуудад ОХУ-н албан ёсны мэдээллийн вебсайт “www.torgi.gov.ru” болон Роснедрагийн албан ёсны вебсайт болох “www.rosnedra.gov.ru” -г олон нийтэд мэдээлэл түгээх зорилгоор ашигладаг байна.

Роснедрагийн албан ёсны вебсайт болон түүний харьяа орон нутгийн байгууллагын вебсайт болох “www.rosnedra.gov.ru” -г авч үзвэл Роснедрагийн захиргааны журмын 56, 114-р заалтад заасны дагуу уг сайдад газрын хэвлий ашиглах, хайгуул хийх эрхийн сонгон шалгаруулалтын зар, мөн түүний үр дүнгийн талаар мэдээлэл оруулдаг.

ОХУ-н албан ёсны мэдээллийн вебсайт болох “www.torgi.gov.ru/index.html” сайтад зөвхөн дуудлага худалдааны талаарх мэдээллийг олон нийтэд түгээдэг. /Сайтын журам дахь заалт: Дуудлага худалдааны албан ёсны вебсайт дээр байрлуулсан мэдээлэлд дараах зүйлс орно: ОХУ-ын 1992 оны 2-р сарын 21-ний өдрийн N 2395-1 “Газрын хэвлийн тухай” хуулийн 13.1-д заасан газрын хэвлийн талбай ашиглах эрхийн тендер, дуудлага худалдаа зохион байгуулах тухай мэдээлэл/

Зураг 31: ОХУ-н вебсайтын нүүр хуудас

Официальный сайт Российской Федерации для размещения информации о проведении торгов

Новости | Торги | Законодательство | Антимонопольный контроль | Вопрос-ответ | Форум | Подписка | Открытые данные

Главная | Все

Виды торгов

Пользование участками недр

Информация о передаче прав пользования участками недр размещается в соответствии с требованиями статьи 13.1 Закона Российской Федерации от 21.02.1992 № 2395-1 "О недрах"

Поиск лотов, торги по которым не завершены либо завершены менее 6-ти (с жалобой менее года) месяцев назад

Организатор торгов: ИНН:

Номер извещения:

Страна размещения:

Местоположение:

Целевое назначение работ:

Полезное ископаемое:

Скачать в Excel | Печать | Очистить | Расширенный поиск | Поиск

* Лоты, торги по которым завершены более 6-ти месяцев (с жалобой более года) назад, доступны в разделе Архив торгов


Все: найдено лотов 1288

Организатор торгов	Номер извещения Номер лота	Полезное ископаемое	Наименование участка	Местоположение	Целевое назначение работ
МИНИСТЕРСТВО ПРИРОДНЫХ РЕСУРСОВ И ЭКОЛОГИИ РЕСПУБЛИКИ СЕВЕРНАЯ ОСЕТИЯ-АЛАНИЯ	1305211575688/01 Лот 1	Песчано-гравийная смесь	Луковской-3	Северная Осетия - Алаания Респ., Моздокский р-н, Луковская ст-ца	Геологическое изучение, разведка добыча
ДЕПАРТАМЕНТ ПО НЕДРОПОЛЬЗОВАНИЮ	1105210880740/05	углеводородное	Т.Б.М.З	Магистраль	геологическое изучение,

Эх үүсвэр: <https://torgi.gov.ru/index.html>

Дээрх зурагт дуудлага худалдаа сонгон шалгаруулалт явцын мэдээлэл /өргөдөл хүлээн авах үе шат, үр дүн гаргах үе шат/ эсэхийн мэдээлэл болон уг, бүх зарлагдсан байгаа дуудлага худалдаа, сонгон шалгаруулалтын мэдээллийг уг сайтад нийтэлдэг байна.

Зураг 32: ОХУ-н сонгон шалгаруулалтын вебсайтын нүүр хуудас




Эх үүсвэр: <https://www.rosnedra.gov.ru/>

Зураг 32-д харуулснаар, дуудлага худалдаа, сонгон шалгаруулалтын талаарх мэдээллийг болон түүний үр дүнгийн талаарх мэдээллийг “www.rosnedra.gov.ru” -д байршуулдаг байна.

7.3.3 ОХУ-н ашигт малтмалын зөвшөөрлийн бүртгэлийн журмын цахимжуулалтын үнэлгээ

ОХУ-н хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны цахимжуулалтын бэлэн байдлын үнэлгээний шалгуур тус бүрийн задаргааг Зураг 33-т дэлгэрэнгүй харуулав.


Зураг 33: ОХУ-н ашигт малтмалын зөвшөөрлийг олгох журмын цахимжуулалтын бэлэн байдлын түвшин



ОХУ-н ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох процессын цахимжуулалтын бэлэн байдлын үнэлгээ **61.3** хувьтай гарсан. Энэ нь цахимжуулалтын бэлэн байдлын **хоёрдугаар** түвшинд хамаарч байгаа бөгөөд шаардлагатай хэв шинжийг **бүрдүүлэх** замаар дижиталжуулах ажлыг зохион байгуулах боломжтой.

ОХУ-н хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны цахимжуулалтын бэлэн байдлын үнэлгээний задаргааг **Зураг 34**-д дэлгэрэнгүй харуулав.

Зураг 34: ОХУ-н ашигт малтмалын зөвшөөрлийг олгох журмын цахимжуулалтын бэлэн байдлын үнэлгээний үзүүлэлтийн дүн




Дүгнэлт: ОХУ-н хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог голчлон зохицуулдаг “Газрын хэвлий ашиглах эрхийн дуудлага худалдаа, сонгон шалгаруулалт зохион байгуулах Роснедрагийн захиргааны журам” -д туссан 31 үүргийг жишиг болгон сонгон авч шинжилгээ хийхэд үүрэг бүрт

гүйцэтгэх үйлдэл, үйлдэлд өртөх объект болон үүрэг гүйцэтгэгчийг этгээдийг **100%** тодорхойлж томъёолсон байсан. Тодорхойлсон үүргүүдийг гүйцэтгэх маягттай байх шалгуурын хувьд **22.58** хувь бүрдүүлсэн байна. Үүний шалтгаан нь тухайн журам үүргүүдийг гүйцэтгэхэд шаардлагатай маягтуудыг бүрэн хавсаргаагүй байсан. Хавсаргасан маягтад өргөдөл гаргах маягтаас бусад үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай маягт байгаагүй ч гэсэн албан ёсны вебсайт болох www.rosnedra.gov.ru болон www.torgi.gov.ru сайтдаа зарим маягтуудыг хэрэглэгч бүрэн татан авч, ашиглах боломжтой байсан. Сайтаас дараах маягтуудыг ашиглаж болж байсан. Үүнд: хураамж төлөхөд шаардлагатай банкны дансны мэдээллийг маягт, дуудлага худалдаа, сонгон шалгаруулалтын комиссын протокол.

Иймд тухайн **77.15** хувийн доголдол нь нийт цахимжуулалтын бэлэн байдлын түвшинд сөрөг нөлөө үзүүлсэн.

Мөн тухайн улсын өнөөгийн хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог цахимжуулсан байдлын түвшинг судалж, шинжилгээ хийсэн. Шинжилгээний дүнг Зураг 35-т үзүүлэв.

Зураг 35: ОХУ-н ашиг малтмалын зөвшөөрлийг олгох журмын цахимжуулсан байдлын түвшин



Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог **цахимжуулсан** байдлын түвшин **16.13** хувьтай гарсан. Дуудлага худалдаа, сонгон шалгаруулалтын талаарх мэдээллийг олон нийтэд зарлах албан ёсны вебсайт болох www.rosnedra.gov.ru болон www.torgi.gov.ru сайтуудаар дамжуулан мэдээлэлж байгаа нь цахимжуулсан байдлын түвшинд эерэг нөлөө үзүүлж байна. Цахимжуулалтын бэлэн байдлын түвшин нь 61.3 хувь буюу хоёрдугаар түвшинд хамаарч байгаа бөгөөд шаардлагатай хэв шинжийг бүрдүүлэх замаар дижиталжуулах ажлыг зохион байгуулах боломжтой. Иймд ОХУ-нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог үүрэгт хамаарах маягтыг бүрэн тодорхойлж боловсруулснаар бүрэн дижиталжуулах боломжтой байна.

Роснедра-аас зарласан тодорхой газрын хэвлийн дуудлага худалдааны журамд дижиталжлагдсан үе шат байх боломжтой учир, дээрх дүгнэлтийг бататгахын тулд Роснедра-аас зарласан тодорхой “Газрын хэвлийг ашиглах эрхийн дуудлага худалдааны журам, нөхцөл” -г судалсан. Үүний тулд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг дуудлага худалдаагаар зохион байгуулах тухай зураглалыг Башкортостаны 2020 оны 11 сард зарласан лицензийн дуудлага худалдааны журмын дагуу судалж, шалгав.

Зураг 36: Башкортостаны 2020 оны 11 сард зарласан лицензийн дуудлага худалдааны журмын зураглал



Башкортостаны дуудлага худалдаа зохион байгуулах журмыг авч үзвэл дуудлага худалдаанд оролцох өргөдөл гаргах гэдэг үе шатанд өргөдөл гаргах маягт хавсаргасан боловч уг маягтыг дижиталжуулж онлайнаар өргөдөл өгөх шийдлийг дижиталжуулаагүй байна. Мөн уг журамд зөвхөн хайгуулын тусгай зөвшөөрөл олгох дуудлага худалдааг дүгнэж, олон нийтэд нийтлэх үе шатанд www.torgi.gov.ru платформаар уг үе шатны гүйцэтгэлийг цахимжуулсан байна.

Ингэснээр ОХУ-н ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны цахимжуулалтын бэлэн байдлын түвшин нь **61.3** хувьтай, цахимжуулсан байдлын түвшин **16.13** хувьтай гарсан.

7.4 Олон улсын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоо, цахимжуулалтын байдлын судалгааны дүгнэлт

Олон улсын ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох системийг судлахын тулд Австрали, ОХУ болон Канад улсыг сонгон авч судалсан. Австрали улс болон Канад улс нь холбооны улс учраас системийг нарийн судлах үүднээс тодорхой шалгуур боловсруулж, Баруун Австрали муж болон Канад улсын Саскачеван мужийг сонгон судласан.

Хүснэгт : Олон улсын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны харьцуулалт

№	Үзүүлэлт	Баруун Австрали	Канад улсын Саскачеван муж	ОХУ
1	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог зохицуулдаг эрх зүйн баримт бичгүүд	Mining Act 1978 Mining Regulation 1981	Mineral tenure registry regulation, 2012 Mineral disposition regulation, 1986	Газрын хэвлийн тухай хууль Тусгай үйл ажиллагааг лицензжуулах тухай хууль Тухайн газар орон нутгийн лиценз олголтийн тухай журам.
2	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог зохицуулдаг байгууллага	Уул уурхай, аж үйлдвэрийн зохицуулалт, аюулгүй байдлын газар /The Department of Mines, Industry Regulation and Safety/	Саскачеван мужийн Эрчим Хүч, Байгалийн Баялгийн Яам	Холбооны газрын хэвлий ашиглах агентлаг /Роснедра/
3	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох арга	Өргөдлөөр “first come first serve” буюу түрүүлж хүсэлт гаргасан этгээдэд	Олон нийтийн тендер	Сонгон шалгаруулалт Дуудлага худалдаа
4	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны оролцогч талууд	Тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргаж буй этгээд Уул уурхай, аж үйлдвэрийн зохицуулалт, аюулгүй байдлын газар Уул уурхайн сайд Уул уурхай, аж үйлдвэрийн зохицуулалт, аюулгүй байдлын газрын гүйцэтгэх захирал Хайгуулын тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргаж буй газрын эзэмшигч	Саскачеван мужийн Эрчим Хүч, Байгалийн Баялгийн Яам Тусгай зөвшөөрөл хүсэгч этгээд First Nation	ОХУ-н Засгийн Газар Газрын хэвлий ашиглах агентлаг Байгалийн менежментийн холбоо Байгаль, орчин, технологи, цөмийн хяналт шалгалтын холбоо
5	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаа	5 жил	1 жил /хамгийн ихдээ 8 жил/	5 жил
6	Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоонд ашиглагдаж буй программууд	Mining Titles Online Mining Notices Tenagraph Web	GeoAtlas MARS IRIS	www.rosnedra.gov.ru/ www.torgi.gov.ru

Баруун Австрали мужид ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох аргачлал нь энэ судалгаанд туссан Орос, Канад улсуудын аргачлалаас ялгаатай учир нь **“first come first serve”** буюу **түрүүлж хүсэлт гаргасан** этгээдэд Уул уурхай, аж үйлдвэрийн зохицуулалт, аюулгүй байдлын газар /The Department of Mines, Industry Regulation and Safety/-с хайгуул хийх тусгай зөвшөөрлийг олгодог. Баруун Австрали мужийн уул уурхай, аж үйлдвэрийн зохицуулалт, аюулгүй байдлын газрын гаргасан

зөвлөмжийн дагуу хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа нь үндсэн 8 үе шатнаас бүрддэг. Энэхүү 8 үе шат нь Mining Regulation-д туссан 12 үүргийн заалт, 56 тодотгох заалт, 6 маягтаас бүрдэж байна. Уул уурхайн үйл ажиллагааг зохицуулдаг баримт бичгүүдээс хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд **Mining Titles Online, Mining Notices, Tenagraph Web** зэрэг програм хангамжууд ашиглагдаж байна.

1. Mining Titles Online - Mining Act, Mining Regulation-д туссан үүргүүдийг гүйцэтгэхэд ашиглагдаж буй маягтуудыг цахимаар бүртгэх, шийдвэрлэх боломжийг бүрдүүлсэн платформ юм. Энэхүү платформоор дамжуулан Mining Regulation-д туссан нийт 43 маягтын 36-г нь цахимаар илгээх, бүртгүүлэх, шийдвэрлүүлэх боломж бүрдсэн ба мөн бусад нэмэлт журамд туссан үүргүүдийг энэ платформоор дамжуулан гүйцэтгэх боломжтой байна.

2. Mining Notices - Энэхүү платформ нь ашиг малтмал, уул уурхайн үйл ажиллагааг явуулах хүсэлт хүлээн авсан, олгосон талаар оролцогч талуудад ил тод мэдэгдэх зорилготой цахим платформ юм.

3. Tenagraph Web нь Баруун Австралийн уул уурхайн ашиглалт, газрын тосны газрын байршил, газрын бусад мэдээлэлтэй холбоотой байр суурийг харуулсан орон зайн лавлагаа, зураглалын систем юм. Энэ нь уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй газрын одоогийн бодит дүр зургийг гаргаж, ашигт малтмалын хайгуул хийх боломжтой газрыг тогтооход ашигладаг.

Эдгээр гурван програмууд нь бүгд “Mining Act”, “Mining Regulation” эрх зүйн баримт бичгүүдийг суурь оюуны шийдлээ болгож ашиглан, цахимжуулсаны үр дүнд бий болсон байна. Ингэснээр дижитал шийдлүүд болон хууль дүрэм журмуудыг уялдуулан сайжруулж, хүсэлт гаргагч этгээд дижитал платформоор дамжуулан үүргээ гүйцэтгэх боломжийг бүрдүүлж өгсөн байна.

Саскачеван мужийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргах, хүлээн авах процессыг судлан, зурагласан. Тухайн процессыг зураглахдаа дөрвөн үе шатад ангилж, үе шат тус бүрт гүйцэтгэх үйлдлүүдийг тодорхойлсон. Хайгуулын тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргагч этгээд нь Эрчим Хүч, Байгалийн Баялгийн Яамд “Subsurface mineral tenure regulation”-н дагуу өргөдөл гаргахаас өмнө боломжит ашигт малтмалын газрыг тодорхойлохдоо ISC /Ашигт малтмалын өмчлөл/ болон Geoatlas /олгогдсон тусгай зөвшөөрөл, эрх/ашиглана. Эдгээр вебсайтуудаас олж авсан мэдээлэл нь ашигт малтмалын эрхийн хүртээмжийг тодорхойлоход ашиглагддаг. IRIS-д тендерийн өргөдөл гаргахыг хүсч буй хүн бүр IRIS дахь олон нийтийн санал авах хуваарь руу орж цахим дебит кодтой болох ёстой. Бүх саналыг IRIS-ээр олон нийтэд санал болгож буй өдрийн стандарт цагийн хуваарийн дагуу өдрийн 12:00 цаг хүртэл хүлээн авах ёстой.

Тодорхойлсон процессын дагуу хайгуулын тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргаж, авахын тулд хүсэлт гаргагч этгээд бүр дараах шалгуурыг хангасан байх шаардлагатай.

7. IRIS бүртгэл болон IRIS-ийн аюулгүй байдлын зохицуулагч өгсөн зохих зөвшөөрөлтэй байх.
8. Тендерийн саналуудыг тусад нь ирүүлэх эсвэл нэг тендер ирүүлэх байдлаар илгээж болно. Тендерийн бүх саналуудад дараах мэдээллүүд багтсан байх ёстой.
 - a. Төлбөр төлөгч
 - b. Холбоо барих мэдээлэл
 - c. Итгэмжлэгдсэн төлөөлөгч
 - d. Тусгай зөвшөөрөл эзэмших этгээдийн мэдээлэл
9. Саскачеваны Эрчим хүч, байгалийн баялгийн яамтай урьдчилж зөвшөөрөгдсөн дебит (PAD) төлбөртэй байх

Оросын Холбооны Улс-н ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг **Холбооны газрын хэвлий ашиглах агентлаг /Роснедра/ цаашид “ХГХАА”** хариуцдаг. ХГХАА нь газрын хэвлий ашиглалтын чиглэлээр төрийн үйлчилгээ үзүүлэх, төрийн өмчийн гүйцэтгэх байгууллага юм. Уг байгууллага нь орон нутгийн харьяа байгууллагуудаараа дамжуулан газрын хэвлийн хайгуул


хийх эрхийн сонгон шалгаруулалт, дуудлага худалдааг тогтоосон журмын дагуу зохион байгуулдаг байна. Түүнчлэн ОХУ-ын хууль тогтоомжоор тогтоосон журмаар газрын хэвлийн талбай хайгуул хийх, эрхийн тухай тендер, дуудлага худалдааны дүнг батлах тухай эрх зүйн баримт бичиг боловсруулах, газрын хэвлий хайгуул хийх эрх олгох, түүнчлэн тусгай зөвшөөрлийг сунгах ажлыг гүйцэтгэдэг байна.

Роснедра-ийн зохион байгуулдаг газрын хэвлийн хайгуул хийх эрхийн сонгон шалгаруулалт болон дуудлага худалдаанд:

3. Байгаль орчин, технологи, цөмийн хяналт шалгалтын холбооны алба (Ростехнадзор России) нь технологийн аюулгүй байдлын чиглэлээр хяналт хийх чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.
4. Харин байгалийн менежментийн холбооны алба (Росприроднадзор)-нь газрын хэвлийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн “Газрын хэвлийн тусгай зөвшөөрлийн нөхцөлийг” дагаж мөрдөхөд хяналт тавьж, байгаль орчныг хамгаалах, газрын хэвлийг зохистой ашиглахад хяналт тавьж, Газрын хэвлийд тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд тогтмол хяналт шалгалт хийдэг байна.

Австрали, Канад, ОХУ-н ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны **цахимжуулалтын** бэлэн байдал болон **цахимжуулсан** байдлыг үнэлэн Зураг 37-д үзүүлэв.

Зураг 37: Олон улсын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны цахимжуулалтын бэлэн байдлын болон цахимжуулсан байдлын дүн



Баруун Австрали мужийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох процессын **цахимжуулалтын** бэлэн байдлын үнэлгээ **91.7** хувьтай гарсан. Энэ нь цахимжуулалтын бэлэн байдлын **нэгдүгээр түвшинд** хамаарч байгаа бөгөөд дижиталжуулах ажлын зохион байгуулах нөхцөл бүрэн бүрдсэн байна. Харин Баруун Австралид ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоонд мөгдөгддөг хууль, дүрэм, журмуудад туссан тухайн үйл ажиллагаатай шууд хамааралтай үүргүүдийг **цахимжуулсан** байдлын түвшин **100** хувьтай гарсан.

Канад улсын Саскачеван мужийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны цахимжуулалтын бэлэн байдлын түвшин нь **98.5** хувьтай, цахимжуулсан байдлын түвшин

100.00 хувьтай гарсан. Энэ нь цахимжуулалтын бэлэн байдлын **нэгдүгээр түвшинд** хамаарч байгаа бөгөөд дижиталжуулах ажлын зохион байгуулах нөхцөл бүрэн бүрдсэн байсан байна.

ОХУ-н ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох процессын **цахимжуулалтын** бэлэн байдлын үнэлгээ **61.3** хувьтай гарсан. Энэ нь цахимжуулалтын бэлэн байдлын **хоёрдугаар** түвшинд хамаарч байгаа бөгөөд шаардлагатай хэв шинжийг **бүрдүүлэх** замаар дижиталжуулах ажлыг зохион байгуулах боломжтой. ОХУ-н хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог голчлон зохицуулдаг “Газрын хэвлий ашиглах эрхийн дуудлага худалдаа, сонгон шалгаруулалт зохион байгуулах Роснедрагийн захиргааны журам” -д туссан 31 үүргийг жишиг болгон сонгон авч шинжилгээ хийхэд үүрэг бүрт гүйцэтгэх үйлдэл, үйлдэлд өртөх объект болон үүрэг гүйцэтгэгчийг этгээдийг **100%** тодорхойлж томъёолсон байсан. Тодорхойлсон үүргүүдийг гүйцэтгэх маягттай байх шалгуурын хувьд **22.58** хувь бүрдүүлсэн байна. Үүний шалтгаан нь тухайн журам үүргүүдийг гүйцэтгэхэд шаардлагатай маягтуудыг бүрэн хавсаргаагүй байсан. Иймд тухайн **77.15** хувийн доголдол нь нийт цахимжуулалтын бэлэн байдлын түвшинд сөрөг нөлөө үзүүлсэн. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог **цахимжуулсан** байдлын түвшин **16.13** хувьтай гарсан.

Эдгээр гурван улсаас Баруун Австрали болон Саскачеван мужуудын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны шийдлүүд бүрэн бүрдсэн байгаа учраас тухайн шийдлүүдэд үндэслэн цахимжуулсан байна. Харин ОХУ-н хувьд шаардлагатай дүрэм, журам, заавар гэх мэтчилэн оюуны шийдлүүд нь хангалттай бүрдээгүй байгаа тул цахимжуулсан түвшин бага байна.


8. ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ТОГТОЛЦООГ ДИЖИТАЛЖУУЛАХАД EMONGOLIA, TENDER.MN, CMCS ПРОГРАММЫГ АШИГЛАХ БОЛОМЖИЙН СУДАЛГАА

Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны оролцогч талууд болон тэдгээрийн хоорондын мэдээллийн урсгалын уялдааг **Зураг 38**-д зураглав. Зураглалд туссан мэдээллийн урсгалын үе шатуудыг дижиталжуулах арга замын дараах гурван хувилбар дэвшүүлж, хувилбар тус бүрийн боломжийг судалсан.

1. Emongolia системийг ашиглах боломж
2. Tender.mn системийг ашиглах боломж
3. CMCS системийг хөгжүүлэх боломж

Зураг 38: Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох системд оролцогч талуудын уялдааны зураглал

Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох системийн оролцогч талууд, тэдгээрийн мэдээллийн урсгал



8.1 Emongolia.mn программын судалгаа

8.1.1 E-mongolia программын ерөнхий мэдээлэл



Монгол Улсын төрийн бүх үйлчилгээг цахимжуулах, цахим засаглалыг хөгжүүлэх зорилгоор E-MONGOLIA төслийг хэрэгжүүлж эхлээд байгаа ба төслийн хүрээнд **Бүгд Найрамдах Эстони Улсын (БНЭУ)** цахим засаглалыг жишиг болгон сонгож, тус улсын цахим засаглалын академитай хамтран, өнөөгийн цахим хөгжлийн нөхцөл байдлыг тодорхойлж, Монгол Улсад хамгийн тохиромжтой загварыг хөгжүүлэн ажиллаж байна. Энэхүү систем нь цахим орчинд бүхий л төрлийн цахим үйлчилгээг авахад тухайн иргэнийг таньж баталгаажуулах боломжийг бүрдүүлэх бөгөөд хувийн хэвшил болон төрийн үйлчилгээний өөр хоорондоо харилцан хамааралгүй системүүдтэй нягт уялдаатай ажиллах боломжтой платформ бүхий систем юм.

“Төрийн үйлчилгээний операторын болон нэгдсэн портал” www.e-mongolia.mn системийг бий болгосноор эхний шатанд харилцан ялгаатай чиг үүрэг бүхий төрийн 23 байгууллагын 181 үйлчилгээг нэвтрүүлж цахимаар авах боломжтой болно. Цаашдаа иргэдэд үзүүлдэг 11 мянга 250 орчим үйлчилгээг нэг системд төвлөрүүлэхээр төлөвлөж байгаа юм.

Хүснэгт 33: Emongolia программын дэлгэрэнгүй мэдээлэл


№	Үзүүлэлт	Дэлгэрэнгүй мэдээлэл
1	Платформын нэр	E-mongolia.mn
2	Хөгжүүлэгч компани	ASTVISION
3	Платформын алсын хараа, эрхэм зорилго, зарчмууд	Emongolia нь иргэд, аж ахуй нэгжид зориулсан бүхий л төрийн үйлчилгээг нэг цахим платформд нэгтгэж хүнд сурталгүй түргэн шуурхай хүргэнэ Бид технологийн дэвшил тулгуурлан ардчиллын үзэл баримтлалыг эрхэмлэн, хувь хүний нууцлалыг тэргүүн эгнээнд тавьсан ил тод, хүртээмжтэй нийгмийг цогцлоохыг зорьж байна. ЗАРЧМУУД: Хүний эрх Технологийн дэвшлийг засаглалын эд эс болгон ашигласнаар төрийн шийдвэр гаргах процесс хурдсаж, мэдээлэл солилцоо сайжирч, төрөөс иргэдэд үзүүлдэг үйлчилгээ ил тод, түргэн шуурхай, чирэгдэлгүй болно. Бүс нутаг газар зүйн байрлалаас үл хамаарч төрийн үйлчилгээг жигд тэгш хүртээмжтэй хүрнэ. Хувь хүний нууц Иргэд өөрсдийн мэдээлэлдээ хяналт тавих, иргэн өөрөө зөвшөөрөл олгосноор тухай хүний хувийн мэдээлэлд хандах боломжийг олгох тухай хууль эрх зүйн орчныг бүрдүүлэн ажиллана Авлига, төрийн хүнд суртал Иргэд цахим үйлчилгээг ашигласнаар дунд болон доод шатны авлига, төрийн хүнд суртал буурна Мэдээллийн аюулгүй байдал Цахим засаглалын бүхий л системийг байгуулахдаа мэдээллийн аюулгүй байдлын шаардлагуудыг үргэлж баримтална Түгжрэл Технологийн дэвшлийг ашигласнаар аливаа асуудлыг шийдвэрлэх, иргэдийн амьдралын чанарыг сайжруулахын төлөө ажиллана. Мөн төрийн үйлчилгээг цахимаар авснаар замын түгжрэл буурна
4	Үйлчилгээгээ цахимжуулсан байгууллагууд	Архивын байгууллага Байгаль орчны асуудал хариуцсан төрийн байгууллага Боловсролын асуудал хариуцсан төрийн байгууллага Гаалийн байгууллага Зам, тээврийн асуудал хариуцсан төрийн байгууллага

	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
	Мэргэжлийн хяналтын байгууллага
	Нийгмийн даатгалын байгууллага
	Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар
	Татварын байгууллага
	Улаанбаатар дулааны сүлжээ
	Улсын бүртгэлийн байгууллага
	Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн байгууллага
	Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газар
	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээ хариуцсан төрийн байгууллага
	Цагдаагийн байгууллага
	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага
	Эрчим хүчний асуудал хариуцсан төрийн байгууллага
	Эрчим хүчний яам
	Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн байгууллага

Дээрх хүснэгтэд туссан Emongolia системийн зорилго нь иргэд, аж ахуй нэгжид зориулсан бүхий л төрийн үйлчилгээг нэг цахим платформд нэгтгэж хүнд сурталгүй түргэн шуурхай хүргэх зорилготой тул энэхүү зорилгын хамрах хүрээний хувьд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог дижиталжуулах үйл ажиллагааны зорилготой уялдаж байгаа нь харагдаж байна.

“Үндэсний Дата Төв” УТҮГ-ийн Emongolia систем нь иргэний өөрийнх нь зөвшөөрлийн дагуу ХУР төрийн мэдээлэл солилцооны системд бүртгэлтэй вебсервис дуудаж үр дүнг үйлчилгээг олгогч системд дамжуулдаг систем юм. Үйлчилгээг олгогч байгууллага, emongolia системээс сервис дуудах бүрт иргэн заавал тоон гарын үсэг эсвэл нэг удаагийн sms нууц кодоор өөрийгөө баталгаажуулж нэвтэрсэн байна. Уг баталгаажуулалт амжилттай болж иргэн өөрөө мэдээллээ өгөхийг зөвшөөрсөн тохиолдолд л иргэний мэдээллийг гуравдагч системд өгөх юм.

Зураг 39: Төрийн үйлчилгээний гол гурван систем



Төрийн мэдээлэл солилцооны “ХУР” систем

“ХУР” төрийн мэдээлэл солилцооны систем нь төрөөс иргэд рүү чиглэсэн үйлчилгээ, үйл ажиллагааг илүү хялбарчлах зорилгоор олон улсын жишигт нийцсэн, найдвартай ажиллагаатай, мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, цахим засаглалын суурь бүрэлдэхүүн хэсгийн нэг юм. “ХУР” нь төрийн үйлчилгээний мэдээллийг тасалдалгүй ажиллагаатай, төвлөрсөн удирдлагатай платформоор дамжуулан байгууллага хоорондын уялдаа холбоог шинэ түвшинд гаргах, иргэд аж ахуй нэгжид хүрэх төрийн үйлчилгээг хөнгөвчлөх зорилготой мэдээлэл солилцооны систем юм.

Танилт нэвтрэлтийн ДАН систем

Үйлчлүүлэгч иргэн төрийн байгууллагын цахим үйлчилгээ тус бүрт бүртгэл үүсгэн, нууц үг авах шаардлагагүй нэгдсэн нэвтрэх эрхтэй болгосон “ДАН” системийг нэвтрүүлсэн. Ингэснээр иргэд цахим орчинд бүхий л төрлийн цахим үйлчилгээг авах, төрийн байгууллагуудад байгаа өөрийн мэдээлэлтэй танилцах боломж бүрдсэн. Тус систем нь төрийн цахим үйлчилгээний ХУР, нийтийн түлхүүрийн дэд бүтцийн системүүдтэй холбогдож ажилладаг бөгөөд төрийн үйлчилгээний хүртээмж, үр ашиг, төрийн байгууллагуудын бүтээмжийг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой суурь системийн нэг нь болно.

E-mongolia буюу нэгдсэн нэвтрэлтийн системийн давуу тал:

1. Тус системийг хэрэгжүүлсэн систем нь нэр болон нууц үг хадгалах шаардлагагүй ба иргэнийг цахим орчинд таниж баталгаажуулах хөгжүүлэлтийн давхардсан зардлыг бууруулах болно.
2. Систем бүр нэгдсэн нэвтрэлтийн системийг ашигласнаар мэдээллийн аюулгүй байдлыг нэг цэгээс хянах боломж бүрдэнэ.

Төрийн нэгдсэн нэвтрэлтийн систем нь иргэнийг таньж баталгаажуулсны дараа “ХУР” системээс татсан иргэний үнэмлэхний мэдээлэл болон нэвтрэлтийн хэлбэрийг үйлчилгээний системд дамжуулах ба үйлчилгээний систем нь баталгаажуулалтын хэлбэрээс хамаарч үйлчилгээний цар хүрээг хязгаарлах шаардлагатай юм. Жишээ нь: Иргэн гэрээ зурах системд Төрийн нэгдсэн нэвтрэлтийн систем ашиглан нэвтрэх бол зөвхөн тоон гарын үсэг ашиглах шаардлагатай бол лавлагаа үйлчилгээнд бусад 2 төрлийн баталгаажуулалтын хэлбэрийг сонгох шаардлагатай болно.

E-mongolia-н бүртгэлийн системийг ашиглаж иргэн, аж ахуй нэгжийг бүртгэж, тусгай зөвшөөрөл олгох системд мэдээллээ хуваалцахыг асуусны дараа зөвшөөрвөл тусгай зөвшөөрлийн системруу үсэрдэг.

Иргэнийг таньж баталгаажуулах аргачлал


Тус систем нь иргэнийг цахим орчинд таньж баталгаажуулах 3 хэлбэртэй байна.

1. Тоон гарын үсэг ашиглан нэвтрэх: Монгол Улсын иргэн нь өөрийн регистрийн дугаар, Монгол Улсын нийтийн түлхүүрийн дэд бүтэц дээрээс үүсгэсэн тоон гарын үсэг ашиглан өөрийгөө цахим орчинд баталгаажуулах үйлдэл хийгдсэний дараа систем нэвтрэлтийг баталгаажуулах юм.
2. Гар утасны дугаараар нэг удаагийн нууц үг ашиглан нэвтрэх: Монгол Улсын иргэн нь өөрийн регистрийн дугаар, Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлдэг үүрэн сүлжээний оператор байгууллагуудаас олгогдсон гар утасны дугаараар хүлээж авсан нэг удаагийн нууц үг, үндсэн нууц үг ашиглан өөрийн бүртгэл болон нэвтрэлт бүрийг баталгаажуулах юм.
3. Үндэсний цахим шуудангийн систем ашиглан нэвтрэх: Монгол улсын иргэн нь өөрийн регистрийн дугаар, үндсэн нууц үг болон үндэсний цахим шууданд хүлээн авсан нэг удаагийн нууц үг ашиглан баталгаажуулах боломжтой юм.

8.1.2 Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог E-mongolia системтэй уялдуулан дижиталжуулах боломж

Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог дижиталжуулахад E-mongolia системтэй уялдуулах боломжийг судлан тодорхойлсон. Хайгуулын тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргах, хүлээн авах процессын 2 дахь үе шатанд хамаарах үүргийг дижиталжуулах боломжтой байгааг **Зураг 40**-д дүрслэв.

Зураг 40: Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог E-mongolia системтэй уялдуулан дижиталжуулах



Хайгуулын тусгай зөвшөөрлийн хүсэгч этгээд шаардлагатай баримт бичгийг хамт өргөдөл гаргах үүргийн тодорхой хэсгийг E-mongolia системээр дижиталжуулах боломжтой байна. E-mongolia системтэй уялдуулан дижиталжуулснаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох системийн мэдээллийн аюулгүй байдлыг нэг цэгээс хянах боломж болох юм.

Emongolia системд төрийн болон бусад байгууллагуудын системтэй холбох бүрэн боломжтой бөгөөд тодорхой шаардлага, тодорхойлолтуудыг бэлтгэн “Үндэсний Дата Төв” УТҮГ-д бүртгүүлэх ёстой. Emongolia системд байгууллагын системийг холбогдоход дараах шаардлагуудыг хангасан байх хэрэгтэй.


Emongolia системд холбогдоход тавигдах шаардлага:

7. developer.sso.gov.mn цахим хуудсанд нийтлэгдсэн OAuth 2.0 /emongolia/ нийтлэлийг сайтар уншиж танилцсан байна.
8. OAuth 2.0 протоколын талаар ойлголттой болсон байх.
9. ХҮР Төрийн мэдээлэл солилцооны системд холбогдсон байх.
10. PGP нийтийн түлхүүрийг PGP түлхүүрийн сан цахим хуудсанд оруулсан байх.
11. Холбогдож буй систем олон улсад итгэмжлэгдсэн SSL тоон гэрчилгээтэй байх.
12. Хөгжүүлэлт хийж буй байгууллага нь ядаж нэг Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй “Гэрчилгээжүүлэх Байгууллага”-аас олгогдсон тоон гэрчилгээг агуулсан И-Токен төхөөрөмжтэй байх.

Дээрх шаардлагыг хангасан тохиолдолд байгууллагаа холбох боломжтой болох бөгөөд **Зураг**

41-д үзүүлсэн дарааллын дагуу системээ холбох юм.

Зураг 41: Системд байгууллагаа холбох дараалал



Эх үүсвэр: <https://developer.sso.gov.mn/>

Эхлээд ХУР Төрийн мэдээлэл солилцооны системд холбогдох заавар авах ба тус зааврыг ХУР Төрийн мэдээлэл солилцооны системийн гарын авлагаас авна. Үүний дараа ХУР төрийн мэдээлэл солилцооны системд холбогдон, OAuth систем буюу emongolia системд холбогдох хүсэлтийг албан бичгээр мэдэгдэнэ. Тухайн албан бичиг Үндэсний Дата Төв УТҮГ-т хаяглагдан дараах мэдээллийг багтаасан байна. Жич: (ХУР төрийн мэдээлэл солилцооны системд шинээр холбогдож буй байгууллага OAuth системд холбогдох хүсэлтийг нэг албан бичгээр мэдэгдэж болно.)


1. Байгууллагын нэр.
2. Байгууллагын регистрийн дугаар.
3. OAuth системд холбогдох системийн домайн нэр.
4. OAuth системд холбогдох системийн тайлбар, үйл ажиллагааны чиглэл.
5. Хөгжүүлэлтийг хариуцан ажиллах мэргэжилтний цахим шуудангийн хаяг.

Албан бичгийг системийн хариуцсан мэргэжилтэн хүлээн авмагц, албан бичигт туссан хүсэлт гаргагч байгууллагын цахим шуудангийн хаягаар холбогдож шаардлагатай мэдээллийг PGP түлхүүрээр шифрлэж хүсэлт гаргагч этгээд рүү илгээнэ. Emongolia системд холбогдох хүсэлт гаргагч байгууллагын системүүд нь олон улсад итгэмжлэгдсэн SSL тоон гэрчилгээтэй байна. Хэрвээ SSL тоон гэрчилгээтэй бол системийн хөгжүүлэлтийг хийж, сервис дуудна.

8.1.3 Ижил төстөй программууд болон E-mongolia программуудын уялдааны зураглал, ажиллах зарчим

Харилцаа холбооны зохицуулах хороо /цаашид ХХЗХороо/ Цахим үндэстэн-Цахим шилжилт үйл ажиллагааг бүрэн дэмжиж ажиллаж байгаа бөгөөд уг ажлын хүрээнд Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын **үйлчилгээ эрхлэгчдийн тусгай зөвшөөрөл хүсэлт**, сунгалтыг цахимаар хүлээн авах систем <https://license.crc.gov.mn/user/login> нэвтрүүлж эхлүүлээд байна. Ингэснээр иргэд, үйлчилгээ эрхлэгчид болон аж ахуй нэгжүүдэд ХХЗХороо тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагааг цаг хугацаа алдалгүйгээр хандах, үйлчилгээ авах боломж бүрдэх юм. ХХЗХороо, OAuth системээс сервис дуудах бүрт иргэн заавал тоон гарын үсэг эсвэл нэг удаагийн sms нууц кодоор өөрийгөө баталгаажуулж нэвтэрсэн байна. Уг баталгаажуулалт амжилттай болж иргэн өөрөө мэдээллээ өгөхийг зөвшөөрсөн тохиолдолд л иргэний мэдээллийг ХХЗХороо-ны системд өгөх юм.

Зураг 42: Иргэн эсвэл хуулийн этгээд харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын үйлчилгээний тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргах замын зураг



Зураг 42-д Харилцаа холбооны зохицуулах хорооны тусгай зөвшөөрлийн систем нь Emongolia системтэй хэрхэн уялдаж ажилладаг процессыг зураглалаар харуулсан. Энэхүү процессын алхам нэг бүрийг системийн зураг болон тайлбартай дараах зургуудад танилцуулав.

Зураг 43: Харилцаа холбооны зохицуулах хорооны системийн нэвтрэх хуудас

Эх үүсвэр: <https://license.crc.gov.mn/user/login>

Тусгай зөвшөөрөл хүсэгч этгээд Харилцаа холбооны зохицуулах хорооны сайтруу нэвтэрч, иргэн эсвэл хуулийн этгээд гэсэн сонголтын аль тохиромжтойг сонгоно.

Зураг 44: Emongolia системийн нэвтрэх хуудас

Эх үүсвэр: <https://e-mongolia.mn/>

Иргэн эсвэл хуулийн этгээдийн аль нэгийг сонгосны дараа Харилцаа холбооны зохицуулах хорооны тусгай зөвшөөрлийн системээс Emongolia систем уруу үрэсч тусгай зөвшөөрөл хүсэгт этгээд Emongolia системд нэвтрэх гурван арга замууд болох тоон гарын үсэг ашиглах, нэг удаагийн нууц үг ашиглах болон үндэсний цахим шуудангийн систем ашиглах эдгээрээс аль боломжтойг нь хэрэглэн нэвтрэнэ.

Зураг 45: Emongolia системийн мэдээлэл дамжуулалтыг баталгаажуулах хуудас

Эх үүсвэр: <https://e-mongolia.mn/>

Emongolia систем руу нэвтрэхэд дээрх зурагт туссан асуултыг асуух бөгөөд зөвшөөрсөн тохиолдолд Emongolia системийн тусгай зөвшөөрөл хүсэгч этгээдийн хувийн мэдээллийг Харилцаа холбооны зохицуулах хорооны систем руу дамжуулах юм.

Зураг 46: Харилцаа холбооны зохицуулах хорооны тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргах хуудас

Эх үүсвэр: <https://license.crc.gov.mn/user/login>

Харилцаа холбооны тусгай зөвшөөрөл хүсэгт этгээд нь Харилцаа холбооны зохицуулах хорооны тусгай зөвшөөрлийн системд шинээр хүсэлт гаргах гэсэн товчийг дарснаар тусгай зөвшөөрлийн төрлөөс аль тохиромжтой сонгон **Зураг 47**-д үзүүлсэн дарааллын дагуу мэдээллээ бүрэн, үнэн зөв оруулах ёстой.

Зураг 47: Харилцаа холбооны зохицуулах хорооны тусгай зөвшөөрлийн систем

Телевизийн өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн тусгай зөвшөөрөл


Маягт сонгох


Байгууллагын мэдээлэл
нягтлах


Мэдээлэл бөглөх


Албан тоот, өргөдөл
хавсаргах


PDF татах


Тоон гарын үсгээр
баталгаажуулах

Телевизийн өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн тусгай зөвшөөрөл Форм бөглөх дугаар: e15d8b47-0bf3-4748-8b75-4d333e9e9aa

Байгууллагын РД

Нэр *

Утас

Веб сайт

Эх үүсвэр: <https://license.crc.gov.mn/user/login>

Харилцаа холбооны тусгай зөвшөөрлийн системд нэвтрэн тусгай зөвшөөрлийн төрөл сонгох буюу маягтыг сонгосноор дараагийн хэсэг болох байгууллын мэдээлэл нягтлах хэсэг рүү шилжинэ. Тухайн хэсэг мэдээллээ үнэн, зөв, цэгцтэй тусгах шаардлагатай. Бүх мэдээллээ оруулсны дараа албан бичиг, өргөдлөө хавсаргана. Тусгай зөвшөөрөл хүсэгч этгээд нь мэдүүлсэн хүсэлтийнхээ хуулбарыг өөрт авч үлдэх боломжтой бөгөөд PDF татах гэсэн хэсгийг идэвхжүүлнэ. Хамгийн сүүлд нь тусгай зөвшөөрөл хүсэгч этгээд өөрийн тоон гарын үсгээр баталгаажуулалт хийснээр хүсэлт амжилттай илгээгдэнэ.

8.2 CMCS программын судалгаа

Нийгмийн тогтолцоог дижиталжуулах үйл ажиллагааны товч тайлбар:

Бид аливаа програмын мөн чанарыг танихын тулд тухайн програмын цаана оршиж буй оюуны шийдэл, загваруудыг ойлгох шаардлагатай байдаг. Энэхүү **“оюуны шийдэл”** гэсэн ойлголтын цаана тухайн програмын зорилго, програмын хэрэглэгчийн хэрэгцээ, мөн тухайн програмын үйл ажиллагааны цар хүрээг тогтоож буй эрх зүйн баримт бичиг болон нийгмийн тогтолцооны загвар багтана. Энэхүү зарчмын бодит хэрэгжилтийг Баруун Австрали мужийн жишээнээс харах боломжтой. Тухайлбал, Баруун Австрали муж нь уул уурхайн салбарын үйл ажиллагааг зохицуулах зорилгоор **“Mining Titles Online”** програмыг хөгжүүлсэн байдаг. Харин энэхүү програмыг хөгжүүлэхэд ашигласан суурь оюуны шийдэл нь **Mining Act /1978/, Mining Regulation /1981/** гэсэн эрх зүйн баримт бичгүүд байсан ба, програмаар бүртгэл хийх өгөгдлийн сангийн бүтцийг энэхүү эрх зүйн баримт бичгүүдийн заалт, маягтуудыг ашиглан гаргасан байна.

Баруун Австрали мужийн жишээтэй адил, тодорхой төлөвшсөн тогтолцоог дижиталжуулах замаар програм бүтээх гэж буй тохиолдолд програм нь зайлшгүй тухайн тогтолцооны оюуны шийдлүүдтэй уялдах шаардлагатай байдаг. Тухайн уялдааг бүрдүүлээгүй тохиолдолд програм хөгжүүлэлтийн үйл ажиллагаа үр дүнгээ гаргаж чаддаггүй. McKinsey компанийн боловсруулан гаргасан **“Unlocking Success in digital transformation”** судалгааны дүгнэлтэд нийт дижитал шилжилт хийх төслийн 70-аас илүү хувь нь амжилтгүй болдог гэсэн байдаг. Тухайн дижитал шилжилт хийх үйл ажиллагааны голлох шалтгаануудаас дурьдвал:

- Байгууллагын загвар нь бэлэн худалдаалж буй дижитал шийдэлтэй уялдадгүй
- Оролцогч талууд хүлээн зөвшөөрсөн тогтвортой хэрэгцээ шаардлага байхгүй
- IT шийдэл хөгжүүлэгч болон захиалагч нарын хооронд тогтмол ойлголтын зөрүү үүсдэг
- Байгууллагын үйл ажиллагааны нарийвчилсан загвар байхгүй

Энэ шалтгаанууд дийлэнх нь оюуны шийдэл болон дижитал шийдэл хоорондын зөрчилдөөнөөс гарч байна гэж дүгнэж болно. Харин оюуны шийдэлд туссан ойлголт болон програмын өгөгдлийн баазын бүтэцүүд нь тухайн хоёр зүйлийг уялдуулдаг. Жишээ нь Баруун Австрали мужийн Mining Regulation-д “тусгай зөвшөөрөл” гэсэн ойлголтууд олон давтамжтай туссан байдаг ба энэ ойлголтыг дижиталжуулсны үр дүнд **“Mining Titles Online”** болон **“Mining Notices”** дижитал шийдлүүд дээр “тусгай зөвшөөрөл” гэх ойлголтыг илэрхийлэх өгөгдлүүдийг бүртгэж байна.

Тэгвэл энэ онолыг практик аргачлал, процеслүү хөрвүүлбэл доорх зураг 48-д харуулсантай ижил үндсэн 8 үе шатанд хувааж болно. Үүнд:

1. Тогтолцооны **“Нэгдмэл зорилго”** тодорхойлох
2. Тогтолцооны нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэхэд ашиглаж буй хууль, дүрэм, журмуудыг тодорхойлох
3. Хууль дүрэм журмуудыг бүрдүүлж буй үүргүүдийг тодорхойлох
4. Үүргийг нарийвчлан задлан, сүбъект, үйл, тусагдахуунуудыг тодорхойлох
5. Сүбъект, үйл, тусагдахуунуудыг бүрдүүлж буй ойлголтуудыг өгөгдлийн бүтцээр илэрхийлэх.
6. Ойлголтуудыг ашиглан програмын өгөгдлийн баазын бүтцийг тодорхойлох, өгөгдлийн баазыг хөгжүүлэх
7. Үйлдэл тусагдахуунуудыг дижиталжуулах
8. Үйлдлүүдийг автоматжуулах


Өөрөөр хэлбэл дүрэм журамд туссан ойлголтууд маань програмын үндсэн суурь болох өгөгдлийн баазын бүтцийг тодорхойлдог болно.

Зураг 48: Нийгмийн тогтолцоог дижиталжуулах үйл ажиллагааны логик дарааллын зураглал




Үүнтэй адил, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа нь бие даасан нийгмийн нэгж тогтолцоо тул тухайн тогтолцоонд нийцсэн уялдаатай үр дүн бүхий цахимжуулсан шийдэл боловсруулахын тулд эхлээд бид энэ тогтолцоог хэрэгжүүлэхэд ашиглагдаж буй дүрэм журамд туссан ойлголтуудыг таних зайлшгүй хэрэгцээ шаардлага үүсэж байна.

Зураг 49: Нийгмийн тогтолцоог дижиталжуулах үйл ажиллагааны логик дарааллын зураглалын жишээ




Зураг 50: Уул уурхайн кадастрын системийн нүүр зураг



Улмаар бид эхлээд хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохицуулж буй дүрэм журамд туссан ойлголтуудыг илрүүлэн, тухайн ойлголтуудаас CMCS програмд бүртгэж буй өгөгдлүүдтэй харьцуулах замаар тухайн оюуны шийдэл болон дижитал шийдлүүдийн хоорондын уялдааг тодорхойлсон болно.

Зураг 51: Хайгуулын тусгай зөвшөөрлийн сонгол шалгаруулалтын журмын суурь ойлголтууд болон цахимжуулсан объектууд



CMCS програмын судалгаа

CMCS програмыг 2008-2012 онд Дэлхийн банкны “Засаглалыг дэмжих төсөл”-ийн 1,4 сая ам.долларын санхүүжилтээр “GAF AG Germany” компани хийсэн бөгөөд 2013 онд хэрэглэгчдэд зориулж тусгайлсан сервис хөгжүүлж интернетээр тусгай зөвшөөрлийн байршил, бүртгэлийн товч мэдээлэлтэй танилцах боломжийг бүрдүүлсэн.

Хүснэгт 34: CMCS програмын дэлгэрэнгүй мэдээлэл

№	Үзүүлэлт	Дэлгэрэнгүй мэдээлэл
1	Платформын нэр	The Computerized Mining Cadastre System /CMCS/ https://cmcs.mrpam.gov.mn/cmcs
2	Хөгжүүлэгч компани	GAF AG Germany
3	Платформыг хэрэгжүүлж буй төслийн зорилго	Төслийн үндсэн зорилго нь Монгол Улсад орчин үеийн, бүрэн автоматжуулсан уул уурхайн бүртгэл, кадастрын системийг буй болгох, кадастрын зураг, дагалдах мэдээллийг агуулсан, бодит цагийн орчинд ажиллах веб хуудсыг нэвтрүүлэх, түүнчлэн тусгай зөвшөөрөл олгох болон түүнтэй холбогдсон кадастрын үйл ажиллагааны менежментийг боловсронгуй болгох улмаар уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нөлөө үзүүлэхэд оршино.

Энэ судалгааны хүрээнд хүлээн авсан мэдээлэл дээр үндэслэн CMCS програм дээр өгөгдөл болгон бүртгэл хийж буй дараах ойлголтуудыг тодорхойлсон. Үүнд:

1. Газар /Area/
 - a. Тусгай зөвшөөрөл олгосон газар
 - b. Тендер зарласан газар
 - c. ТЗ-ийн өөрчлөлт хийж буй газар
 - d. Тусгай хэрэгцээний газарууд
2. Газрын Солбицол /Area coordinates/
3. Газрын эзэмшигч
4. Газрын ашигт малтмалын төрөл /mineral/
5. Газрын төрөл
6. Газрын төлөв
7. Газрын зураг гэсэн объектууд тус тус багтаж байна.


Харин хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны оюуны шийдэл болох “Хайгуулын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтын журамд” нийт 37 үүрэг, 52 тусагдахуун /объект/

ойлголтууд туссан байна. Энэ 57 ойлголтын тодотгол мэдээллүүдийг хасаж, давхцлыг арилгавал нийт 28 ойлголтууд үлдэж байна. Үүнд:

1. Талбай
2. Талбайн солбицол
3. Талбайн зураг
4. Хуулийн 17.1-д заасан мэдэгдэл
5. Талбай тус бүрээр багц мэдээллийг бэлтгэх ажил
6. Сонгон шалгаруулалт явуулах талбай тус бүрийн геологи-ашигт малтмал
7. Сонгон шалгаруулалтын урилга
8. /Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад оролцоход/ Шаардлагатай баримт бичгийг
9. Сонгон шалгаруулалтын санал бүртгэх дэвтэр
10. Сонгон шалгаруулалтын санал
11. /Сонгон шалгаруулалтын санал нь журмын 3.5 ба 3.6-д заасан шаардлагыг хангаагүй тухай тэмдэглэл/ Тэмдэглэл
12. Сонгон шалгаруулалтад шалгараагүй бусад оролцогчийн төлсөн босго үнэ
13. Нийслэлийн Засаг даргаас ирүүлсэн санал
14. Стратегийн ач холбогдол бүхий ордын талбайн хил заагт хамаарсан талбайд тусгай зөвшөөрөл олгох асуудал
15. Техникийн санал
16. Сонгон шалгаруулалт зарласан талбайд ирүүлсэн техникийн санал нь журмын 3.3.2, 3.4-т заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгах ажиллагаа
17. журмын 4.2.2-т заасан ажиллагаанд оролцох нөхцөл
18. Сонгон шалгаруулалтад оролцогчоос ирүүлсэн саналын эх хувь
19. Сонгон шалгаруулах комиссын үнэлгээний хуралдааны тэмдэглэл
20. Үнийн санал
21. Үнийн санал нээх ажиллагаа
22. Сонгон шалгаруулалтад оролцогчдоос ирүүлсэн үнийн саналын үнэлгээ
23. Тусгай зөвшөөрөл олгох тухай дүгнэлт
24. /Тусгай зөвшөөрөл олгох тухай дүгнэлт/ Холбогдох тушаал
25. түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох шийдвэр
26. Үйлчилгээний хөлс, түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр
27. түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл
28. АМГТГ хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон тухай мэдээлэл

Оюуны шийдэлд туссан ойлголтуудтай давхцаж буй CMCS програм дээр бүртгэл хийж буй ойлголтуудыг харьцуулсаны үр дүнд дараах зурагт тэмдгэлсэн үүргүүдийг шуурхай CMCS програмыг ашиглан дижиталжуулах боломжтой байна.

Зураг 52: Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог CMCS программаар дижиталжуулах боломжийн зураглал



Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог дижиталжуулахад “Хайгуулын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтын журам”-н 6 үе шатыг CMCS программын өнөөгийн хөгжүүлэлтэд үндэслэн дижиталжуулах боломжтой байна. Үүнд:

1. 1.2 “АМТХ-н 11.1.25-д заасны дагуу төрийн захиргааны байгууллага нь талбайн солбицлыг тодорхойлохдоо тухайн аймаг, нийслэлийн Засаг даргад бичгээр мэдэгдэх бөгөөд түүнд талбайн зургийг хавсаргана” гэсэн үүргийн тодорхой хэсгийг CMCS программаар дижиталжуулах боломжтой.
2. 1.5 “Төрийн захиргааны байгууллага нь Засгийн газраас тогтоосон талбайн солбицлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ” гэсэн үүргийг CMCS программ болон MRPAМ вебсайтаар цахимжуулсан байна.
3. 1.8 “Төрийн захиргааны төв байгууллага нь багц мэдээлэлтэй танилцаж, сонгон шалгаруулалт явуулах талбайг эцэслэн сонгож, Төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ” гэсэн үүргийн тодорхой үйлдлийг CMCS программаар дижиталжуулах боломжтой.
4. 4.1 “АМГТГ нь түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох шийдвэрийг хуулийн этгээдэд мэдэгдэнэ” гэсэн үүргийн тодорхой хэсгийг CMCS программаар дижиталжуулах боломжтой.
5. 4.4 “АМГТГ нь түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг хуулийн этгээдэд олгох” гэсэн үүргийн тодорхой хэсгийг CMCS программаар дижиталжуулах боломжтой.
6. 4.5 “АМГТГ хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон даруйд энэ тухай байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн талбай байрших аймаг, сум, дүүргийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын албанд мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ” гэсэн үүргийн тодорхой хэсгийг CMCS программаар дижиталжуулах боломжтой.

8.3 Tender.mn программын судалгаа

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах, зохион байгуулах, уг ажиллагаанд хяналт тавих, гомдол маргаан шийдвэрлэх зэрэг үйл ажиллагааг хурдан шуурхай, мэдээллийн давхардал, алдагдалгүйгээр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль мөн худалдан авах ажиллагааны ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хүрээнд цахим хэлбэрээр явуулахад системийн зорилго оршино.

Уг цахим системийн хэвийн үйл ажиллагааг Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцан ажилладаг.

Хүснэгт 35: www.tender.gov.mn сайтын дэлгэрэнгүй мэдээлэл

No	Үзүүлэлт	Дэлгэрэнгүй мэдээлэл
1	Платформын нэр	/www.tender.gov.mn ²
2	Платформын тухай	Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 5.2.2.-т “Төсөл, тендерийн шалгаруулалтыг олон нийтэд ил тод болгож “Шилэн тендер шалгаруулалт” бодлого хэрэгжүүлнэ.” гэж заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас “Худалдан авах ажиллагааны нэгдсэн цахим систем”/ www.tender.gov.mn /-ийг 2017 оноос ашиглалтанд оруулан ажиллаж байна. Уг систем нь Монгол улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй бүх тендер шалгаруулалтын урилга, үр дүнгийн мэдээллийг “Уламжлалт” эсвэл “Цахим” тендерээс үл хамааран олон нийтэд нэгдсэн байдлаар хүргэх, “Цахим тендер шалгаруулалт”-ыг зохион байгуулах зорилготой бөгөөд худалдан авах ажиллагаатай холбоотой хууль, журам, баримт бичгүүд болон түүний төлөвлөгөө, АЗ сертификат эзэмшигчдийн нэгдсэн мэдээлэл зэргийг ил тод мэдээлэх зэрэг үүрэгтэй систем юм. https://www.pcsp.gov.mn/n/1111
3	Бүртгэлтэй журам	1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль 2.Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам
4	Үйл ажиллагаа явуулж эхэлсэн огноо	2017 он
5	Төсвийн ерөнхийлөн захирагч	Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын газар Хууль зүй дотоод хэргийн сайд Эрчим хүчний сайд 21 Аймгийн засаг дарга Нийслэлийн засаг дарга Өвөрхангай Аймгийн засаг дарга Нийслэлийн засаг дарга Эрүүл Мэндийн Сайд

² Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.25-т зааснаар “худалдан авах ажиллагааны цахим систем” гэж цахим программ хангамжийг ашиглан худалдан авах ажиллагааг төлөвлөх зохион байгуулах, тайлагнах, хяналт тавих цогц үйл ажиллагаа, мэдээллийн тогтолцоог;

6	Тендерийн төрөл	1. Ажил 2. Зөвлөх үйлчилгээ 3. Зөвлөхөөс бусад үйлчилгээ 4. Бараа
7	Хамтрагч байгууллагууд	1.Төрийн банк 2.Чингис Хаан Банк 3. Хасбанк 4.Капитрон Банк 5.NIBank 6.Ариг Банк 7.Голомт Банк 8.Хаан Банк 9.Худалдаа Хөгжлийн Банк

Уг сайтын ажиллагааны ерөнхий зураглалыг “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын дагуу боловсруулсан.

Зураг 53: tender.gov.mn сайтын худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээллийг зураглал

Tender.mn Цахим системд нэвтрэх эрх авсан захиалагч цахим худалдан авах ажиллагааг дараах дарааллын дагуу зохион байгуулна



Захиалагч, тендерт оролцогч болон холбогдох бусад этгээд цахим системийг хэрэглэхдээ хууль тогтоомж, түүнд нийцүүлэн төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон мэргэжлийн байгууллагаас гаргасан журам, аргачлал, зааварчилгааг дагаж мөрддөг байна.

Захиалагч нь цахим системд бүртгүүлэхдээ захиалагч, түүнийг төлөөлөн цахим системд нэвтрэх эрх авах ажилтны нэр, албан тушаал, цахим шуудан, утасны дугаар, тендерийн баримт бичгийн үнэ шилжүүлэх Төрийн сангийн дансны мэдээлэл бүхий хүсэлтээ албан бичгээр мэргэжлийн байгууллагад хүргүүлнэ. Хүсэлтэд захиалагч байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг хавсаргасан байна. Уг хүсэлтийг нь мэргэжлийн байгууллага хянаж шаардлага хангасан бол ажлын 3 хоногт багтаан цахим системд бүртгэж, хариуцсан ажилтанд нэвтрэх эрхийг цахим шуудангаар олгодог байна.

Цахим худалдан авалтад оролцохыг сонирхогч этгээд нь цахим системд бүртгүүлэхдээ тендерт оролцогчийг төлөөлөн цахим системд нэвтрэх эрх авах ажилтны нэр, албан тушаал, цахим шуудан, утасны дугаар бүхий хүсэлтээ албан бичгээр мэргэжлийн байгууллагад хүргүүлнэ. Хүсэлтэд хуулийн

этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /тендерт оролцогч нь иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар/, тендерт оролцогчийг төлөөлөх ажилтны мэдээлэл бүхий иргэний үнэмлэхийн хуулбарыг тус тус хавсаргасан байдаг байна. Уг хүсэлтэд мэргэжлийн байгууллага тендерт оролцогчийн хүсэлтийг хянан, шаардлага хангасан бол ажлын 3 хоногт багтаан цахим системд бүртгэж, хариуцсан ажилтанд нэвтрэх эрхийг цахим шуудангаар олгодог байна.

Цахим системд бүртгүүлсэн захиалагч нь тендерийн урилга, тендерийн баримт бичиг /санхүүгийн шаардлага, тендерийн баталгааны мэдээлэл, хүний нөөцийн мэдээлэл, техник тоног төхөөрөмж, худалдан авах бараа, ажил, үйлчилгээний мэдээлэл/-ийг цахим системд нийтэлсний дараа, тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө тендерээ электрон хэлбэрээр буюу “PDF” форматаар гаргацтай, тод хөрвүүлж илгээх, ингэхдээ өөрийн санал болгож буй тендерийн үнэ, хүчинтэй хугацаа болон холбогдох бусад мэдээллийг системийн холбогдох талбарт бүрэн оруулсан байх зэрэг мэргэжлийн байгууллагаас тогтоосон бусад аргачлал, зааврыг баримталж тендер илгээх, үүний дараагаар тендерийн баримт бичигт заасан тендер хүлээж авах эцсийн хугацаа дуусахад үнэлгээний хороо хуулийн 26.1-д зааснаар тендерийг цахим системээр дамжуулан нээн үнэлэх үе шат явагдана. Ирүүлсэн өргөдлүүдийг үнэлгээний хороо үнэлэн “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам”-ын дагуу олон нийтэд ил болгодог байна.

Дээрх зураглалд туссан үе шатыг нэгтгэн дүгнэвэл, www.tender.gov.mn сайт нь хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны дараах дөрвөн үе шатыг цахимжуулсан байна.

Зураг 54: tender.gov.mn сайтын цахимжуулсан үе шат




Ингэснээр www.tender.gov.mn сайт нь хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны дараах үе шатыг цахимжуулсан байна:

1. Олон нийтэд нийтэлж байгаа үе шатыг
2. Өргөдлийг цахимаар гаргаж байгаа үе шатыг
3. Өргөдлийг хүлээн авах нээх үе шатыг

www.tender.gov.mn сайтын сонгон шалгаруулалт зохион байгуулах үйл ажиллагаа, хайгуулын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтын дараах үе шатуудыг дижиталжуулах боломжтой байна.

Зураг 55: Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог tender.gov.mn системтэй уялдууланд дижиталжуулах боломж




Tender.mn нь хайгуулын тусгай зөвшөөрлийг олгох үйл ажиллагааны дараах үе шатуудыг дижиталжуулах боломжтой байна. Үүнд:

- Хайгуулын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтын журмын 1.5-т заасан “Төрийн захиргааны байгууллага нь Засгийн газраас тогтоосон талбайн солбицлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ” болон 1.9 “Журмын 3.1.5-д заасан талбайд сонгон шалгаруулалт явуулахаас 30-аас доошгүй хоногийн өмнө Төрийн захиргааны байгууллага нь сонгон шалгаруулалтын урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ” гэсэн үүргийг www.tender.gov.mn “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ийн 3.2.2.-т заасан “Үнэлгээний хороо тендерийн баримт бичгийг боловсруулж, захиалагчаар батлуулсны дараа тендерийн урилга, тендерийн баримт бичиг /санхүүгийн шаардлага, тендерийн баталгааны мэдээлэл, хүний нөөцийн мэдээлэл, техник тоног төхөөрөмж, худалдан авах бараа, ажил, үйлчилгээний мэдээлэл/-ийг цахим системд нийтлэх” гэсэн заалтыг үндэслэн тус сайт дээр дижиталжуулах боломжтой байна.
- Хайгуулын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтын журмын 2.1-т заасан “Хуулийн этгээд хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтээ АМТХ-н 10.1.2-т заасан журмын дагуу өргөдлөөр төрийн захиргааны байгууллагад гаргах бөгөөд шаардлагатай баримт бичгийг хавсаргана. (АМТХ 18.1)” гэсэн үүргийг www.tender.gov.mn “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ийн 3.3.2. “Тендерт оролцогч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө тендерээ электрон хэлбэрээр буюу “PDF” форматаар гаргацтай, тод хөрвүүлж илгээх, ингэхдээ өөрийн санал болгож буй тендерийн үнэ, хүчинтэй хугацаа болон холбогдох бусад мэдээллийг системийн холбогдох талбарт бүрэн оруулсан байх зэрэг хуулийн 53.5.4-т заасны дагуу мэргэжлийн байгууллагаас тогтоосон бусад аргачлал, зааврыг баримталж тендер илгээх” гэсэн заалтыг үндэслэн тус сайт дээр дижиталжуулах боломжтой байна.
- Хайгуулын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтын журмын 2.2 “Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийн өргөдлийг хүлээн авч бүртгэх (АМТХ 11.1.16)” гэсэн үүргийг www.tender.gov.mn “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ийн 3.2.5.2-т заасан “Тендерийн баримт бичигт заасан тендер хүлээж авах эцсийн хугацаа дуусахад үнэлгээний хороо хуулийн 26.1-д зааснаар тендерийг цахим системээр дамжуулан нээх” гэсэн заалтыг үндэслэн тус сайт дээр дижиталжуулах боломжтой байна.
- Хайгуулын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтын журмын 4.1-т заасан “АМГТГ нь түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох шийдвэрийг хуулийн этгээдэд мэдэгдэнэ” гэсэн заалт болон 4.5-т заасан “АМГТГ хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон даруйд энэ тухай байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн талбай байрших аймаг, сум, дүүргийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын албанд мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ” гэсэн үүргийг www.tender.gov.mn “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ийн 3.2.7.-т заасан “Үнэлгээний хороо хуулийн 29.1-д заасан мэдэгдэл хүргүүлсэн өдөрт багтаан цахим системд тендер шалгаруулалтын үр дүнг үнэн зөв, бүрэн нийтэлж, шалгарсан тендерт оролцогчийн ирүүлсэн тендерийн нууцлаагүй хэсгийг Сангийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 132 дугаар тушаалаар батлагдсан “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам”-ын дагуу ил болгох” гэсэн заалтыг үндэслэн тус сайт дээр дижиталжуулах боломжтой байна.

8.4 Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог дижиталжуулах арга зам

Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог дижиталжуулах боломжтой арга замуудыг АМГТГ болон УУХҮЯ-н холбогдох ажилтнуудтай ярилцсаны үндсэн дээр дараах арга замуудын хувилбаруудыг тодорхойлсон.

Зураг 56: Хайгуулын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтын журмын үүргүүдийн үрсгал зураг



Зураг 50-д цэнхэр өнгөөр тэмдэглэгдсэн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны 8 үүргүүдийг хэрэгжиж буй оюуны шийдлүүд буюу дүрэм, журам, заавар үндэслэн **программын өнөөгийн хөгжүүлэлтэд тохируулан** дижиталжуулах боломжтой байна. Үүнд:

1. Ашигт малтмалын тухай хуулийн 11.1.25-д заасны дагуу *“төрийн захиргааны байгууллага нь талбайн солбицлыг тодорхойлохдоо тухайн аймаг, нийслэлийн Засаг даргад бичгээр мэдэгдэх бөгөөд түүнд талбайн зургийг хавсаргах”* үүргийн **тодорхой хэсгийг** MRPAM-н программаар дижиталжуулах боломжтой байна.
2. *“Төрийн захиргааны байгууллага нь Засгийн газраас тогтоосон талбайн солбицлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ”* үүргийг MRPAM-н программ болон Tender.mn программаар дижиталжуулах боломжтой байна.
3. Хайгуулын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтын журмын 3.1.5-д заасан *“талбайд сонгон шалгаруулалт явуулахаас 30-аас доошгүй хоногийн өмнө Төрийн захиргааны байгууллага нь сонгон шалгаруулалтын урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ”* үүргийг MRPAM-н программаар дижиталжуулах боломжтой байна.
4. *“Хуулийн этгээд хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтээ АМТХ-н 10.1.2-т заасан журмын дагуу өргөдлөөр төрийн захиргааны байгууллагад гаргах бөгөөд шаардлагатай баримт бичгийг хавсаргана”* үүргийн **тодорхой** хэсгийг Emongolia программ болон Tender.mn программаар дижиталжуулах боломжтой байна.
5. *“Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийн өргөдлийг хүлээн авч бүртгэх”* үүргийн **тодорхой** хэсгийг Emongolia программ болон Tender.mn программаар дижиталжуулах боломжтой байна.
6. *“АМГТГ нь түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох шийдвэрийг хуулийн этгээдэд мэдэгдэнэ”* үүргийг MRPAM программ болон Tender.mn программаар дижиталжуулах боломжтой байна.
7. *“АМГТГ нь түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг хуулийн этгээдэд олгох”* үүргийг MRPAM программаар дижиталжуулах боломжтой байна.
8. *“АМГТГ хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон даруйд энэ тухай байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн талбай байрших аймаг, сум, дүүргийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын албанд мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ”* үүргийг MRPAM программ болон Tender.mn программаар дижиталжуулах боломжтой байна.

9. АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ


1. <https://www.canlii.org/en/sk/laws/regu/>
2. <https://laws-lois.justice.gc.ca/eng/>
3. <https://www.saskatchewan.ca/business/agriculture-natural-resources-and-industry/oil-and-gas/crown-land-sales-dispositions-and-tenure/public-offerings>
4. <https://www.saskatchewan.ca/business/agriculture-natural-resources-and-industry/oil-and-gas/crown-land-sales-dispositions-and-tenure/public-offerings/bidding-on-crown-public-offering-parcels>
5. <https://er-saskatchewan.hub.arcgis.com/pages/saskatchewan-geological-survey>
6. <https://publications.saskatchewan.ca/#/categories/2500>
7. https://www.saskatchewan.ca/IRIS#utm_campaign=q2_2015&utm_medium=short&utm_source=%2FIRIS
8. <https://iris.gov.sk.ca/Portal/Security/Credentials/Login.aspx?ReturnUrl=%2fPortal>
9. <https://www.saskatchewan.ca/business/agriculture-natural-resources-and-industry/mineral-exploration-and-mining/mineral-tenure/mineral-administration-registry-saskatchewan-mars>
10. MARS системийн гарын авлага
11. <https://publications.saskatchewan.ca/#/categories/2521>
12. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам
13. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг бүртгэх, хянан шийдвэрлэх үйл ажиллагааны заавар
14. <https://mrpam.gov.mn/article/57/>
15. <https://mrpam.gov.mn/article/60/>
16. <https://mrpam.gov.mn/article/52/>
17. <https://mrpam.gov.mn/article/132/>
18. <https://crc.gov.mn/k/36X>
19. <https://developer.sso.gov.mn/>
20. <https://developer.sso.gov.mn/start/intro.html>
21. <https://developer.sso.gov.mn/oauth.html>
22. <https://www.montsame.mn/mn/read/246236>
23. http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_852/225438e8e83cc987039866676dfaf5a7036dbd73/
24. http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_48132/f96bbe3f4bd5a43c29926e16245ee11c8154f597/
25. http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_113658/f54f9225be124402c800a8b69aee1a0fe1614b19/
26. http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_343/
27. <https://www.rosnedra.gov.ru/article/11630.html>
28. www.torgi.gov.ru/index.html
29. <https://pfo.rosnedra.gov.ru/page/177.html>
30. <https://www.tender.gov.mn/mn/index/>

10. ХАВСРАЛТ

Хавсралт 1: Системийн төлөв байдлын үнэлгээний хувь

Системийн төлөв байдлын оношилгооны дүн /хувиар/

- Хэвийн үйл ажиллагаатай байгууллагын дүн /хувиар/
- Оношилгооны дүн /хувиар/
- Зорилгын тайллын дэд тогтолцоо



Хавсралт 2: Системийн төлөв байдлын оношилгооны нарийвчилсан үнэлгээ

Дэд тогтолцоо	Хэв шинжүүд	Код	Хэв шинжийг хангах дэд тогтолцооны шийдлүүд	Хэв шинжийг хангах дэд тогтолцооны шийдлүүд бүрдсэн эсэх	Авсан үнэлгээ
А. Зорилгын тайллын дэд тогтолцоо					
ЗТ.1	Нэгдмэл зорилго нь албан ёсоор баталгаажсан байх ёстой	ЗТ.1 - Ш.1	Нэгдмэл зорилго нь албан ёсоор баталгаажсан байх ёстой хэв шинжийг дүрэм, журамд тусгасан байх	2	12
		ЗТ.1 - Ш.2	Нэгдмэл зорилгыг батлах үүргийг тодорхой этгээдэд хүлээлгэсэн байх	2	
		ЗТ.1 - Ш.3	ЗТ.1 - Ш.2 үүргийн хэрэгжилтийг баримт, фактанд үндэслэн шалгах боломжтой байх	2	
		ЗТ.1 - Ш.4	ЗТ.1 - Ш.2 үүргийн хэрэгжилтийн тухай мэдээлэл тогтмол урсдаг байх	2	

Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны цахимжуулалтын бэлэн байдлын үнэлгээ

		ЗТ.1 - Ш.5	ЗТ.1 - Ш.2 үүрэг хэрэгжээгүй тохиолдолд хүлээх хариуцлага тодорхой байх	2	
		ЗТ.1 - Ш.6	Хэв шинжийг бүрдүүлэх шийдлүүдийг үйл ажиллагаандаа ашигладаг эсэх	2	
ЗТ.2	Нэгдмэл зорилгыг дэд зорилгуудад задалж томъёолсон байх ёстой.	ЗТ.2 - Ш.1	Нэгдмэл зорилгыг дэд зорилгуудад задалж томъёолсон байх ёстой хэв шинжийг дүрэм, журамд тусгасан байх	2	12
		ЗТ.2 - Ш.2	Нэгдмэл зорилгыг дэд зорилгуудад задалж батлах үүргийг тодорхой этгээдэд хүлээлгэсэн байх /алсын хараа, дунд хугацааны зорилго/	2	
